

## **ГУРАВ. ХОХИРЛЫН САНГИЙН ТУХАЙ ГАДААД ОРНУУДЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

|                        |  |
|------------------------|--|
| Судалгааг удирдсан:    | Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,<br>Хууль зүйн ухааны доктор Х.Эрдэм-Ундрах                                   |
| Судалгааг хянасан:     | Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн<br>Эрдэмтэн нарийн бичгийн дарга<br>Хууль зүйн ухааны доктор С.Сүхбаатар              |
| Судалгааг гүйцэтгэсэн: | Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн<br>Эрдэм шинжилгээний ажилтан З.Мөнгөлжин<br>Эрдэм шинжилгээний ажилтан Г.Сувд-Эрдэнэ |



## ХУРААНГУЙ

Монгол Улсад хийгдэж байгаа эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яамны хохирогчдын эрх ашгийг хамгаалах бодлого, шийдвэртэй уялдуулан, Монгол Улсад хохирлын сангийн эрх зүйн орчныг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор энэхүү харьцуулсан судалгааг хийв.

Судалгааны тайлангийн Нэгдүгээр бүлэгт төрөөс нөхөн олговор олгох тухай олон улсын болон Монгол Улсын эрх зүйн зохицуулалт, үзэл баримтлал, практик, нөхөн олговрын зарим асуудал, Хоёрдугаар бүлэгт гадаадын зарим улс орны хохирогчдод төрөөс нөхөн төлбөр олгох эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлав. Үүний хүрээнд хохирлын сангийн олон улсын чиг хандлагыг судлах зорилгоор Япон улс, БНСУ, БНКУ, ХБНГУ, Норвегийн хант улс, Шведийн хант улсуудыг сонгон авч, хохирлын сангийн үзэл баримтлалыг судлахын зэрэгцээ, гадны зарим улсын хохирлын сангийн тухай хуулийг хэсэгчлэн орчуулан, эрх зүйн зохицуулалтыг хэрхэн тусгасныг онцлов. Иймд хохирлын сангийн эрх зүйн зохицуулалт, нөхөн төлбөрийг барагдуулах олон улсын эрх зүйн орчинг нарийвчлан авч судалсны үндсэн дээр Монгол Улсын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох санал дэвшүүлэхийг зорив.

## УДИРТГАЛ

НҮБ-с баталсан “Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал”, “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”, “Монгол Улсын Үндсэн хууль” болон бусад хууль тогтоомжуудад хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөний улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, сэргээн эдлүүлэх үүргийг төр иргэнийхээ өмнө хуулиар хүлээсэн байдаг. Тухайлбал, НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1985 оны 40/34 дүгээр тогтоолоор «Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай тунхаглал» батлагдсан нь дэлхийн улс орнуудын өөр өөрсдийн онцлогт тохирсон хохирогчид нөхөн олговрын бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх эрх зүйн гол үндэслэл болсон байна. Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт “бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ... эрхтэй”, Арван есдүгээр зүйлд “төр хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцах” хэмээн төрийн хариуцлагын механизмыг хуульчлан тогтоосон байна.

Гэвч гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх, учирсан хохирлыг арилгуулах талаарх заалтууд хангалтай мэт боловч эдгээр нь зөвхөн тунхаглалын шинжтэй төдийгүй хэрэгжих механизм нь тодорхой бус байна. НҮБ-ын хүний эрхийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ, санал зөвлөмжид хохирогчдын эрх ашгийг хамгаалах, нөхөн олговрыг төрөөс барагдуулдаг тогтолцоо Монгол Улсад хангалтгүй гэж үзэн, боловсронгуй болгох зөвлөмжийг гаргасан байдаг<sup>1</sup>. Гэмт хэргийн хохирлыг шударгаар барагдуулах нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх төдийгүй, нийгмийн эмзэг бүлгийн хохирогчдын эрхийг хамгаалахад чухал ач холбогдолтой юм. Иймд төрийн зүгээс иргэдийнхээ зөрчигдсөн эрхийг хамгаалах механизмын нэг хэлбэр болох гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах, нөхөн төлбөр олгох үндэсний тогтолцоо, эрх зүйн зохицуулалтын түвшинг тодорхойлох, гадаадын сайн туршлагыг судлах шаардлага тулгараад байна.

Уг судалгаанд олон улсын хүний эрхийн гэрээ конвенц, НҮБ-ын тунхаглал зарчмуудыг үндэс болгон Монгол Улсад хүний эрх, түүний дотроос гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлүүлэлтийн байдал, төрөөс нөхөн төлбөр авах боломж бололцоо, эрх зүйн зохицуулалтынцар хүрээ гэх мэтчлэн олон асуудалд хариулт өгөхийг зорьсон болно. Иймд хохирлын сангийн тухай хуулийн төслийг боловсронгуй болгож, төр үндсэн хуулиар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх, хохирогчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор төрөөс хохирол барагдуулах боловсронгуй тогтолцоо бий болгох шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрч, үүнийг хэрэгжүүлэх саналыг боловсрууллаа.

### Судалгааны зорилго, зорилт

Судалгааг гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор хийсэн бөгөөд энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан. Үүнд:

- Монгол Улсын нэгдэн орсон гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн төлүүлэх тухай олон улсын гэрээ конвенц, олон улсад хүлээсэн үүргийг тодорхойлох;

1 НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт, хэлэлцүүлэг (UPR), 2014 оны 9 дүгээр сар,

- Монгол Улсад гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах, нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, олон улсын хууль тогтоомжийн уялдаа холбоог тодорхойлох;
- Үндэсний хэмжээнд хохирлыг нөхөн төлүүлж буй статистик, тоо баримтыг судлах;
- Эрх зүйн тогтолцоо, эдийн засаг, нийгмийн хөгжлийн түвшин, хүний эрхийн хэрэгжилтийг харгалзан Хохирлын сангийн тухай гадаадын зарим орны хууль тогтоомж, туршлага, жишгийг харьцуулан судлах;
- Судалгааны үр дүнг зөвхөн тогтоогдсон баримтад үндэслэн бодитой гаргах;
- Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хохирогчдын эрх ашгийг баталгаатай хангаж хамгаалахуйц эрх зүйн орчин бүрдүүлэх боломжийг харьцуулалтын аргаар судалж, дотоодын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох арга замыг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх санал, зөвлөмж боловсруулж, хохирлын сангийн тухай ямар зохицуулалт, хэм хэмжээ, практикт нутагшуулах талаарх санал дэвшүүлэхэд судалгааны зорилго оршино.

### **Судалгааны ажлын үндэслэл шаардлага**

НҮБ-ын санал зөвлөмж болон бусад судалгааны тайланд Монгол Улс нь Үндсэн Хуулиар болон олон улсад хүлээсэн үүрэг болох хохирогчдыг хамгаалах, хохирлыг нөхөн барагдуулах тогтолцоог боловсронгуй болгох, шаардлагатай арга хэмжээг авах талаар маш тодорхой байдлаар дурдсан байдаг бөгөөд төрөөс нөхөн олговор олгож буй механизм, арга хэлбэр хангалтгүй гэж дүгнэсэн байна<sup>2</sup>. Иймд хууль эрх зүйн орчин, нөхөн олговрын хэрэгжилтийн төлөв байдлыг тодорхойлж, гадаад улс орнуудын хууль тогтоомж, практикийг судалж улмаар манай оронд ямар зохицуулалт, хэм хэмжээ, практик нутагшуулах талаар санал зөвлөмж гаргах нь өндөр ач холбогдолтой гэж үзсэн.

### **Судалгааны ач холбогдол**

Төр иргэнийхээ өмнө хүлээх хариуцлагыг Үндсэн хуулиараа баталгаажуулсан байх ба Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн эрх зүйт төрийг төлөвшүүлэх, хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн дээдлэх зорилгоор бусдын хууль бус үйлдлийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой асуудлыг хөндөх нь өндөр ач холбогдолтой байна. Манай улсад 2012 оноос эхэлсэн эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн үндсэн чиглэлийн нэг нь хохирогчийг хамгаалах, хохирол барагдуулалтыг шинэ шатанд гаргах явдал билээ. Гэмт хэргийн хохирол, хор уршгийг шударгаар барагдуулж, нөхөн төлүүлэх нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх төдийгүй нийгмийн эмзэг бүлгийн хохирогчдын эрхийг хамгаалах, гэмт хэрэгтэй үр нөлөөтэй тэмцэхэд чухал нөлөөтэй. Иймд төр тодорхой нөхцөлд хохирлыг барагдуулах ажилд дэмжлэг үзүүлж, хохирлын сангийн эрх зүйн орчинг сайжруулах нь хохирогчийн хууль ёсны эрх ашиг, Эрүүгийн хууль, ЭХХШТХ-ийн үзэл баримтлалтай нягт холбоотой учир Монгол Улсын эрх зүйн тогтолцоонд чухал юм. Хохирлын сангийн хууль эрх зүйн орчин нь гэмт хэргийн хохирогчийн эрх ашгийг хамгаалах, үндсэн суурь болох учиртай. Иймд Монгол Улсын Үндсэн хуулиар

2 НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт, хэлэлцүүлэг (UPR), 2014 оны 9 дүгээр сар, Хүний эрхийн Үндэсний Комиссын 2019 оны тайлангийн хэсэг “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын хэрэгжилт”.

хамгаалагдсан хүний суурь эрх, халдашгүй байдлыг илүү баталгаажуулсан, олон улсын нийтийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагад нийцүүлсэн, илүү боловсронгуй, олон талт хохирлыг нөхөн барагдуулах шаардлага тулгараад байна. Хохирол барагдуулах тогтолцоог сайжруулах үүднээс, хохирлын сангийн холбогдох хууль, тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг нарийвчлан тодорхойлох, улмаар энэ асуудалд судлаачдын анхаарлыг хандуулахад оршино.

### **Судалгааны арга зүй**

Судалгааг аливаа улс төрийн байгууллага, албан тушаалтны бодлого, нөлөөллөөс ангид бие даасан байдлаар, шинжлэх ухааны арга зүйг баримтлан, судалгааны дүгнэлтийг зөвхөн тухайн судалгаагаар тогтоогдсон үр дүнд үндэслэн бодитой гаргах зарчмыг удирдлага болгон сэдвийн хүрээнд хууль зүйн эх сурвалж болох баримт бичгийн задлан шинжилгээ хийсэн болно. Дээрх судалгааны ажлаар хууль зүйн шинжлэх ухааны үндсэн аргууд болох норматив аргаар хэм хэмжээнүүдийг логик зарчмын үүднээс авч үзэж, тухайн асуудлыг илүү оновчтой авч үзэх үүднээс харьцуулалтын арга, нийгмийн асуудлыг тодорхой болгох үүднээс анализ, синтезийн арга, мөн тухайн харилцааг зохицуулж байгаа эрх зүйн зохицуулалт тэдгээрийн ойлголтыг системтэйгээр судлах үүднээс системчлэх аргыг хэрэглэсэн болно.

Тоон судалгааны хүрээнд 2017 оноос Эрүүгийн хуулийн шинэ хууль хэрэгжиж эхэлснээс хойш гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлыг тодруулах, түүнд дүн шинжилгээ хийхийн тулд статистик мэдээллийн үндсэн сангаас гаргасан албан ёсны тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийв. Тэрчлэн, хохирлын сангийн зохицуулалт хэрхэн хэрэгждэг талаарх гадаад улсын туршлага, эрх зүйн орчныг харьцуулан судаллаа. Харьцуулан судлах хүрээнд Азийн орнуудаас манай улстай хамтын ажиллагааны цар хүрээ өргөн, эрүүгийн эрх зүйн хөгжил өндөр улс орнууд болох Япон, Солонгос, БНКУ-ыг тус тус сонгож авсан болно. Харин хохирлын сангийн хуулийн тогтолцоог хамгийн эрт нутагшуулсан, боловсронгуй болгож чадсан болохын хувьд Европын орнуудаас ХБНГУ, Норвеги, Швед зэрэг орнуудыг сонгож, хохирлын сангийн тухай холбогдох хууль тогтоомжуудыг судлав. Харьцуулалтын арга зүйн хувьд зарим гадаад улсын эрх зүйн зохицуулалтыг тодорхойлж буй байдал, хэрэгжилтийг Монгол улсын хууль тогтоомжтой харьцуулан судалж дүгнэнэ.

### **Судалгааны хүрээ**

Төрөөс хохирлыг ямар тохиолдолд барагдуулж нөхөн төлбөр олгох тухай олон улсын зарчмыг судлахаас гадна, Монгол Улсад мөрдөгдөж буй холбогдох хууль тогтоомж, тэр дундаа гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлүүлэлтийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийнэ. Улмаар гадаадын зарим улсын туршлага, хохирлын сангийн тухай эрх зүйн зохицуулалтыг харьцуулан, зарим онцлог зохицуулалтыг түүвэрлэн судаллаа.

### **Судлагдсан байдлын тойм**

Хохирогчийн эрхийн асуудал нь хүний эрхийн асуудал бөгөөд Монгол Улсад хохирогчийн эрхийг хамгаалах, хууль эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр төрийн бус байгууллагуудаас хийсэн хорь гаруй судалгаа байна. Гэвч эдгээр судалгаануудад хохирогчийн эрхийг хамгаалах хууль эрх зүйн орчинг сайжруулах чиглэлд илүү анхаарчээ. Тухайлбал, Нээлттэй Нийгэм Форум (ННФ), болон Монгол улсын криминологчдын холбоо хамтран гэмт хэргийн хохирогчийн нийтлэг дүр төрхийг тодорхойлох зорилгоор "Гэмт хэргийн хохирогч", "Гэмт хэргийн хохирогчийн эрхийн

хамгаалалтын байдал” “Хохирлын тогтолцоо” зэрэг цуврал судалгаануудыг явуулсан байна. Энэ нь ихэнхи тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад учирсан хохирлын нөхөн төлүүлэлтийн байдлыг шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээнд тулгуурлан хийсэн байх бөгөөд Монгол улсын холбогдох хууль тогтоомж болон түүний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхэд чиглэгджээ. Эдгээр судалгаануудад гэмт хэргийн хохирогчийн эрхийн хамгаалалт, хохирогчийн эрхийн хэрэгжилтийн талаарх хохирогчийн сэтгэл ханамж, хохирогчид үзүүлж байгаа тусламж үйлчилгээ, хохирогчид тулгарч буй бэрхшээл болон хохирлыг гэмт этгээдээс нөхөн барагдуулж байгаа байдлыг судалж, цаашид хохирогчийн эрх зүйн хамгаалалтыг боловсронгуй болгох арга замыг тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл, хохирлын тогтолцоо, хохирогчийн эрхийг хамгаалах зэрэг бодлогын судалгаанууд ихэнхи тохиолдолд хийгдсэн байна. Харин гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн олгож буй үндэсний хохирлын сангийн тухай нарийвчилсан судалгаа байхгүй байна. Иймд энэхүү судалгаа нь сэдвийн хүрээнд анхдагч судалгаа гэж үзэж болох юм.

## НЭГ. ЭРХ ЗҮЙН ОРЧИН

### 1.1. Олон улсын эрх зүйн зохицуулалт

Олон улсын эрх зүйд хохирогчийн эрх ашгийг хамгаалах тухай хэд хэдэн хэм хэмжээ бий бөгөөд тэрхүү хэм хэмжээ нь хохирлыг төрөөс нөхөн төлүүлэх талаарх үндэсний зохицуулалт, хэрэгжилтийг боловсронгуй болгох шаардлагыг тодорхойлоход нэн тэргүүний ач холбогдолтой юм.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал нь олон улсын харилцаанд хүний эрхийг хамгаалах үйл ажиллагааны гол үндсэн эх сурвалж болохын хувьд НҮБ-ын Ассемблейн 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 217/A/III/ тогтоолоор “Хүн төрөлхтний гэр бүлийн бүх гишүүд угаас заяасан нэр төр болон тэдний тэгш салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрх чөлөө, шударга ёс бүх нийтийн энх тайвны үндэс мөнхийг иш үндэс болгон” батлан зарласан түүхтэй<sup>3</sup>. Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 8 дугаар зүйлд, “Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон үндсэн эрх нь зөрчигдвөл хүн бүр үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй” гэж суурь зохицуулалтыг заасан. Мөн НҮБ-ын Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад “Төр иргэнийхээ эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг нь сэргээх үүргийг хариуцах” гэж заасан байна<sup>4</sup>.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1985 оны 40/34 дүгээр тогтоолоор баталсан «Эрх мэдлээ урвуулан ашигласан болон гэмт хэргийн хохирогчдын талаарх үндсэн зарчмын тухай тунхаглал» батлагдсан нь дэлхийн улс орнуудад өөр өөрсдийн онцлогт тохирсон хохирогчийн эрх ашгийг хамгаалах бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх эрх зүйн гол үндэслэл болсон байна<sup>5</sup>. Тус тунхаглалын 3.3-т “төрийн албан тушаалтан болон төрийг төлөөлж албан үүрэг гүйцэтгэж буй этгээд үндэснийхээ хууль тогтоомжийг зөрчиж, эрх мэдлээ урвуулан болон хэтрүүлэн ашигласан бол хохирогч төрөөс нөхөн төлбөр авах эрхтэй. Тухайн хохирлыг хариуцах Засгийн газар нь өөрчлөгдсөн тохиолдолд тухайн асуудлыг хариуцах байгууллага хохирлыг

3 НҮБ-ын Ассемблейн 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 217/A/III/ тогтоол

4 Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт. 1966 он

5 Эрх мэдлээ урвуулан ашигласан болон гэмт хэргийн хохирогчдын талаарх үндсэн зарчмын тухай тунхаглал. Declaration of Basic Principles of Justice for Victims of Crime and Abuse of Power <http://www.un.org/documents/ga/res/40/a40r034.htm>, 1985.

барагдуулна”<sup>6</sup> хэмээн мөн төрийн буруутай үйл ажиллагаанаас учирсан хохирлыг иргэд нэхэмжлэх эрхийг баталгаажуулж, төр хохирлыг барагдуулах хариуцлагын механизмыг тунхагласан байна.

Мөн тус тогтоолын хавсралт болох “Гэмт хэрэг, хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах үндсэн зарчим”-ын 14-17 дахь хэсэгт хохирогчид үзүүлэх тусламцааны асуудлыг дараах байдлаар тусгасан.<sup>7</sup> Үүнд:

- “Хохирогч нь эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний хүртээмжийн болон бусад тусламжийн талаар мэдээлэл авах, тэдгээр үйлчилгээ, тусламжийг хүртэх ёстой.”
- “Хохирогчид тусламж үзүүлэх, үйлчлэхдээ тийнхүү учирсан хохирлын шинж байдалд тохируулахад анхаарал хандуулах хэрэгтэй”

хэмээн тус тус заасан нь төр иргэдийнхээ өмнө хохирлыг үнэлэх, нөхөн барагдуулах бодлого баримтлахаас гадна, тэр талаар нийтэд сурталчлан таниулж, хохирогчдын мэдээлэл авах эрхийг нь хангах ёстой талаар чиглэл өгсөн гэж үзэхээр байна<sup>8</sup>.

НҮБ-аас 2005 онд баталсан “Олон улсын хүний эрхийн эрх зүйн их хэмжээний зөрчил, хүмүүнлэгийн эрх зүйн ноцтой зөрчлийн улмаас хохирсон этгээдийн хохирлоо нөхөн төлүүлэх эрхийн талаарх үндсэн зарчмууд”-д зааснаар буруутай этгээд нь хохирогч, түүний гэр бүл, асрамжинд байсан хүмүүст учруулсан хохирлыг шударгаар арилгах, хохирлоо нөхөн төлүүлэх эрхийг баталгаажуулах, төрөөс хохирогчийн бие махбод, сэтгэл санаа, зан суртахуунд учирсан хохирол, ажил хөдөлмөр, сургууль боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээ зэрэг алдагдсан нөхцөл, бодит болон бий болох орлого, хууль зүй, сэтгэл зүй, эмнэлэг, нийгмийн үйлчилгээний зардлыг бүрэн, шуурхай барагдуулах нөхцөл бололцоогоор хангах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэхийг оролцогч улсуудад зөвлөхийн зэрэгцээ хэрэгжүүлж ажиллахыг шаарддаг<sup>9</sup>. Хэрвээ гэмт этгээдээс буюу бусад эх үүсвэрээс хохирлыг арилгах боломжгүй тохиолдолд төрөөс наад зах нь:

а/ Хүнд төрлийн гэмт хэргийн улмаас бие махбодын хүнд гэмтэл авсан, бие буюу сэтгэцийн эрүүл мэнд нь алдагдсан

б/ Дээрх төрлийн хохирлоос шалтгаалан сэтгэцийн өвчтэй буюу тахир дутуу болсон эсвэл нас барсан хохирогчийн гэр бүл, түүний дотор тэжээгчээ алдсан хүмүүст нөхөн олговор олговол зохино гэж зөвлөсөн байна<sup>10</sup>.

---

6 Эрх мэдлээ урвуулан ашигласан болон гэмт хэргийн хохирогчдын талаарх үндсэн зарчмын тухай тунхаглал. Declaration of Basic Principles of Justice for Victims of Crime and Abuse of Power <http://www.un.org/documents/ga/res/40/a40r034.htm>, 1985.

7 Гэмт хэрэг, хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах үндсэн зарчим

8 Эрх мэдлээ урвуулан ашигласан болон гэмт хэргийн хохирогчдын талаарх үндсэн зарчмын тухай тунхаглал. 1985 он. Declaration of Basic Principles of Justice for Victims of Crime and Abuse of Power <http://www.un.org/documents/ga/res/40/a40r034.htm>

9 Олон улсын хүний эрхийн эрх зүйн их хэмжээний зөрчил, хүмүүнлэгийн эрх зүйн ноцтой зөрчлийн улмаас хохирсон этгээдийн хохирлоо нөхөн төлүүлэх эрхийн талаарх үндсэн зарчмууд, 2005 он.

10 Мөн тэнд.



Тиймээс, НҮБ-аас дээрх зарчим, стандартыг тогтоож өгөхдөө гэмт этгээд нь хохирогч, түүний гэр бүл буюу түүгээр тэжээлгэж буй хүмүүсийн хохирлыг шударгаар арилгах, гэмт хэргийн улмаас учирсан бие махбодын ба сэтгэцийн гэмтэл, сэтгэл зүйн хор уршиг, алдагдсан орлого, эмчилгээний төлбөр зэрэг тус тус эдийн бус зардлуудыг төрөөс нөхөн төлбөр авах замаар барагдуулах хандлагыг олон улсын түвшинд тогтоож өгсөн бөгөөд хохирогчдын зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэхийг оролцогч улсуудад зөвлөхийн зэрэгцээ хэрэгжүүлж ажиллахыг шаарддаг байна.

Эдгээр зарчмууд нь гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах, хохирогчийн эрхийг төрөөс сэргээхэд баримтлах олон улсын түвшинд тогтоосон үндсэн стандарт юм. Энэхүү зарчим нь хууль, олон улсын гэрээний хэм хэмжээний адил дагаж мөрдөх зайлшгүй шаардлагагүй боловч НҮБ-аас тогтоосон бусад норм, стандарттай адилтган үзэх боломжтойн зэрэгцээ уг зарчим нь гэмт хэргийн улмаас хохирсон этгээдийн эрхийг хангахад баримтлах үндсэн стандарт болж байгаа юм.<sup>11</sup> Иймд Монгол Улс нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эдгээр зарчим стандартуудыг дотоодын хууль тогтоомжтой хэрхэн уялдуулан, хэрэгжүүлж байгааг судлах, үнэлэлт дүгнэлт өгөх шаардлага тулгараад байна.

## **Монгол Улсын эрх зүйн орчин**

### **Монгол Улсын Үндсэн Хууль**

Монгол Улсын Үндсэн хуулийн 17 дугаар зүйлд “Монгол улсын иргэн, шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн дараахь үндсэн үүргийг ёсчлон биелүүлнэ:

- 1/ Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх;
- 2/ хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;

### **16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт**

“Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй” гэж хохирогчийн эрх ашгийг Үндсэн хуулиараа хамгаалан баталгаажуулсан байна.

### **19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт**

“Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”

хэмээн тус тус заасан нь иргэд өөрт учирсан хохирлоо шаардах, нөхөн төлүүлэх эрхийг тунхаглаж, шаардлагатай тохиолдолд төр хохирлыг барагдуулна гэсэн утгыг агуулж буй суурь зохицуулалтууд юм. Мөн Үндсэн хуулийн энэ заалтаар бусдын хууль бусаар учруулсан хохирлыг эдийн болон эдийн бус гэж хязгаарлаагүй тул энэ нь хохирсон этгээдэд өөрт учирсан эдийн бус хохирлоо нөхөн төлүүлэх эрхийг хамгаалсан зохицуулалт гэж үзэхээр байна<sup>12</sup>. Иймд төрийн хариуцлагын эрх зүйг Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 болон Арван зургадугаар зүйлийн 14-т шууд тусгагдсан гэж үзэж болох ба энэ онолын үзэл баримтлал нь эрх зүйт

11 Г.Оюунболд. Нөхөн сэргээх халдлагад суурилсан эрүүгийн эрх зүйн шинэчлэл, хохирол нөхөн барагдуулах үндэсний тогтолцоо бүрдүүлэх нь. Хууль дээдлэх ёс №1 (66) 2018

12 Нээлттэй нийгэм форум. 2021 ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ДӨЧИН ТАВДУГААР БҮЛГИЙН ХЭРЭГЖИЛТ - СУДАЛГААНЫ ТАЙЛАН

төрийн зарчмыг тусгасан.<sup>13</sup> Үндсэн хуульд тусгагдсан төрийн үүрэг, хариуцлагын тухай хэрхэн уялдаж байгааг нарийвчлан тогтоох нь төрийн хариуцлагын эрх зүйг хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай билээ<sup>14</sup>. Иймд төрийн зүгээс иргэний зөрчигдсөн эрхийг хамгаалах механизмын нэг хэлбэр болох төрийн сангаас хохирлыг зохих ёсоор барагдуулах тухай Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох заалтуудаар хэрхэн зохицуулсан байгааг харах нь зүйтэй.

### **Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль**

Төрийн хариуцлагын эрх зүйн ерөнхий зохицуулалтыг бусад хууль тогтоомж болон Үндсэн хуулийн зарчимтай уялдуулах, төрийн хариуцлагын механизмыг нэг цогц болгон иргэдэд хүргэх, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн барагдуулах болон зохицуулалттай холбон судалж, нэгдсэн системтэй ойлголтод хүрэх нь маш чухал ач холбогдолтой. Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг “гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон, шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршино” гэж тодорхойлсон<sup>15</sup>. Иймд хохирогчийн зөрчигдсөн эрхийг сэргээх нь тус хуулийн зорилттой салшгүй холбоотой юм. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлүүлэх эрх хангагдах эсэх нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бусдын амь нас, эрүүл мэнд, эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүнд, эд хөрөнгөд учруулсан хохирлын төрөл, хэмжээг зөв тогтоох, хохирлыг үнэлэх, барагдуулах, мөн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны явцад хохирлыг төлүүлэх зохицуулалтаас ихээхэн хамаарах юм.

ЭХХШТХ-ын 8.1 дүгээр зүйлд “Гэмт хэргийн улмаас амь нас эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг хохирогч гэнэ” гэж тодорхойлсон бөгөөд тус хуулийн 8.2 дугаар зүйлд хохирогчийн 15 эрхийг хуульчлан тодорхойлсноос хохирсон эрхээ сэргээх, хохирлоо нөхөн төлүүлэхтэй холбоотойгоор 1.9 дэх хэсэгт “хохирогч нь гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх хүсэлт гаргах...” эрхтэй гэж заасан байна. Ийнхүү хохирогч эрүүгийн хэрэг үүсгэхээс эхлэн тухайн гэмт хэрэг шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэх хүртэлх хугацаанд гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо төлүүлэх талаар хүсэлт гаргах эрхтэй талаар хуульчилжээ.

Мөн тус хуулийн 45.1-р зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд нь мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эрүүл мэнд, сэтгэл санааны үр дагаврыг арилгуулах болон тэтгэвэр, тэтгэмж авах, орон сууц эзэмших болон бусад эрхээ нөхөн сэргээлгэх эрхтэй” гэж заасан байна.

13 Б. Батболд, Гэмт хэргийн улмаас иргэний амь нас, эрүүл мэндэд учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулах талаарх үзэл баримтлал. Хууль дээдлэх ёс. №3, 2020

14 Б.Буянхишиг, Эрх зүйт төрийн зарчим нь төрийн хариуцлагын тогтолцоог сайжруулах, хөгжүүлэх үндэс болох тухай.

15 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг

Мөн 45.2-р зүйлийн 1 дэх хэсэгт “Хүнийг хууль бусаар ял шийтгэсэн, баривчилсан, цагдан хорьсон, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлсэн, эмнэлгийн байгууллагад байлгасан, албадан эмчлэх арга хэмжээ хэрэглэсэн, эрүүдэн шүүсний улмаас учирсан хохирлыг мөрдөгч, прокурор, шүүгчийн гэм бурууг үл харгалзан төр хариуцан арилгана.” хэмээн заасан нь төрөөс өөрт учирсан хохирлоо шаардах, нөхөн төлүүлэх эрхийг зохицуулж, улмаар уг эрхийг хангах үүргийг төрд хариуцуулсан байна. Иймд хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, мөрдөгч, прокурор шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас болон гэмт хэргийн улмаас иргэн, хуулийн этгээдэд учирсан хохирлыг төрөөс арилгах асуудлыг тодорхой зааж, хуульчилсан байна. Монгол улсын эрх зүйн хөгжилд зөвхөн сэжигтэн, яллагдагчийн эрхийн баталгааг өргөжүүлэх замаар хөгжиж ирсэн байна.

### **Иргэний хууль тогтоомж, түүнд хамаарах тайлбар**

Доктор (Ph.D) Ч. Нямсүрэн гэм хорыг арилгах, хохирлыг нөхөн төлөх нь агуулгын хувьд адил бөгөөд гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах арга замыг 1) хохирогчид учруулсан эдийн хохирлыг гэмт хэрэг үйлдсэн болон түүнийг хариуцвал зохих гуравдагч этгээдээс нөхөн сэргээлгэх буюу төлүүлэх; 2) гэмт хэрэг үйлдсэн этгээд нь тодорхойгүй, төлбөрийн чадваргүй бол төр болон даатгалын байгууллагаас нөхөн олговор олгох гэсэн хоёр үндсэн хэлбэртэй гэж тэмдэглэсэн байна.<sup>16</sup> Харин хууль тогтоогч ИХ-ын 228 дугаар зүйлд биет байдлаар нөхөн сэргээх боломжгүй тохиолдолд мөнгөөр нөхөн төлөх бүрэн боломжтой гэж үзсэн байна.<sup>17</sup>

ЭХХШТХ-ийн 45.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Эд хөрөнгийн бус хохирол, сэтгэл санаанд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу гаргана” гэж тус тус зохицуулсан. Улсын дээд шүүхийн 2009 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 15 дугаар тогтоолд “Гэмт хэргийн улмаас бусдын эрүүл мэндэд гэм хор учирсан бол гэм буруутай этгээд Иргэний хуулийн 505, 506 дугаар зүйлүүдэд зааснаар хохирогчийн эмчилгээний зардал, хөдөлмөрийн чадвар алдсанаас олох байсан орлогын хэмжээгээр хохирлыг нөхөн төлнө. Олох байсан орлогын хэмжээг авах байсан цалин, орлого авсан тэтгэвэр, тэтгэмжийн зөрүүгээр тооцох тул хөдөлмөрийн чадвар алдсан этгээдийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ ихсэх, багасах тохиолдолд гэм хор учруулсны төлбөр Иргэний хуулийн 507 дугаар зүйлд зааснаар өөрчлөгдөнө” гэж заасан байдаг. Дээрхи тайлбараас гэмт хэргийн улмаас бие эрхтэнд хохирол учирвал хохирогч нь эмчилгээний зардлаа гэм буруутай этгээдээр төлүүлж хөдөлмөрийн чадвараа алдсан хугацаанд олох байсан орлогоор хохирлын хэмжээ нь тодорхойлогдож байна. Иймд гэмт хэргийн улмаас учирсан хохирлын асуудлыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхдээ шүүх Иргэний хуулийн гэм хор учруулснаас үүсэх үүргийг зохицуулсан холбогдох зүйл, заалтыг баримтлан шийдвэрлэдэг байна.

Тухайлбал, Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.4 дэх хэсэгт “Хууль бусаар яллагдагчаар татагдсан, ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан буюу гадагш явахгүй гэсэн баталгаа өгсөн, захиргааны журмаар баривчлагдсан этгээдийн зөрчигдсэн эрхийг сэргээсэн тохиолдолд түүнд учирсан хохирлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор болон шүүгчийн буруутай эсэхээс үл хамааран төр хариуцан арилгана” гэж тус тус заасан байна. Иргэний хуулийн 498-р зүйлд

16 Ч. Нямсүрэн, Гэмт хэргийн виктимологи /хохирогч судлал/. Анхны хэвлэл. УБ., 2005-457-458 тал.

17 Иргэний хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ, 2002. №7.

төрийн хариуцлагын эрх зүйн маш чухал зохицуулалт байна. Иймд Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээгээр хүлээсэн хохирогчийн хохирлыг барагдуулах, эрхийг хамгаалах үндсэн шаардлагыг хуульд тодорхой хэмжээнд тусгажээ. Гэвч төрөөс нөхөн төлбөр олговол зохих эрх зүйн зохицуулалтын дийлэнхи нь төрийн албан хаагчийн хариуцлагатай холбоотой байгааг онцлох нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, Монгол улсын эрх зүйн хөгжилд зөвхөн сэжигтэн, яллагдагчийн эрхийн баталгааг өргөжүүлэх замаар хөгжиж ирсэн байна.

### **Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хууль**

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай<sup>18</sup> хуулиар хилс хэрэгт шийтгүүлсэн хэлмэгдэгчид нөхөн олговор олгохоор зааж, цаазаар авах ял шийтгүүлсэн хэлмэгдэгчийн гэр бүлийн гишүүдэд болон хорих ялаар шийтгүүлсэн хэлмэгдэгчид, хэрэв хэлмэгдэгч нас барсан бол түүний гэр бүлийн гишүүдэд 1,000,000, бусад хэлмэгдэгчид 500,000 төгрөгийн нэг удаагийн нөхөн олговор тус тус олгохоор шийдвэрлэжээ. Хилс хэрэгт шийтгүүлж цаазаар авахуулсан, хоригдон мөрдөгдөж, ялаа эдэлж байхдаа нас барсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон хүмүүсийн амь нас, эрүүл мэндэд учруулсан гэмтэл согог болон сэтгэл санааны шаналалд үнэлэмж тогтоох гэсэн оролдлогыг төр хийгээгүй. Харин зөвхөн хэлбэрийн төдий, иргэдийнхээ эсрэг хоморголон үйлдсэн гэмт хэргийнхээ төлөө төр уучлал эрж, энэ мэт бусармаг үйл ажиллагаа түүхэнд дахин давтагдан гарахгүй байх нийгэм, улс төр, хууль зүйн дархлаа бий болгох зорилготой тунхаглалын шинжтэй болсон гэж судлаачид үздэг<sup>19</sup>.

### **Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай хууль**

Монгол Улсад эд хөрөнгийн хохирлыг төрөөс мөн барагдуулахаар Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай хуулиар зохицуулсан байна. Тухайлбал, Банк хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын албаны мэдээллээс үзэхэд шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн нийт 26 хадгаламж зээлийн хоршоодод холбогдох 8301 хохирогчтой 72,4 тэрбум төгрөгийн төлбөртэй гүйцэтгэх баримт бичигт “Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай” хууль болон бусад хууль эрх зүйн актуудын хүрээнд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулан ажиллаж ирсэн байна. “Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай” хуулийн дагуу улсын төсвөөс нийт 36,1 тэрбум төгрөгийг хүлээн авч, 26 хадгаламж зээлийн хоршооны 7731 хохирогчтой зохих гэрээг байгуулан 35.8 тэрбум төгрөгийг олгож эргэн төлөгдөх нөхцөлөөр хохирлын мөнгө олгох ажил 99.2%-тай байна гэсэн мэдээлэл байна. Түүнчлэн тус алба нь шүүхийн шийтгэх тогтоол түүний хавсралтанд заасан, мөрдөн байцаалт болон шүүхийн шатанд битүүмжлэгдсэн 29,2 тэрбум төгрөгийн үнэлгээтэй 69.380 ширхэг эд хөрөнгө буюу нийт хохирлын дүнгийн 40 хувьтай тэнцэх хөрөнгө хүлээн авчээ<sup>20</sup>.

18 1998 оны 1 дүгээр сарын 2-ны өдөр баталсан.

19 Нээлттэй нийгэм форум, (2021). Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дөчин тавдугаар бүлгийн хэрэгжилт, Судалгааны тайлан, ISBN: 978-9919-9742-7-5.

20 Хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын албаны тайлан, 2013 он. Хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажиллагаа, тулгамдсан асуудал, 2013 он



Иймд Монгол Улсын төрөөс нөхөн олговор олгох эрх зүйн орчин нь хохирлын төрлөөс хамааран хууль тогтоомжоор ялгамжтай зохицуулсан байна. Тухайлбал, эд хөрөнгийн хохирол болон эд хөрөнгийн бус хохирлын төрлөөс хамааран хохирлын хэмжээ, нөхөн олговрын барагдуулах зохицуулалт нь өөр хоорондоо ялгаатай байна.

### Засгийн газрын тусгай сангийн тухай хууль

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1985 оны 40/34 дүгээр тогтоолоор баталсан «Эрх мэдлээ урвуулан ашигласан болон гэмт хэргийн хохирогчдын талаарх үндсэн зарчмын тухай тунхаглал»-д тулгуурлан Монгол улсын Их Хурлын 2003 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 41 дүгээр тогтоолоор “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийг баталсан байдаг. Энэхүү хөтөлбөрийн хоёрдугаар бүлгийн 2.1.5-д:

- Зохих сан бий болгох, иргэдийг гэмт халдлагаас хамгаалах даатгалд хамруулах эдгээр гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эх үүсвэрийг бүрдүүлж, эхний ээлжид хариуцагч нь тодорхойгүй, эсхүл төлбөрийн чадваргүй иргэдийн хохирлыг төр урьдчилан төлж хариуцагчаар нөхөн төлүүлэх журмыг хуулиар тогтоон хэрэгжүүлж цаашид боловсронгуй болгоно.
- Гэмт этгээдийн үйлдсэн хэргийн улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх нөхцөлийг бий болгох үүднээс хоригдлыг ажлаар хангах, тэдний хийж гүйцэтгэсэн ажлын хөлсийг ижил төрөл, хэмжээний ердийн ажил, үйлчилгээний хөлс, үнэлгээний дунджаас багагүй байхаар тогтоохын зэрэгцээ тэдэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ гэж заасан.

Гэрч хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөрийн 5.1.2-р зүйлд Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн журмыг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуультай уялдуулан боловсронгуй болгох гэж заасан байдаг<sup>21</sup>. Улмаар хуулийн түвшинд 2006 онд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг баталж хожим нь энэхүү хууль нь 2019 онд шинэчлэн батлагдсан байна.<sup>22</sup>

21 Гэрч хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр

22 Засгийн газрын тусгай сангийн тухай хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл. №48, 2019

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 2010 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан” шинээр нэмэгдэн хуулийн 213 дугаар зүйлийн 2-д Эрүүгийн хуулийн дараах зүйл, заалтад заасан гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг уг сангаас олгохоор хуульчилжээ. Хуулийн хэрэгжилтийг хангах, гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох чиглэлээр Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 132 дугаар тогтоолын хавсралтаар баталсан «Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох журам»-ыг баримталдаг. Энэ журам нь гэмт хэргийн улмаас амь насаа алдсан хүний гэр бүлийн гишүүн, хүнд гэмтэл учирсан хохирогчдод нөхөн төлбөр олгохтой холбогдсон харилцааг зохицуулдаг.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 213 дугаар зүйлийн 2-д заасны дагуу “Сангийн хөрөнгийг Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн, Эрүүгийн хуульд заасан зарим гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, хүнд гэмтэл учирсан хохирогчид нөхөн төлбөр олгоход зарцуулна” гэж заасан байна. Уг журамд зааснаар Эрүүгийн хуульд заасан 21 төрлийн гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгохоор зохицуулсан. Улмаар гэмт хэргийн улмаас хохирсон хохирогч болон түүний хууль ёсны төлөөлөгчид оршуулгын болон эмчилгээний зардал, хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын нөхөн төлбөрийг сангаас олгож байгаа ба нөхөн төлбөрийн хэмжээг хохирогч нас барсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30 дахин нэмэгдүүлсэнтэй, хохирогчийн бие махбодид хүнд гэмтэл учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээнээс ихгүй байхаар тогтоосон байна.

2019 онд Ерөнхий сайдын өгсөн чиглэлийн дагуу Засгийн газрын тусгай сангуудад шалгалт хийсэн байна<sup>23</sup>. Гэвч иргэд үүнийг мэддэггүй учир төрөөс хохирол барагдуулах тогтолцоо харилцан адилгүй явагдаж, зөвхөн өргөдөл гаргасан иргэнд олгож иржээ. Гэмт хэргийн хохирогчид олгох нөхөн төлбөрийн хэмжээ нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тодорхойлогдох бөгөөд гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангаас хохирогчид олгосон нөхөн төлбөрийг шүүхийн шийтгэх тогтоолоор гэм буруутай болох нь тогтоогдсон этгээдээр санд буцаан төвлөрүүлэхээр хуульчилсан байдаг. Нөхөн төлбөр хүсэх өргөдлийн маягтыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас авах бөгөөд хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх тухай шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр болон гүйцэтгэх хуудсын хуулбар, өргөдөл гаргагч иргэний баримт бичгийн хуулбар, хохирлыг ялтан буюу түүний хууль ёсны төлөөлөгч барагдуулаагүй, эсвэл дутуу барагдуулсныг нотлох баримтыг хавсаргах ёстой. Энэ тохиолдолд гэмт этгээд тодорхойгүй, эсхүл цагаатгагдсан тохиолдолд төрөөс хохирлыг барагдуулах боломжгүй байдлаар хуульчлан зохицуулж, хохирогч хохирч үлдэх эрсдэлийг бий болгож байна. Хүний зөрчигдсөн эрхийг сэргээх асуудал нь эрх зүйн харилцаанд юу юунаас илүү чухал зүйл билээ. Гэвч гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо барагдуулж, хор уршгаа нөхөн төлүүлж чадахгүй байгаа нөхцөл хэвээр байна. Гэмт хэргийн улмаас хүний амь бие, эрүүл мэндэд хохирол учирч түүнийг нөхөн барагдуулахад шударга ёсны зарчмыг баримтлах учиртай. Шударга ёсны мөн чанар нь нийгмийн харилцаанд оролцогчид эрх тэгш байх явдлаар илэрдэг. Гэвч гэмт хэргийн улмаас нөхөн төлбөр авах сангаас хохирогчид эрх тэгш байдлаар нөхөн төлбөрийг авч байгаа эсэх нь маш эргэлзээтэй байна. “Хохирогчид нөхөн төлбөр олгох үйл ажиллагаатай холбоотой маргаан үүссэн тохиолдолд уг маргааныг хянан шийдвэрлэх хүртэлх

23 [http://www.buzznews.mn/news/156/single/22277?fbclid=IwAR25oouf0C6uJR0Ck5uD1nHnneKujRMx2ZjJmatelyP0yW31VdUdA0n\\_xc](http://www.buzznews.mn/news/156/single/22277?fbclid=IwAR25oouf0C6uJR0Ck5uD1nHnneKujRMx2ZjJmatelyP0yW31VdUdA0n_xc)

хугацаанд тухайн хохиролтой холбоотой нөхөн төлбөр олгох ажлыг түдгэлзүүлнэ” гэж заасан боловч энэ талын хяналт, үнэлэлт дүгнэлт байхгүй байгаа тухай мөн судлаачид онцлон тэмдэглэсэн байна<sup>24</sup>.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс УИХ-д өргөн барьсан «Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 17 дахь илтгэл»-д хохирол нөхөн төлүүлэх эрхийн асуудлыг нэг бүлэг сэдэв болгон хөндөж, тус эрхийн хэрэгжилттэй холбоотой 4 саналыг хүргүүлээд байгаагийн нэг нь Төр хариуцах төлбөрийн тухайн жилд шаардагдах зардлыг улсын төсөвт тусгах, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу төрийн байгууллага, албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан хохирлыг тухай бүрт нь олгодог байх зэрэг саналуудыг хүргүүлж байгаа ч холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт, шинэчлэлт хангалтгүй явагдаж байна.<sup>25</sup> Энэ бүхнээс гэмт хэргийн хохирогчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор төрөөс хохирол, хор уршигийг барагдуулдаг үндэсний тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрлээ. Иймд гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулах эрх зүйн зохицуулалт, практик дутмаг байгаа тул гадаад улсын хууль тогтоомж, олон улсын чиг хандлага, туршлагыг судлахыг зорилоо.

## **ХОЁР. ГАДААД ОРНУУДЫН ЭРХ ЗҮЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

### **Хохирлын сангийн тухай онол, үзэл баримтлал**

Хууль зүйн ном зохиол, шүүхийн практикт “хохирол”, “нөхөн төлбөр” гэсэн нэр томъёог хэрэглэдэг. Зарим тохиолдолд хохирол барагдуулах нөхөн төлбөр барагдуулах зэрэг адил утгаар хэрэглэх, ойлгох тохиолдол байгаа тул эдгээр нэр томъёонууд болох “Хохирол”, “нөхөн төлбөр” гэсэн 2 үгийн ялгааг юун түрүүнд зааглах нь зүйтэй. “Нөхөн төлбөр”, “хохирол” гэсэн нэр томъёо нь хоорондоо яг нийцдэггүй.

Гэм хор нь нэлээд өргөн хүрээтэй ухагдахуун бөгөөд эд хөрөнгийн эрхийн ба эд хөрөнгийн бус гэж хуваагдана. Эд хөрөнгийн гэм хорын мөнгөн үнэлгээг хохирол гэж нэрлэнэ<sup>26</sup> хэмээн үздэг. Хохирлын гол шинж нь тооцож хэмжиж болохуйц байдаг. Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Г.Совд “Гэмт хэргийн хор уршиг гэдэг бол тухайн үйлдэл, эс үйлдэхүйгээс нийгмийн харилцаанд учруулсан хохирол бөгөөд тэр нь материалын, оюун санааны, улс төрийн, ёс суртахууны зэрэг олон хэлбэртэй байж болохоос гадна тодорхой гэмт хэргийн бүрэлдэхүүний зөрчлийн онцлогтой уялдаж их хэмжээний; ноцтой; үлэмжхэн; бага бус; хүнд; хүндэвтэр; хөнгөн гэх мэт олон хэлбэртэй байж болох” тухай бичжээ.<sup>27</sup> Ингэснээр хор уршиг хохирлыг адил гэж үзсэн байна.

24 Монгол Улсын Сангийн яам. “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан”- гийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүнгийн талаар’ [https://mof.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/6\\_](https://mof.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/6_), 2018

25 Монгол Улсын хүний эрхийн үндэсний комисс, Хохирол нөхөн төлүүлэх эрхийн хэрэгжилтийн зарим асуудал» сэдвээр өглөөний уулзалт зохион байгууллаа. <https://nhrcm.gov.mn/> 2018

26 С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг (УБ, 2007), Адмон хэвлэл, 138 дахь тал.

27 Г.Совд, Эрүүгийн хуулийн тайлбар, УБ.,(2002) 25 дахь тал.

Хохирол гэдэгт аливаа этгээдийн үнэт зүйлс нь түүний хүсэл зоригийн эсрэг устсан, дордсон, муудсан явдлыг ойлгож болно.<sup>28</sup> Доктор Б.Бат-Эрдэнэ гэмт хэргийн хохирлыг; нэр төр, алдар хүнд, санаа сэтгэлийн; бие махбодийн; эд хөрөнгийн; гэж ангилан авч үзсэн байдаг.<sup>29</sup> Харин академич С.Нарангэрэл “Эрх зүйн толь бичиг” бүтээлдээ “Хохирол” гэдэг нь “.. нэг этгээдийн хууль зөрчсөн үйлдлээр нөгөөд учруулсан мөнгөн хэлбэрээр илэрхийлэгдэх зүйл. Үүнд хэн нэгэн этгээдийн эрх зөрчигдсөнөөс түүнийг сэргээн тогтооход гаргах ёстой зардал, тэрчлэн түүний эд хөрөнгийг алга болгосон ба гэмтээсэн бодит зардал, олох ёстой байсан орлого” гэж тодорхойлжээ.

Харин нөхөн олговор нь хохирол барагдуулах нэг арга хэлбэр бөгөөд Эмануэла Кьяра Гийар хохирлыг барагдуулах нь практикийн хувьд чухал ач холбогдолтой гэж үзээд хохирол арилгах гурван хэлбэртэй гэсэн байна<sup>30</sup>.

- Нөхөн сэргээх (restitution)
- Нөхөн төлбөр (compensation)
- Уучлал гуйх (satisfaction)

Эдгээр 3 төрлийн хохирол арилгах хэлбэр нь өөр өөрсдийн онцлог, агуулгатай байна. Академич С.Нарангэрэл Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг бүтээлдээ “нөхөн олговор”-ыг “нөхөн төлбөр”-тэй адилхан утга агуулгатай гэж үзсэн байна. Нөхөн олговор гэдэг (compensation) нь “хуульд үндэслэн эсхүл хуулийн дагуу иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг төрөөс арилгах арга хэмжээ” хэмээн тодорхойлжээ. Тухайлбал, “нөхөн төлбөр” нь хууль бус үйлдлийн үр дүнд учирсан хохирлыг мөнгөн хэлбэрээр барагдуулах явдал бөгөөд нөхөн төлбөрийг материаллаг болон сэтгэл санааны хохирлыг нөхөн олгож болдог бөгөөд гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах нь гэмт хэргийг үр дагаврыг устгах эрүүгийн эрх зүйн чухал элемент гэж Доктор Б.Батболд үзсэн байна<sup>31</sup>. Иймд зорилго, зохицуулалтын онцлог, ямар харилцааг зохицуулж байгаагаас хамааран нэр томъёог зөв зохистой, зөв утгаар нь хэрэглэх нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах хууль тогтоомжийг боловсруулахдаа “нөхөн төлбөр” гэсэн нэр томъёог хэрэглэх нь зүйтэй юм. Тодруулбал, “Хохирлын сан” гэж нэрлэх бус харин “Нөхөн төлбөрийн сан” гэж нэрлэх нь зүйтэй байж болох юм.

Олон улсын жишгээс үзэхэд гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлүүлэхтэй холбоотой хууль тогтоомжуудыг “Crime victim aid”, “Crime victim relief fund”, “Crime victims benefit payment law” гэх зэрэг хохирогчдод үзүүлэх “тусламж” гэдэг утгаар нь нэрлэсэн байгаа бол, нөгөөтэйгүүр “Victim compensation act”, “Law on crime victims fund”, “Violence victims compensation act” гэх зэрэг хохирогчдын “нөхөн төлбөр” (compensation) гэсэн шууд утгаар нэрлэж буй чиг хандлага байгааг дурдах нь зүйтэй.

---

28 Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги, УБ., 110 дахь тал, 2011 он

29 Б.Бат-Эрдэнэ, Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, (1 Ерөнхий анги), УБ., 1996. 86 дахь тал.

30 Б.Батболд, Гэмт хэргийн улмаас иргэний амь нас, эрүүл мэндэд учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулах талаарх үзэл баримтлал. Хууль дээдлэх ёс. №3, 2020

31 Б.Батболд, Гэмт хэргийн улмаас иргэний амь нас, эрүүл мэндэд учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулах талаарх үзэл баримтлал. Хууль дээдлэх ёс. №3, 2020



Тус гэмт хэргээс учирсан хохирлыг төрөөс барагдуулах тухай хуулийн үзэл баримтлал нь 4 үндсэн суурь онолд суурилдаг. Үүнд;

Нийгмийн гэрээний онолын дагуу төр нь иргэдийнхээ аюулгүй байдлыг хангах, хамгаалах үүрэгтэй, харин иргэд зарим төрлийн эрх чөлөөгөө хязгаарлуулахаар харилцан тохиролцсон хэмээн үздэг. Гэвч төр нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй буюу иргэдээ гэмт хэргээс урьдчилан сэргийлж хамгаалж чадаагүй тул хариуцлага хүлээн төрөөс хохирлыг барагдуулах нь зөв гэсэн онол дээр суурилдаг байна. Энэхүү санааг дэмжин, В.В. Батуев нь гэмт хэрийн улмаас учирсан хохиролд иргэнийг хамгаалах үүрэг бүхий төрийн буруу ч байдаг учир хохирогч нь гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулахыг шаардах, харин төр барагдуулах үүрэгтэй хэмээн заасан байна<sup>32</sup>.

Нөгөөтэйгүүр, хохирлын тогтолцоог халамжийн онолын үүднээс тайлбарлахдаа тусгай хэрэгцээт буюу эмзэг бүлгийн иргэдэд төр илүү анхаарал тавих ёстой тул төр хангалттай хамгаалж чадахгүй байгаа эмзэг давхаргын иргэддээ төрөөс хохирлыг барагдуулах нь зүйтэй гэсэн үзэл санааг агуулдаг.

Харин Даатгалын онолын дагуу хохирлын сан нь нэг төрлийн даатгалын системтэй адилтгаж үзэх нь зүйтэй гэж үздэг. Учир нь бүх иргэд гэмт хэргийн хохирогч болох өндөр эрсдэлийг хүлээж байдаг тул татвар төлөгчдийн мөнгөнөөс хохирлын санг бүрдүүлэх нь зүйтэй бөгөөд хүн бүр гэмт хэргийн хохирогч болох эрсдэл үүрч байгаагийн хувьд тодорхой хэмжээнд хохирлын санд хувь нэмэр оруулах зүйтэй гэж үздэг байна.

Иймд хохирлын сангийн хамрах хүрээ, хүртээмжийн тухай ялгаатай үзэл баримтлал, онол байдгаас шалтгаалж, хууль тогтоогчдын аль талыг баримтлах хандлагаас улбаалан улс болгон хохирлын сангийн тухай ялгамжтай бодлогыг хэрэгжүүлдэг байна.

Төрөөс гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох үзэл санааг хамгийн анх Англи угсааны хуульч, Барууны орнуудын эрх зүйн хөгжилд чухал хувь нэмэр оруулсан Шинэ Зеландын төрийн эрх баригч Маргери Фрай гаргасан байна. Тэрээр хэлэхдээ “Энэхүү нөхөн төлбөр нь нэг төрлийн нийгмийн даатгал бөгөөд бүх татвар төлөгч иргэд гэмт хэргийн хохирогч болох эрсдлийг байнга үүрч байдаг тул бүх иргэд татварын мөнгөөр дамжуулан хохирлын санд тодорхой хувь нэмэр үзүүлэх хэрэгтэй” гэсэн үзэл санааг анх дэвшүүлж байжээ.<sup>33</sup> Улмаар Хохирлын сангийн тухай үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулж, олон удаагийн хэлэлцүүлэг мэтгэлцээн өрнүүлсний эцэст Шинэ Зеланд улсад 1964 онд Хохирлын сангийн тухай хууль батлагдсан. Хэдэн сарын дараа энэхүү хохирлын тогтолцоог Их Британи улс нутагшуулсан бол удалгүй АНУ, Канад, Австраль, Европын Холбооны орнууд хохирлын сангийн тогтолцоог үндэсний хэмжээнд бэхжүүлж холбогдох хууль тогтоомжуудыг баталсан байна.<sup>34</sup>

Хохирлын сангийн тухай үндэсний эрх зүйн тогтолцоо нь тухайн оронд болсон нөхцөл байдлын онцлог, эдийн засгийн боломж бололцоо, үндэсний сэтгэхүйгээс шууд хамааралтай тул хохирлын сангийн тухай төгс зохицуулалт, хууль тогтоомж байх боломжгүй. Төрийн эрх баригчдын улс төрийн баримталж буй бодлого, үзэл баримтлалаас ихээхэн хамаарч байдаг. Хохирлын тогтолцоог бүрдүүлэхэд нийгэм

32 Б. Батболд, Гэмт хэргийн улмаас иргэний амь нас, эрүүл мэндэд учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулах талаарх үзэл баримтлал. Хууль дээдлэх ёс. №3, 2020

33 HALDANE, J., & HARVEY, A. The Philosophy of State Compensation. *Journal of Applied Philosophy*, 12(3), 273–282. <http://www.jstor.org/stable/24354130>, 1995

34 Мөн тэнд.

эдийн засгийн байдлыг харгалзан дараах зүйлсүүдийг чухалчлан хууль тогтоомждоо тусгадаг байна<sup>35</sup>.

- Хохирлын сангаас нөхөн олговор олгох эрх бүхий субъект;
- Хохирлын сангийн санхүүгийн эх үүсвэр;
- Нөхөн олговор авах шалгуур;
- Гэмт этгээдүүд хохирлын санг бүрдүүлэх эсэх;
- Сурталчилгааны асуудлын тухай хүчин зүйлүүдийг тус тус тусган тогтолцоогоо бүрдүүлдэг байна.

Дэлхий нийтийн чиг хандлагад гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчдод төрөөс нөхөн олговор олгох хохирлын сангийн тогтолцоотой холбоотойгоор хэд хэдэн бэрхшээлүүд тулгараад байна. Үүнд санхүүжилтын асуудал буюу санхүүжилт эх үүсвэр хангалтгүй, зохицуулалт дутмаг байгаагаас шалтгаалж сангаас нөхөн олговор олгох асуудал удааширч, төр хохирогчдыг ялгаварлан гадуурхах, хохирогчид нөхөн олговор авч чадахгүй байгаа тохиолдол цөөнгүй байна. Иймд хууль зүйн тулгамдсан асуудлын нэг нь хохирогчдын хамрах хүрээг хэрхэн өргөсгөх, ямар шалгуур тавих, нарийвчилсан зохицуулалт дэлхий дахинаа тулгамдаад байна. Дээрхи асуудлуудыг нарийвчлан тооцсоны үндсэн дээр хохирлын сангийн тухай хууль тогтоомжуудыг хуульчилдаг бөгөөд эдгээр асуудлуудыг хэрхэн хуульчлан зохицуулсан байгаагаас шалтгаалан улс орон болгон гэмт хэргийн гаралт, нийгмийн байдал, эрэлт хэрэгцээнээс шалтгаалж харилцан адилгүй хохирлын сангийн тогтолцоотой байна. Хохирлын тогтолцоог амжилттай хэрэгжүүлснээр хохирогчид өөрсдийн эрх ашгийн төлөө гэмт хэргийг яаралтай бүртгүүлжүүлэх зэрэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх процесс, хохирогчдын эрх ашгийг хамгаалах, хохирлыг бүрэн нөхөн барагдуулах нь эрүүгийн эрх зүйн тогтолцоонд маш чухал ач холбогдолтой буюу эрүүгийн эрх зүйн зорилго, зорилтыг биелүүлэхэд чухал нөлөө үзүүлдэг хэмээн судлаачид үздэг байна<sup>36</sup>.

Иймд гадаадын улс орны хууль тогтоомжийг харьцуулан судлах ажлын хүрээнд Азийн орнуудаас Япон улс, БНСУ, БНКУ болон Европын орнуудаас БНГУ, Норвеги болон Шведын Хант улсуудыг тус тус сонгон, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах тогтолцоо, хохирлын сангийн тухай хууль эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан авч судаллаа. Тус улс орнуудын нийгэм эдийн засгийн байдал, хууль эрх зүйн нарийвчилсан зохицуулалт, болон хөгжингүй байдлыг харгалзан тус улсуудыг сонгон авч судласан болно. Уг судалгааны хүрээнд дараах хүснэгтэд заасан шалгуур үзүүлэлтүүдийг чухалчлан авч судалсан болно.

|                          | Япон   | БНСУ   | Казакстан   |
|--------------------------|--|--|---|
| Холбогдох хууль тогтоомж | Санхүүгийн болон бусад туслалцаа үзүүлэх тухай хууль | Гэмт хэргийн хохирогчийн тусламжийн тухай хууль;<br>Гэмт хэргийн хохирогчийн сангийн тухай хууль | Нөхөн олговор олгох тухай хууль;<br>Хохирогчид олгох нөхөн олговрын сангийн тухай хууль |
| Санхүүжилт               | Улсын төсөв  | Улсын төсөв,<br>Мөнгөн хандив  | Улсын төсөв   |

35 Мөн тэнд.

36 HALDANE, J., & HARVEY, A. (1995). The Philosophy of State Compensation. *Journal of Applied Philosophy*, 12(3), 273–282. <http://www.jstor.org/stable/24354130>

|   |   |   |  |
|---|---|---|--|
| Эрх бүхий этгээд                                | Хохирогч нас барсан тохиолдолд түүний ар гэрийнхэнд;<br>Гэмт хэргийн улмаас хохирогч хүнд гэмтэл авч, хөгжлийн бэрхшээлтэй болсон | Хүнд гэмтэл авсан гэмт хэргийн хохирогч болон нас барсан хохирогчдын асран хамгаалагчид   | Эрүүл мэндэд нь хүнд хохирол учирсан этгээд болон дархлал хомсдолын вирус авсан этгээд; Бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт өртсөн насанд хүрээгүй этгээд, хүн худалдаалах болон эрүүдэн шүүх гэмт хэргийн хохирогч; Хохирогч нас барсан тохиолдолд түүний хууль ёсны төлөөлөгч. |
| Гадаадын иргэн х а м р а г д а х боломжтой эсэх | Японд оршин суугаа гадаадын иргэд хамрагдах боломжтой   | Гэмт хэрэг гардаг өдөр БНСУ -д оршин суух зохих визтэй, бол гадаадын иргэд, болон жуулчид өргөдөл гаргах эрхтэй.                |  |
| Өргөдөл гаргах хугацаа                          | Гэмт хэрэг гэж үзсэн цагаас 2 жилийн дотор буюу гэмт хэрэг гарснаас 7 жилийн дотор өргөдөл гаргасан байх ёстой.                   | Хохирогч болон ар гэрийнхэн нь гэмт хэргийг мэдсэн даруйдаа 2 жилийн дотор, эсхүл гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш 5 жилийн дараа | Гурван жилийн дотор гаргах эрхтэй бөгөөд хэрэв өргөдөл гаргах эцсийн хугацаанд өргөдлөө багтааж өгч чадаагүй тохиолдолд Казахстан Улсын хууль тогтоомжид заасан журмын дагуу өргөдөл гаргах хугацааг сэргээх хүсэлтээ шүүхэд гаргах эрхтэй.  |
| Өргөдлийг хүлээн авах байгууллага               | Цагдаагийн байгууллага  | Цагдаагийн байгууллага эсвэл прокурорын газар   | Цагдаагийн байгууллага   |
| Нөхөн олговрын дээд хэмжээг заасан эсэх         | Тийм  | Тийм  | Тийм   |

|                          | БНГУ  | Норвеги   | Швед  |
|--------------------------|---|---|---|
| Холбогдох хууль тогтоомж | Гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох тухай хууль   | Эрүүгийн гэмт хэргийн улмаас хүний биед учирсан хохирлыг төрөөс нөхөн олгох тухай хууль   | Гэмт хэргийн хохирогчдын сангийн тухай хууль  |
| Санхүүжилт               | Улсын төсөв   | Улсын төсөв   | Шүүхийн шийдвэрээр торгууль ноогдуулахаар тогтоосон гэмт хэрэгтэн этгээд бүрээс 800 крон авч сангийн хөрөнгийг бүрдүүлнэ.   |
| Эрх бүхий этгээд         | Хүч хэрэглэсэн, болон хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчид бие махбодийн болон сэтгэцийн эрүүл мэндийн бүх хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй. | Гэмт хэргийн улмаас эрүүл мэндээрээ хохирсон хохирогчид, тэжээгчээ алдсан гэр бүлийн гишүүдэд, Гадаадад гэмт хэргийн хохирогч болсон өөрийн улсын иргэдэд нөхөн олговор олгоно. | Хувь хүний, болон өмчийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд; Гэмт хэргийн шинжтэй үйлдлийн улмаас хохирогчид гэмтэл учирсан байх; Өмч хөрөнгийн эсрэг үйлдсэн гэмт хэрэг; Ноцтой гэмт хэргийн хохирогчдын гэр бүл, болон гэрч болсон хүүхдүүдэд олгоно |

ХОХИРЛЫН САНГИЙН ТУХАЙ ГАДААД ОРНУУДЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

|   |   |   |  |
|---|---|---|--|
| Гадаадын иргэн хамрагдах боломжтой эсэх | ХБНГУ-тай хоёр талын хэлэлцээртэй улсын иргэн, ХБНГУ-д албан ёсоор 3 жилээс багагүй хугацаанд амьдарч байгаа гадаадын иргэн нөхөн төлбөр авах эрхтэй байна. | Гадаад улсын иргэд нөхөн төлбөр авах хүсэлт гаргах эрхтэй.  | Гадаад оюутан болон жуулчид хамрагдах боломжтой.   |
| Өргөдөл гаргах хугацаа                  | Хуульчлан тогтоогоогүй ч ихэнхи тохиолдолд 1 жилийн дотор гаргадаг.   | Гурван жилийн дотор гаргах эрхтэй бөгөөд хэрэв тухайн хугацаанд өргөдлийг гаргаагүй бол хүндэтгэх шалтгааныг харгалзан үзнэ.                      | Эрүүгийн хэрэг хаагдсанаас хойш 2 жилийн дотор гаргах ёстой. Тухайн хугацаанд өргөдлийг гаргаагүй бол хүндэтгэх шалтгааныг харгалзан үзнэ. |
| Өргөдлийг хүлээн авах байгууллага       | Ц а г д а а г и й н б а й г у у л л а г а а р дамжуулан төрийн бус байгууллага  | Цагдаагийн байгууллагаар дамжуулан Норвеги улсын Вардое хот дахь Хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчдын нэхэмжлэлийн алба хүлээн авч шийдвэрлэнэ. | Гэмт хэргийн хохирогчийг дэмжих газар  |
| Нөхөн олговрын дээд хэмжээг заасан эсэх | Үгүй  | Тийм  | Тийм   |

**ЯПОН УЛС**

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн төлүүлэх хууль тогтоомж 1974 оны 8 -р сарын 30 -ны өдөр Япон улсын Токио хотод байрлах Mitsubishi Heavy Industries -ийн төв байранд террорист халдлага болж, бөмбөгдөлтөнд найман хүний амь эрсдэж, 376 хүн шархадсаны улмаас хохирогчдын гэр бүлийн гишүүдийг хамгаалах, нөхөн олговор олгох системийг хамгийн анх төрөөс бий болгосон байна. Улмаар 1980 онд “Гэмт хэргийн хохирогчдод олгох тэтгэмжийн тухай хууль” (Crime Victims Benefit Payment Law),-ийг баталж, Гэмт хэргийн хохирогчдод олгох тэтгэмжийн (The Benefit System for Crime Victims) тогтолцоог үндсээр нь хэрэгжүүлж эхэлсэн байна<sup>37</sup>. Гэмт хэргийн хохирогчдод олгох тэтгэмжийн систем гэдэг нь санаатай гэмт хэргийн улмаас амь насаа алдсан хохирогчийн ар гэрийнхэнд эсвэл хохирол амссан хохирогчдод сэтгэцийн хямрал, эдийн засгийн хохирлыг хөнгөвчлөхийн тулд олгодог төрөөс олгож буй нэг удаагийн нөхөн олговор бөгөөд харилцан туслалцаа, эв санааны нэгдэл дээр суурилсан хохирогчдод чиглэсэн бодлого юм<sup>38</sup>.

Мөн 1995 онд Токиогийн метронд хий ялгарсны улмаас олон тооны хүмүүс хохирсон бөгөөд олон нийтийн хандлага тэдгээр хэргээс хохирсон хохирогчдод чиглэсэн тул тус хуулийн хамрах хүрээг өргөтгөх шаардлага тулгарсан. Энэхүү хуулийн хэрэгжилтийн түвшинг судлахад 2000 он хүртэл гэмт хэргийн улмаас хохирогчдын 2770 гэр бүлд тэжээгчээ алдсаны тэтгэмжийг олгож, харин зөвхөн 86 хохирогчид тахир дутуугийн тэтгэмж олгосон байна. Иймд харьцангуй цөөхөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хамрагдаж байна гэж үзсэн тул 2001 оны 7-р сарын

37 ITO Fujie & ISHII-TAKIGUCHI Ryoko. 2020 The Current Status and Issues in Crime Victim Support in Japan. [http://www.sophia-humans.jp/department/socialservices\\_bulletin/pdf/2020\\_06.pdf](http://www.sophia-humans.jp/department/socialservices_bulletin/pdf/2020_06.pdf)

38 ITO Fujie & ISHII-TAKIGUCHI Ryoko. 2020 The Current Status and Issues in Crime Victim Support in Japan. [http://www.sophia-humans.jp/department/socialservices\\_bulletin/pdf/2020\\_06.pdf](http://www.sophia-humans.jp/department/socialservices_bulletin/pdf/2020_06.pdf)

7 ноос эхлэн (Crime Victims Benefit Payment Law) хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, хөнгөн төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хохирогчдыг хамруулахаар болсон байна. Тус Гэмт хэргийн хохирогчдын тэтгэмжийн тухай хуулийн (Crime Victims Benefit Payment Law) нэрийг өөрчлөн, Гэмт хэргийн хохирогчийг дэмжих тухай хууль (The Crime Victim Support Law) болгож, 2008 онд шинэчлэн найруулж нэмэлт өөрчлөлт оруулсан. Энэхүү нэмэлт өөрчлөлтийн хүрээнд нас барсан хохирогчийн ар гэрийн хүмүүст олгох нөхөн олговрыг илүү нарийвчилсан зохицуулалттай болгож, мөн хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хохирогчдыг 1-3 зэргийн хөгжлийн бэрхшээлээр нь ангилан, нөхөн олговрын зааг ялгааг нэмэгдүүлэхээр болсон байна. Тус хууль нь олон удаагын нэмэлт өөрчлөлтөөр Санхүүгийн болон бусад туслалцаа үзүүлэх тухай хууль гэж нэрлэх болсон байна. Уг хууль нь 13 зүйл, заалт бүхий хууль бөгөөд хуулийн нэмэлт өөрчлөлтийг зөвхөн Парламентаар оруулж батлуулахаар заасан байна<sup>39</sup>.

Улмаар нөхөн олговрын санг улам боловсронгуй болгох үүднээс 2004 оны 12 -р сард “Гэмт хэргийн хохирогчдын тухай суурь хууль” (The Basic Act on Crime Victims) батлагдсан. Энэхүү хууль нь гэмт хэргийн хохирогчдод зориулсан бодлогын талаарх үндсэн санаануудыг тусгасан бөгөөд гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх цогц, урт хугацааны дэмжлэгийг хэрэгжүүлэх үндсэн зарчмуудыг агуулсан байна. Энэхүү хуулиар гэмт хэргийн хохирогчдод зориулсан үндсэн төлөвлөгөөг бий болгох, хохирлын санг боловсронгуй болгох үүргийг засгийн газарт илүү дэлгэрэнгүй хуульчлан өгсөн байна.

Тус хуулийн үзэл баримтлалд зааснаар <sup>40</sup>

Төрийн салшгүй нэг чухал чиг үүрэг бол иргэд аюулгүй амар тайван амьдарч чадах орчныг бүрдүүлэх явдал юм. Гэмт хэргийн гаралтыг багасгах, урьдчилан сэргийлэхийн тулд Японы засгийн газар тасралтгүй үйл ажиллагаа явуулж ирсэн ч сүүлийн жилүүдэд янз бүрийн төрлийн гэмт хэргүүд их хэмжээгээр гарч байна. Улмаар гэмт хэргийн хохирогчдын эрх ашиг алдагдаж, хохирлын нөхөн олговоргүй, нийгмээс гадуурхагдаж байна. Хохирогчдын дийлэнхи нь гэмт хэргийн улмаас учирсан шууд хохирол төдийгүй, дараа нь үүсэх нэмэлт хор уршгийг ихэвчлэн амсдаг. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын гол хариуцлагыг гэмт хэрэгтнүүд хүлээх ёстой. Гэсэн хэдий ч төр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, болон иргэдийн аюулгүй амар тайван амьдрах нийгмийг цогцлоох чиг үүрэгтэй тул гэмт хэргийн хохирогчдын дуу хоолойг сонсох ёстой. Өнөөгийн нийгэмд хүн бүр гэмт хэргийн хохирогч болох магадлал өндөр байгаа тул Гэмт хэргийн хохирогчдын байр сууринаас бодлого гаргаж, тэдний эрх, ашиг орлогын эх үүсвэрийг сайн хамгаалсан байх шаардлагатай байна. Иймд гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх арга хэмжээний үндсэн зарчмуудыг тодруулж, чиглэлийг нь зааж, гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх арга хэмжээг төр, орон нутгийн засаг захиргаа, холбогдох бусад байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран цогц системтэйгээр таниулах зорилгоор энэхүү хуулийг баталж байна.

Тус хуулийн 13 дугаар зүйлд зааснаар “Гэмт хэргийн хохирогчдод учирсан хохирлын эдийн засгийн ачааг хөнгөвчлөхийн тулд муж, орон нутгийн засаг захиргаа гэмт хэргийн хохирогчдод тэтгэмж олгох гэх мэт тогтолцоог сайжруулах шаардлагатай арга хэмжээг авах ёстой” хэмээн хуульчлан зохицуулсан байгаа нь төр, иргэнийхээ өмнө хүлээх үүрэг хариуцлагыг тодотгон бэхжүүлж чадсан байна<sup>41</sup>.

39 ITO Fujie & ISHII-TAKIGUCHI Ryoko. 2020 The Current Status and Issues in Crime Victim Support in Japan. [http://www.sophia-humans.jp/departments/socialservices\\_bulletin/pdf/2020\\_06.pdf](http://www.sophia-humans.jp/departments/socialservices_bulletin/pdf/2020_06.pdf)

40 [http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail\\_main?re=&vm=02&id=2980](http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail_main?re=&vm=02&id=2980)

41 Matsuzawa, S. PROTECTION OF VICTIMS OF CRIME-THE CASE OF JAPAN, *THE RIGHT TO HUMAN DIGNITY*, 349, 2020

Улмаар хилийн чанад дахь гэмт хэргийн хохирогчдод эмгэнэл илэрхийлэх мөнгийг олгох тухай хуулийг (the Act on the Payment of Condolence Money to the Victims of Crimes Overseas) хилийн чанадад гэмт хэргийн хохирогч болсон иргэдийг хамгаалах зорилгоор мөн баталсан бөгөөд энэ нь нас барсан гэр бүлд эмгэнэлийн мөнгө, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хохирогчдод нөхөн олговор олгох боломжийг олгосон юм.

➤ Санхүүжилтын эх үүсвэр

Гэмт хэргийн хохирогчийн алба нь улсын төсвөөс санхүүждэг бөгөөд гэмт хэргийн улмаас өнчирсэн хүүхдэд болон гэмт хэргийн хохирогч нарт дэмжлэг үзүүлэх туслах сангаар дамжуулан тэтгэлэг олгодог.

➤ Хохирогч нөхөн төлбөр авах эрх үүсэх шалгуур

Хохирогч гэмт хэргийн талаар Цагдаагийн байгууллагад гаргасан байх ёстой. Өргөдөл гаргагч 2 жилийн дотор гэмт хэрэг гэж үзсэн буюу гэмт хэрэг гарснаас 7 жилийн дотор өргөдөл гаргасан байх ёстой. Хэрэв нөхөн төлбөр олгох тухай шийдвэрийг яаралтай гаргах боломжгүй бол, мөн гэмт хэрэгтэн болон гэмт хэргийн хохирол тодорхой бус байвал өргөдөл гаргагчид урьдчилсан нөхөн олговрыг журмын дагуу олгоно.

Өргөдөл гаргахад шаардлагатай материалууд:

1. Хохирогч нас барсан өдрийг нотлох баримт
2. Гэр бүлийн бүртгэл
3. Оршин суугаа газрын гэрчилгээний хуулбар
4. Хохирогчийн нотлох баримтууд. Тухайн бүс нутаг, хөгжлийн бэрхшээлийг тогтоосон холбогдох эмчийн дүгнэлт, бусад эрүүл мэндийн үзлэгийн тайлан
5. Хохирогчийн өдөр тутмын орлогоо нотлох баримтууд
6. Даатгалын нотолгооны нотлох боломжтой материалууд зэрэг тус тус багтана.

Улмаар Цагдаагийн байгууллага нь хохирлыг бүртгэх, гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг тогтоох, хүсэлтийг хүлээж авах ажлыг хариуцан ажиллаж байна. Мөн Цагдаагийн ерөнхий газар захиргааны үйл ажиллагааг сайжруулахтай холбогдуулан шийдвэр гаргах ажлыг түргэсгэх, гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх тэтгэмжийн тогтолцооны талаарх бүрэн мэдээллийг нийтэд түгээх зэрэг чиг үүргийг хариуцан ажилладаг.

Харин Олон нийтийн аюулгүй байдлын комисс (Prefectural Public Safety Commission) -ын Гэмт хэргийн хохирогчийн алба нь нөхөн олговор олгох, хууль ёсны шаардлагыг баталгаажуулж, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, гэмтэлтэй холбоотой холбогдох баримтуудыг тодруулж, хохирлыг үнэлэхдээ тодорхой нөхцөлүүдийг харгалзан, тэтгэмжийн мөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн төлөх тухай захиргааны шийдвэр гаргадаг. Нөхөн олговор авах хүсэлт гаргаснаас хойш нөхөн олговрыг нэг жилийн дотор олгохоор хуульд заасан ч практикаас харвал 2017 онд 6.4 сар, 2018 онд 6.6 сар дотор тус тус шийдвэрлэгдсэн байна.<sup>42</sup> Иймд төрөөс нөхөн олговрыг олгох тухай шийдвэрийг өргөдөл гаргаснаас хойш 6 сарын дотор ихэвчлэн шийдвэрлэж ирсэн байна. Харин албаны шийдвэр гарснаас хойш 2 долоо хоногийн дараа өргөдөл гаргагч зохих хэмжээний төлбөрийг олгоно.

---

42 Matsuzawa, S, PROTECTION OF VICTIMS OF CRIME-THE CASE OF JAPAN, *THE RIGHT TO HUMAN DIGNITY*, 349, 2020

Гэвч хохирлын нөхөн олговрыг дараах тохиолдолд олгохгүй.

- Хүсэлт гаргагч гэмт хэргийн шинжтэй үйл ажиллагаанд тусалж дэмжсэн, өдөөн хатгасан бол; эсхүл
  - аль хэдийн хохирлын нөхөн олговрыг өөр замаар авч байсан бол нөхөн олговор авах эрх үүсэхгүй.
- Гомдол гаргах эрх бүхий этгээд

Японы нутаг дэвсгэрт болсон тодорхой төрлийн гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн олговрыг олгох бөгөөд Японы иргэншилтэй, эсвэл оршин суугаа газар нь Японд байгаа хүмүүс, гэмт хэрэг гарсан үед Японд оршин суугаа гадаадын иргэд мөн хамрагдах боломжтой. Хохирогч гэмт хэрэг үйлдэх үедээ Японд хууль ёсны оршин суугч байсан бол гадаад улсын иргэд хохирлоо барагдуулах хүсэлт гаргах эрхтэй. Харин жуулчид хохирлын нөхөн олговрыг авах эрхгүй.

Гэмт хэргийн хохирогчийн хууль ёсны эхнэр / нөхөр эсвэл түүнтэй адилтгах статустай этгээдэд нийтлэг хуулиар олгоно. Эхнэр нөхөргүй тохиолдолд тэтгэмжийг хохирогчоос хараат болох хүүхэд, эцэг эх, ач, зээ, ах, эгч гэх зэрэг хүмүүст олгодог.<sup>43</sup>

- Нөхөн олговрын хамрах хүрээ

Гэмт хэрэг үйлдсэн гэмт хэрэгтэн нь тодорхойгүй, эсхүл гэмт хэрэгтэн галзуурсан, сэтгэцийн өвчтэй байгаа тохиолдолд, эсхүл гэмт этгээд нь насанд хүрээгүй бол

- Хохирогч нас барсан тохиолдолд, түүний ар гэрийнхэнд
  - Гэмт хэргийн улмаас хүнд бэртэл авч, хөгжлийн бэрхшээлтэй болсон тохиолдолд бол тус тус нөхөн олговрыг олгоно<sup>44</sup>.
- Нөхөн төлбөрийн хэмжээ ба олгох хязгаар

Нөхөн олговрын хэмжээг гэмт хэргийн хохирогчдын нас, ажил хөдөлмөрт суурилсан орлого гэх мэтийг үндэслэн тооцдог. Хохирлын дээд хэмжээ нь 1.200.000 иен аар хязгаарлагддаг. Гэмт хэргийн хохирогчдод олгох нөхөн олговрын хэмжээ нь 2015 оны санхүүгийн жилд 991 сая орчим иен, 2016 оны санхүүгийн жилд 882 сая иен байсан юм. Шагналын жилд, 2016 оны санхүүгийн жилд 6.7 орчим сар (өмнөх онтой харьцуулахад -0.3 сар). Харин 2017, 2018 онд гэмт хэргийн хохирогчийн тэтгэмжийн хэмжээ 1,001,000,000 иен, 724,000,000 иен байв.

2001 оноос хойш үйлдэгдсэн гэмт хэргийн улмаас учирсан хохирлын тэжээгчээ алдсаны нөхөн олговрын хэмжээ нь 10.790.000 иен байдаг бөгөөд үүнд хохирогч нас барахаасаа өмнө гэмтлийн улмаас эмчилгээ хийлгэж байсан тохиолдолд хохирогчийн хүнд гэмтэл, өвчин туссанаас хойш гурван сараас нэг жилийн хугацаанд холбогдох эмчилгээний зардлыг түүний ар гэрийнхэнд олгодог. Мөн сэтгэцийн хэвийн бус байдлаа алдсаны улмаас ажлаасаа чөлөө авч, 1 сараас дээш хугацаанд эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх шаардлага тулгарсан бол эмчилгээний зардлыг хариуцан нөхөн олгоно.

43 <https://www.npa.go.jp/hanzaihigai/whitepaper/english/2019/pdf/chapter1.pdf>

44 Matsuzawa, S, PROTECTION OF VICTIMS OF CRIME-THE CASE OF JAPAN, *THE RIGHT TO HUMAN DIGNITY*, 349, 2020

Гэмт хэргийн улмаас учирсан бие махбодийн маш хүнд бэртэл гэмтэл авсан болон өвчин шаналалын улмаас үүсэх сэтгэл зүйн хохирлыг оролцуулан нөхөн олговрын хэмжээг тооцохдоо, хохирогч 1 жил хүртэлх хугацаанд хувиараа төлсөн эмчилгээний зардал болон хөдөлмөр алдагдлаас болж бизнесээ зогсоосны улмаас учирсан хохирлыг харгалзан үзэж 12.730.000 иенээр нөхөн олговрын хэмжээг тооцдог байна.

Хөдөлмөрийн чадвараа үүрд алдсаны нөхөн олговорт тахир дутуу болсон 1-14 хүртэлх ангиллыг харгалзан, нөхөн олговрыг тооцон ангилдаг байна. Тухайлбал, 1-3-р зэргийн тахир дутуугийн зэрэгт 10,560,000 - 39,744,000 хүртэлх иен олгодог бол бусад ангилалд 10,560,000 - 39,744,000 хүртэл нөхөн олговрыг олгодог байна. Дээрхи 3 төрлийн хохирлын төрөлд төрөөс зөвхөн ганц удаагийн мөнгөн тэтгэмжийг олгодог байна. Өөрөөр хэлбэл, эдгээр нөхөн олговор нь гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нэг хэсгийг нөхөх зорилгоор олгосон тэтгэмжийн нэг хэлбэр юм.

## **БНСУ**

➤ Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн төлүүлэх хууль тогтоомж

БНСУ нь 2005 онд гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчдын эрхийг хамгаалах, тэдгээрийн нөхөн олговрыг барагдуулахад анхаарсны үндсэн дээр эрүүгийн хохирогчдын эрх ашгийг хамгаалахаар олон хуулиудыг амжилттай баталж, хэрэгжүүлж ирсэн байна. Учир нь 2000 оны эхээр ард иргэдийн эрүүгийн эрх зүйн системд, хууль дээдлэх ёс, шударга ёсны зарчимд итгэл алдарч эхэлсэн байна<sup>45</sup>. Учир нь гэмт хэргийн гаралт, давтамж маш их ихэссэнээр нийгэмд гэмт хэргээс айх түгшил сандрал нэмэгдэж, ард иргэдийн дунд сэтгэл санааны зовиур нийгэмд давамгайлж ирсэн байна<sup>46</sup>. Иймд, 2006 онд Солонгосын Криминологийн хүрээлэн 484 гэмт хэргийн хохирогч (243 эрэгтэй, 241 эмэгтэй) -д судалгаа хийжээ. Энэхүү судалгааны үр дүнгээс үзэхэд хохирогчид гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны маш хүнд байдалд ордог бөгөөд хохирогчдын 80.7% уур хилэнтэй болж, 74% нь сэтгэл санааны түгшүүрийг мэдэрч, 68.8% сэтгэлийн хямрал, сэтгэл хөдлөлийн тогтворгүй байдалтай байсан байна. Хохирогчдоос амссан хохирлыг судлахад хариултыг 62.1% нь сэтгэл санааны хохирол, 43% нь эд хөрөнгийн хохирол, бие махбодийн гэмтлийг 40.1% авсан байна. Хохирогчдын эдийн засаг нийгмийн байдлаар нь дүгнэвэл ихэнхдээ нийгэмд эзлэх байр суурь багатай, орлогын эх үүсвэр муутай хүмүүсд гэмт хэргийн улмаас учирсан хохирол амьдралд нь их хэмжээний хор уршиг дагуулдаг байна<sup>47</sup>.

Иймд гэмт хэргийн хохирогчид эрүүгийн эрх зүйн тогтолцоонд асар их сөрөг үр дагаврыг бий болгож байсан. Тухайлбал, зарим хохирогчид гэмт хэргийн тухай мэдээллэхээс зайлсхийдэг бөгөөд хохирлоо нөхөн төлүүлж чадахгүйгээс хойш эрүүгийн хэргийг мэдээллэхээс зайлсхийх хандлагатай байдаг байна. Иймд БНСУ-

45 On the Korean justice system, See [www.moj.go.kr/HP/ENG/eng\\_02/eng\\_2040.jsp](http://www.moj.go.kr/HP/ENG/eng_02/eng_2040.jsp); UNAFEI(1995), Criminal Justice Profiles of Asia-Investigation, Prosecution, And Trial. On the Korean justice system, See [www.moj.go.kr/HP/ENG/eng\\_02/eng\\_2040.jsp](http://www.moj.go.kr/HP/ENG/eng_02/eng_2040.jsp); UNAFEI(1995), Criminal Justice Profiles of Asia-Investigation, Prosecution, And Trial .

46 Cho, K. S, Assistance For Victims Of Crime In Korea. In *Support For Victims Of Crime In Asia* (Pp. 186-205). Routledge, 2007

47 Cho, K. S, The Current Situation And Challenges Of Measures For Victims Of Crime In The Korean Criminal Justice System, History And Development Of Measuresfor Victims Of Crime (Ch 1), Routledge, 2018



ын засгийн газар эрүүгийн эрх зүйн тогтолцоог сайжруулах, мөн хохирогчийг хамгаалах олон талт бодлого боловсруулж эрүүгийн эрх зүйд шинэтгэл хийсэн байна. Үүний нэг нь БНСУ-ын Хууль зүйн яам гэмт хэргийн хохирогчийн эрхийг хамгаалах зорилгоор 2005 оны 12 -р сарын 23 -ны өдөр “Гэмт хэргийн хохирогчийн тусламжийн тухай хууль” (Crime Victims Aid Act) -ийг баталж, тус хууль нь 2006 оны 3 -р сарын 24 -ний өдрөөс эхлэн мөрдөгдөж эхэлсэн байна. Тус хуулиар гэмт этгээдээс нөхөн төлбөр авч чадахгүй байгаа хохирогчдод төрөөс тусламж үзүүлэх тухай хуульчлан зохицуулсан байна.

Улмаар Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хууль (Crime victim protection act) батлагдсан бөгөөд тус хуулийн зорилго нь гэмт хэргийн улмаас амь насаа алдах, бие махбодид нь хохирол учирсан хохирогчийг хамгаалах, дэмжих, тусламж үзүүлэх, хохирогчдын сайн сайхны төлөө хувь нэмэр оруулахад оршино<sup>48</sup>. Тус хуулиар төрийн гэмт хэргийн хохирогчдын өмнө хүлээсэн үүргийг илүү нарийвчлан зохицуулсан байна. Тус хуулийн албан бус орчуулгыг хавсралт 1-ээс судлан харах боломжтой.

Хохирлын санг хэдэн ангилалд хуваадаг бөгөөд Тэжээгчээ алдсаны нөхөн олговрын сан; Тахир дутуу, хүнд гэмтэл бэртлийн нөхөн олговрын сан зэрэг тусгай чиг үүргээр нь ангилсан байна. Тус сан нь зөвхөн гэмт этгээдээс нөхөн олговор авах боломжгүй болсон хохирогчдод болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцын улмаас үүссэн хохирлыг барагдуулдаг онцлогтой байна. Мөн нөхөн олговор олгох тухай шийдвэрийг дүүргийн прокурорын харьяа болох Хохирол арилгах зөвлөл хохирогчдын хүсэлтийг авч шийдвэрлэгддэг бөгөөд Хууль зүйн яам зөвхөн хянах чиг үүргийг хуульчлан тогтоосон байна. Мөн нөхөн олговрын мөнгөн дүнг тогтоохдоо сарын орлого цалинг тодорхой хуульд заасан сар буюу 24-48; 2-48 сар зэрэг тогтоож өгсөн хугацаанд үржүүлэн тооцоог гаргана гэж заасан онцлог хэсэг байна. Мөн тухайн хүний олж байсан орлого зэргийг хохирогч өөрөө тогтоон нотлох баримтыг бүрдүүлэх шаардлагагүй. Харин тус орлогын тодорхойлолтыг Татварын алба зэрэг зохих төрийн албаны байгууллагаас гаргуулан авдаг байгаа нь хүнд сурталыг арилгах, хугацаа хэмнэх, шийдвэр гаргалтын процессыг хурдасгах зэрэг олон давуу талуудыг олгож байгааг дурдах нь зүйтэй.

➤ Гомдол гаргах эрх бүхий этгээд

Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хууль (Crime victim protection act)-ийн 16 дугаар зүйлд зааснаар:

1. Гэмт хэрэгт ял шийтгүүлэгчээс хохирлын нөхөн төлбөрийн заримыг болон бүхэлд нь гаргуулж авч чадаагүй;
2. Өөрийн болон бусдын холбогдсон хэргийн талаархи хэрэг мөрдөн байцаалтын талаархи, хэрэг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх шатанд хэргийн мэдээлэл, гэрчийн мэдүүлэг, нотлох баримт гаргаж өгөх явцдаа тухайн хэрэгтэй холбоотойгоор хохирсон тохиолдлыг ойлгоно.

Дээрхи хуулиас харвал, гэмт этгээдүүд тодорхойгүй эсвэл санхүүгийн боломж байхгүй тул хохирлыг бүрэн буюу хэсэгчлэн төлж чадахгүй байгаа тохиолдолд нас барсан хохирогчийн ар гэрийнхэн эсвэл гэмт хэргийн улмаас хүнд бэртэл авсан хүмүүс төрөөс нөхөн олговор авахаас гадна гэдсэнд бүрэлдэж буй үр хөврөлийг хохирогчийн цусан төрлийн удам угсаа, болон гэр бүлийн гишүүн гэж үздэг бөгөөд нөхөн олговор авах эрх үүснэ. Мөн хохирогчийн биологийн аав ээжээс бус харин

48 Cho, K. S, The Current Situation And Challenges Of Measures For Victims Of Crime In The Korean Criminal Justice System, History And Development Of Measuresfor Victims Of Crime (Ch 1), Routledge, 2007

үрчилж авсан эцэн эх нь нэн тэргүүний нөхөн олговрын авах эрхтэй тухай эрэмбэлэн хуульчилсан байна. Харин хохирогч, гэмт этгээд хоорондоо аливаа хэлбэрээр хамтарч гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд, эсхүл нөхөн олговор олгох нь нийгмийн ёс суртахууны хэмжээнд харшлана гэж үзсэн бол хохирлын нөхөн олговрыг олгохгүй байхаар заасан байна.

Мөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад хохирогч болсон бол төрөөс нөхөн олговрыг авахаар хуульчлан тогтоосон байна.

➤ Нөхөн олговрын хамрах хүрээ

БНСУ -ын нутаг дэвсгэрт эсвэл тус улсын усан онгоц, нисэх онгоцонд гэмт хэргийн улмаас хүний амь нас, бие махбодид гэмтэл учруулсан бол хохирогч болон хохирогчийн ар гэрийнхэнд нөхөн олговор олгоно. Гэмт этгээдийн тодорхойгүй байдал, төлбөрийн чадваргүй байдал, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад хохирогч болсон бол төрөөс нөхөн олговрыг олгоно.

Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар хохирогч, гэмт хэрэгтэн 2 гэр бүлийн гишүүд, эхнэр нөхөр, хамтран амьдрагч, шууд залгамжлах 4 үеийн хамаатан байсан тохиолдолд нөхөн төлбөрийг олгохгүй. Мөн түүнчлэн хохирогч тухайн гэмт хэрэгт шууд бус хэлбэрээр оролцсон, хохирогчийн зохих хэмжээнээс хэтэрсэн заналхийлэл, доромжлол, биед нь халдах зэрэг буруутай үйлдлийн улмаас үүссэн хэрэг байвал нөхөн төлбөрийг олгохгүй.

Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу хохирогч нь дараах төрлийн нөхөн төлбөрийг авах эрхтэй:

1. Эмчилгээний төлбөр
2. Сэтгэл зүйн эмчилгээний төлбөр
3. Тэжээгчээ алдсаны тэтгэмж
4. Сургалтын төлбөр
5. Оршуулгын зардал

➤ Гомдол гаргах журам

Хохирогч болон ар гэрийнхэн нь гэмт хэрэг үйлдсэнийг мэдсэн даруйдаа 2 жилийн дотор буюу гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш 5 жилийн дараа харьяа дүүргийнхээ прокурорын газрын Гэмт хэргийн хохирогчдод туслах зөвлөлд хандан, өргөдөл гаргах ёстой.

2006 оны 5 -р сарын 3 -ны өдөр “Хууль зүйн үйлчилгээ, хохирогчийг дэмжих хэлтэс” (Legal Service and Victim Support Division) -ийг гэмт хэргийн хохирогчтой холбоотой хэргийг хянан шийдвэрлэх зорилгоор байгуулсан. Үүнтэй холбоотойгоор “Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, дэмжих үндсэн төлөвлөгөө” “The Basic Plan for Crime Victims Protection and Support” -ийг боловсруулсан<sup>49</sup>. Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, дэмжих үндсэн төлөвлөгөөнд гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах ерөнхий төлөвлөгөө, үндэсний болон орон нутгийн засаг захиргаа, иргэний нийгмийн дэмжлэг тусламжаа үзүүлэхээр заасан байна. Гэмт хэргийн хохирогчдын тусламжийн тухай хууль (Crime Victims Aid Act)-д, зааснаар гэмт хэргийн хохирогчид гэмт этгээдээс хохирлоо барагдуулж чадахгүй байгаа тохиолдолд гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчдод Улсын сангаас хохирлыг барагдуулна хэмээн заасан байна. Хохирогч харьяаллын дагуу прокурорын байгууллагын (Civil Affairs

49 Cho, K. S, The Current Situation And Challenges Of Measures For Victims Of Crime In The Korean Criminal Justice System, History And Development Of Measuresfor Victims Of Crime (Ch 1), Routledge, 2007

Division of a prosecutor's office) иргэний хэргийн хэлтэст өргөдөл гаргана. Харин Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, дэмжих газар (The Crime Victims Protection and Support Agency) нь тус өргөдлийг хянаж үзэн, улсын сангаас тусламж авах эрхтэй эсэхийг шалгаж, үнэлгээ өгсний үндсэн дээр хохирлын нөхөн олговрыг олгодог байна<sup>50</sup>.

➤ Нөхөн төлбөрийн хэмжээ ба олгох хязгаар

Талийгаачийн гэр бүлд үзүүлэх нөхөн олговор - 10 сая вон;

Тахир дутуугийн нөхөн олговор - 6 сая вон (1 -р анги), 4 сая вон (2 -р анги), 3 сая вон (3 -р анги)

➤ Санхүүжилтын эх үүсвэр

2008 онд БНСУ-д хүүхдийг хүчирхийлсэн онц ноцтой хэрэг гарсан боловч шүүх гэмт этгээдэд тохирох ялыг өгсөнгүй хэмээн хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуугиж эхэлсэн бөгөөд, олон нийтийн дунд асар их шүүмжлэл дагуулж, хохирогчдыг дэмжих, хамгаалах шаардлага тулгарсаныг үндэсний хэмжээнд ойлгуулсан байна. Үүний үр дүнд 2009 оны 10-р сарын 21-нд Гэмт хэргийн хохирогчдын сангийн тухай хуулийн (Crime Victim Compensation Fund) төслийг Солонгосын Үндэсний Ассамблейд өргөн барьсан. Улмаар 2010 оны 5-р сарын 14-нөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн бөгөөд 2014 оны 10-р сарын 15-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Энэхүү хуулийн зорилго нь “гэмт хэргийн хохирогчийг хамгаалах сан байгуулж, гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, дэмжихэд шаардагдах хөрөнгийг бүрдүүлэх, санг удирдах, ажиллуулахад шаардлагатай асуудлыг тодорхойлоход оршино<sup>51</sup> хэмээн заасан байна”.

Тус хуульд хохирогчдод зориулсан нөхөн олговрын төрөл; гэмт хэргийн хохирогчийг дэмжих бусад арга хэмжээ, сангийн үйл ажиллагаанаас олсон орлогын захиран зарцуулах зэрэг олон үйл ажиллагааг дараах байдлаар хуульчлан баталгаажуулсан байна. Тус хуулийн албан бус орчуулгыг хавсралт 2-оос харна уу.

## **БНКУ**

➤ Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн төлүүлэх хууль тогтоомж

Бүгд Найрамдах Казахстан Улсад Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн улмаас шүүхээс хохирогч болохыг тогтоосон этгээдэд нөхөн олговор олгох тухай хууль<sup>52</sup> 2018 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн бөгөөд дөрвөн бүлэг арван гурван зүйлээс бүрддэг. Тус хууль хүчин төгөлдөр мөрдөгдсөнөөс хойш нийт гурван удаа нэмэлт өөрчлөлт орсон бөгөөд сүүлийн нэмэлт өөрчлөлт 2021 оны 6 дугаар сарын 9-нд орсон байна. Хуульд заасны дагуу хохирогчид олгох мөнгөн нөхөн олговрыг зөвхөн нэг удаа, буцалтгүйгээр төсвийн гүйцэтгэлийн эрх бүхий төв байгууллагаас олгоно. Нөхөн олговор нь гэмт хэргийн улмаас материаллаг байдлаар хохирсон этгээдэд тусламж үзүүлдэг хэдий ч гэмт хэргийг илрүүлээгүйгээс эсхүл гэм буруутай этгээдийг олоогүй, тогтоогоогүй тохиолдолд хохирогчид нөхөн олговрыг олгохгүй байхаар зохицуулсан байна. Мөн гадаадын иргэн, харьяалалгүй этгээдийг шүүхээс хохирогч гэж тогтоосон тохиолдолд Казахстан Улсын хууль тогтоомж

50 Мөн тэнд.

51 Article 1, Crime Victim Protection Fund Act

52 “Хохирогчид олгох нөхөн олговрын сан”-ийн тухай хууль, [https://online.zakon.kz/Document/?doc\\_id=32981304=Ф=№\\_ФЙ#pos=7;-44](https://online.zakon.kz/Document/?doc_id=32981304=Ф=№_ФЙ#pos=7;-44), (Сүүлд үзсэн: 2021.08.26)

болон Казахстан Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол нөхөн олговор олгохоор зохицуулагдсан.

Хуульд заасны дагуу дараах этгээдэд нөхөн олговор олгохоор хуульчилсан байна.

- Бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт өртсөн насанд хүрээгүй этгээд, хүн худалдаалах болон эрүүдэн шүүх гэмт хэргийн хохирогч гэж хүлээн зөвшөөрөгдсөн этгээд;

Тухайлбал, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Казахстан Улсын Эрүүгийн хуулийн 110 дугаар зүйлийн 2.4 дэх хэсэг буюу эрүүдэн шүүх гэмт хэрэг, 120 дугаар зүйлийн 3-1 дэх хэсэг буюу насанд хүрээгүй этгээдийг хүчиндэх гэмт хэрэг, 121 дүгээр зүйлийн 3-1 дэх хэсэг буюу насанд хүрээгүй этгээдэд бэлгийн шинж чанартай хүч хэрэглэх гэмт хэрэг, 134 дүгээр зүйл буюу насанд хүрээгүй этгээдийг биеэ үнэлэхэд татан оролцуулах гэмт хэрэг зэрэг “Хохирогчид олгох нөхөн олговрын сан”-ийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дээрх этгээдүүдэд хамаарах гэмт хэргийг тус бүр нарийвчлан зохицуулсан байх бөгөөд нийт Эрүүгийн хуульд тусгагдсан 22 зүйл, хэсэг багтсан байна.

- Эрүүл мэндэд нь хүнд хохирол учирсан этгээд болон дархлал хомсдолын вирус авсан этгээд;

Тус улсын Эрүүгийн хуулийн 114 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг буюу хүний эрүүл мэндэд болгоомжгүй байдлаар хүнд хохирол учруулсан гэмт хэрэг, 116 дугаар зүйлийн 3 дахь хэсэг буюу хүний эд, эрхтэнг хууль бусаар авах гэмт хэргийн улмаас хохирогчийн эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, 120 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг буюу хүчингийн гэмт хэргийн улмаас хохирогч дархлал хомсдолын вирустэй болсон эсхүл эрүүл мэндэд нь хүнд хохирол учирсан, 255 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг буюу террорист үйл ажиллагааны улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, 355 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг буюу шугам хоолойг санаатайгаар гэмтээж, устгасны улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учирсан зэрэг “Хохирогчид олгох нөхөн олговрын сан”-ийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт гэмт хэргийг тус бүр зохицуулж өгсөн. Тус хуульд зааснаар Эрүүгийн хуулийн 43 зүйл, хэсэгт заасан гэмт хэргийг үйлдсэний улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учирсан тохиолдолд хуульд заасан нөхөн олговор олгохоор хуульчилсан.

- Хохирогч нас барсан тохиолдолд түүний хууль ёсны төлөөлөгч.

Мөн улсын Эрүүгийн хуулийн 99 дүгээр зүйл буюу хүнийг алах гэмт хэрэг, 105 дугаар зүйл буюу хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх, 106 дугаар зүйлийн 3 дахь хэсэг буюу хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулсны улмаас хохирогч нас барсан, 126 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэг буюу хүнийг хууль бусаар баривчилсны улмаас хайхрамжгүй байдлаас болж хүн нас барсан, 261 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг буюу хүнийг барьцаалсны улмаас хайхрамжгүй байдлаас болж хүн нас барсан, 348 дугаар зүйлийн 3 дахь хэсэг буюу тээврийн хэрэгслийг чанаргүй засварлах эсхүл техникийн доголдолтойгоор ашиглалтад оруулсны улмаас хайхрамжгүй байдлаас болж хүн нас барсан зэрэг “Хохирогчид олгох нөхөн олговрын сан”-ийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт нөхөн олговор авах этгээдэд хамаарах гэмт хэргийг тус бүр зохицуулсан байх бөгөөд нийт Эрүүгийн хуульд заасан 47 зүйл, хэсэг хамаарч байна.

Хохирогчид олгох нөхөн олговрын хэмжээг тогтооход Месячный расчётный показатель<sup>53</sup> /цаашид “МРП”/ гэх хэмжигдэхүүнээс тооцдог бөгөөд “2021-2023 оны Бүгд Найрамдах Казахстан Улсын төсвийн тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт<sup>54</sup> зааснаар 2021 оны МРП- 2,917 тэнгэ байхаар хуульчилсан байна. “Хохирогчид олгох нөхөн олговрын сан”-ийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хохирогчид олгох нөхөн олговрын хэмжээ нь 30 МРП-тэй тэнцүү байхаар, хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хохирогчид олгох нөхөн олговрын хэмжээ 40 МРП, хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан хохирогчид олгох нөхөн олговрын хэмжээ 50 МРП-тэй тэнцүү нөхөн олговрыг олгохоор хуульд тусгаж өгсөн байна. “Хохирогчид олгох нөхөн олговрын сан”-ийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан этгээд хэд хэдэн гэмт хэргийн хохирогч болсон тохиолдолд бага нөхөн олговор олгож байгаа гэмт хэргийн хохирлыг илүү их хэмжээний нөхөн олговор олгож байгаа хохиролд шингээх замаар олгохоор зохицуулсан.

➤ Хохирогчид нөхөн олговор олгох журам:

Тухайн этгээдийг хохирогч гэж тогтоосон эсхүл хохирогчийн эрх эдлүүлсэн этгээд мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа байгууллагад гурван жилийн дотор нөхөн олговор авах өргөдлөө гаргах эрхтэй бөгөөд хэрэв өргөдөл гаргах эцсийн хугацаанд өргөдлөө багтааж өгч чадаагүй тохиолдолд Казахстан Улсын хууль тогтоомжид заасан журмын дагуу өргөдөл гаргах хугацааг сэргээх хүсэлтээ шүүхэд гаргах эрхтэй. Өргөдлийг бүртгэснээс хойш мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа байгууллага арван хоногийн дотор шийдвэрлэж өгөх үүрэгтэй, тус шийдвэрийнхээ хариуг бичгэн хэлбэрээр өгөх бөгөөд тус шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа тохиолдолд гомдол гаргах эрхтэйг зайлшгүй тусгахаар зохицуулсан байна.

Нөхөн олговрыг дараах баримт бичгийн үндсэн дээр олгох бөгөөд эхний гуравт байгаа баримт бичгийг хохирогч гэж тогтоосон эсхүл хохирогчийн эрх эдлүүлсэн этгээд бүрдүүлж өгөх бол үлдсэн баримт бичгийг мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа байгууллага гаргаж өгөх үүрэгтэй байна.

1. хохирогч гэж тогтоосон эсхүл хохирогчийн эрх эдлүүлсэн этгээдийн өргөдөл;
2. хохирогчийн биеийн байцаалтын /иргэний үнэмлэх/ баримт бичгийн хуулбар, эсхүл нөхөн олговор авах эрхтэй болохыг тогтоосон хохирогчийн тухай бусад баримт бичиг;
3. хохирогч гэж тогтоосон эсхүл хохирогчийн эрх эдлүүлсэн этгээдийн банкны болон зарим төрлийн банкны үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагад нээсэн дансны дугаарын талаарх мэдээлэл;
4. тухайн этгээдийг хохирогч гэж тогтоосон мөрдөн шалгах ажиллагааны тогтоолын хуулбар;
5. хохирогчийн эрүүл мэндэд учруулсан хохирлын шинж чанар, ноцтой байдлыг баталгаажуулсан баримт бичгийн хуулбар;
6. хохирогч нас барсан тохиолдолд нас барсны гэрчилгээ, эсхүл хохирогчийн нас барсныг баталгаажуулсан бусад баримт бичгийн хуулбар.

53 Казахстан Улсын хууль тогтоомжид заасны дагуу олгогдох тэтгэмж болон бусад төлбөр тооцоог тооцох, мөн торгууль, татварыг тооцох сарын тооцооны индекс.

54 “2021-2023 оны Бүгд Найрамдах Казахстан Улсын төсвийн тухай” хууль, [https://online.zakon.kz/Document/?doc\\_id=32245090#pos=53;-54](https://online.zakon.kz/Document/?doc_id=32245090#pos=53;-54), (Сүүлд үзсэн: 2021.08.25)

Гэр бүлээс нэг гишүүн нь нас барсан тохиолдолд үлдсэн гэр бүлийн гишүүдэд зөвхөн нэг хүний нөхөн олговор олгоно. Хэрэв нэг гэр бүлээс хэд хэдэн гэр бүлийн гишүүн нас барсан бол нас барсан гишүүн бүрээр нөхөн олговор олгохоор хуульчилсан.

Мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагын дарга үндэслэлгүйгээр нөхөн олговор олгох, мөн нөхөн олговор олгосон этгээдийг улсын төвлөрсөн бүртгэлд бүртгэх ажлыг хариуцан ажиллана.

Дараах нөхцөл бүрдсэн тохиолдолд нөхөн олговор олгохоос татгалзаж болно.

1. “Хохирогчид олгох нөхөн олговрын сан”-ийн тухай хуульд заасан үндэслэл тогтоогдоогүй;
2. Өргөдөл гаргах хугацаа дууссан;
3. Худал баримт бичиг бүрдүүлсэн;
4. Хохирогчид учруулсан хохирлыг гэм буруутай этгээд бүрэн хэмжээгээр нөхөн төлсөн;
5. Хохирогч болохыг тогтоосон шийдвэр хүчингүй болсон.

Төсвийн гүйцэтгэлийн эрх бүхий төв байгууллага нөхөн олговор олгох мөнгийг арван хоногийн дотор мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа байгууллагад шилжүүлдэг бөгөөд мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа байгууллага хохирогчийн данс руу хуваарилдаг. Хэрэв хохирогчийн нөхөн олговрыг олгоход сангийн хөрөнгө хүрэлцэхгүй байгаа тохиолдолд санг бүрдүүлэх эс үүсвэрээс нөхөн олговроор олгох мөнгөн хөрөнгийг татаж авна.

Хохирогчид олгох нөхөн төлбөрийн санг бүрдүүлэх эх үүсвэр нь татварын бус орлого байх бөгөөд үүнд дараах төлбөр багтана:

- шүүхээс нөхөн төлүүлж буй албадан төлбөр;
- Казахстан Улсын Эрүүгийн процессын тухай хуулийн<sup>55</sup> 71, 78, 80, 81, 82, 90, 142, 156, 165 дугаар зүйлд заасан процессын үүргийг биелүүлээгүй, эсхүл өмгөөлөгч, прокурор, шүүгдэгчээс бусад шүүх хуралдааны оролцогчид хохирогч, гэрч, мэргэжилтэн, орчуулагч нар шүүх хуралдааны дэгийг зөрчсөн тохиолдолд шүүхээс тогтоосон мөнгөн торгууль;
- албадан ажил хийлгэх ялаар оноосон шүүхийн тогтоол хүчин төгөлдөр болсон ялтнаас авах мөнгөн торгууль;
- нэхэмжлэлийн шаардлагаар цуглуулсан мөнгө;
- Казахстан Улсын хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх сурвалж.

Шүүх гэм буруутай этгээдээс “Хохирогчид олгох нөхөн олговрын сан”-д мөнгө шилжүүлэх гэж байгаа тохиолдолд Казахстан Улсын Эрүүгийн хуулийн<sup>56</sup> 98-1, 98-2-т заасныг үндэслэн албадан шилжүүлгийг гүйцэтгэнэ. Хэрэв хэсэг бүлэг этгээд гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд гэм буруутай этгээд бүрээс албадан төлөх төлбөрийг тус тусад нь авна. Гэм буруутай этгээдээс хохирогчид олгох мөнгөн нөхөн олговрын нэхэмжлэлийг харьяа дүүргийн прокурорын байгууллагаас шүүхэд гаргаж өгөхөөр хуульчилсан байна. “Хохирогчид олгох нөхөн олговрын сан”-ийн үлдэгдэл мөнгийг улсын төсөвт татах, эсхүл шилжүүлэн авахыг хориглодог.

55 Казахстан Улсын Эрүүгийн процессын тухай хууль, [https://online.zakon.kz/Document/?doc\\_id=31575852#pos=90;-54](https://online.zakon.kz/Document/?doc_id=31575852#pos=90;-54), (Сүүлд үзсэн: 2021.08.26)

56 Казахстан Улсын Эрүүгийн хууль, [https://online.zakon.kz/Document/?doc\\_id=31575252&doc\\_id2=31575252#pos=114;-110&pos2=1619;-62](https://online.zakon.kz/Document/?doc_id=31575252&doc_id2=31575252#pos=114;-110&pos2=1619;-62), (Сүүлд үзсэн: 2021.08.26).

Хэдий хохирлын сангаас хохирогчдод нөхөн олговор олгосон ч гэсэн шүүх доор дурдсан этгээдээс нөхөн олговорт олгосон мөнгийг гаргуулж болно.

- Насанд хүрээгүй гэмт хэрэгтний хууль ёсны төлөөлөгчөөс;
- эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэний улмаас бодгаль этгээдэд материаллаг хохирол учруулсан хуулийн этгээдээс;
- Казахстан Улсын Эрүүгийн процессын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 4 болон 12 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлийн дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зогсоосон этгээдээс,
- нөхөн олговор авахын тулд хуурамч баримт бичиг бүрдүүлж өгсөн хохирогчоос.

“Хохирогчид олгох нөхөн олговрын сан”-ийн тухай хууль Эрүүгийн хуульд заасан нийт 124 зүйл, хэсэгт заасан гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчид нөхөн олговор олгохоор хуульчилсан. Өмнө нь дурдсанчлан нөхөн олговрыг зөвхөн материаллаг хохирол учирсан гэмт хэрэгт, эсхүл гэмт хэрэгтэнг тогтоосон, гэмт хэргийг илрүүлсэн тохиолдолд нөхөн олговор олгохоор зохицуулсан. Санг бүрдүүлэх хөрөнгийн гол үүсвэр нь шүүхийн шийтгэх тогтоолоор тогтоогдсон гэм буруутай этгээд бүрээс авах албадан төлбөр юм. Албадан хураах төлбөрийн хэмжээ нь гэмт хэргийн хүнд байдлаас хамаарч 5-30 хүртэлх МРП-тэй тэнцүү байна.

Мөн тус хуульд хохирогчид нөхөн олговор олгох хугацаа, журмыг тогтоосон байдаг бөгөөд мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа байгууллагыг үүрэгжүүлэн хохирогчид нөхөн олговор авах эрхийг тайлбарлах, түүний гаргасан өргөдлийг хүлээн авч бүртгэхээс эхлээд хохирогчид мөнгөн нөхөн олговор олгох хүртэл бүхий л харилцааг зохицуулсан байна. Үүний зэрэгцээ төсвийн гүйцэтгэлийн эрх бүхий төв байгууллага нөхөн олговор олгох мөнгийг арав хоногийн дотор мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа байгууллагад шилжүүлдэг бөгөөд мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа байгууллага хохирогчийн данс руу хуваарилдаг. Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуульд төрийн байгууллага тус бүрийн үүргийг нарийвчлан зохицуулж өгсөн бөгөөд, үүргээ биелүүлээгүйгээс үүдэн гарах хариуцлагыг мөн зохицуулсан байна. Хохирогчид нөхөн олговор олгосон нь эрүүгийн процессын болон иргэний процессын хууль тогтоомжид заасны дагуу гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны болон бусад хохирлыг бүрэн хэмжээгээр шаардах эрийг хязгаарлахгүй.

## **ЕВРОПЫН ОРНУУДЫН ТӨРӨӨС ХОХИРЛЫГ НӨХӨН БАРАГДУУЛАХ ТУХАЙ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

Европын холбоо нь гишүүн орнуудынхаа хохирлын тогтолцоог сайжруулах, хохирогчдын эрхийг сэргээх тал дээр стратегийн чухал үзэл баримтлалыг барьдаг байна. Энэхүү стратегийн гол зорилго нь хохирогчид Европын холбооны хаана ч, ямар ч нөхцөл байдалд байсан гэмт хэргийн хохирогчдын эрхийг бүрэн дүүрэн хангах явдал бөгөөд<sup>57</sup> гэмт хэргийн хохирогчдыг чадавхжуулах, хохирогчдын эрхийн төлөө хамтран ажиллахад оршино. Энэхүү стратеги нь таван үндсэн тэргүүлэх чиглэлийг баримталдаг байна.

57 [https://ec.europa.eu/info/policies/justice-and-fundamental-rights/criminal-justice/protecting-victims-rights/right-compensation\\_en](https://ec.europa.eu/info/policies/justice-and-fundamental-rights/criminal-justice/protecting-victims-rights/right-compensation_en)

- хохирогчтой үр дүнтэй харилцах, хохирогчдын гэмт хэргийн талаар мэдээлэх аюулгүй орчин;
- хамгийн эмзэг бүлгийн хохирогчдод үзүүлэх дэмжлэг, хамгаалалтыг сайжруулах;
- хохирогчдын нөхөн төлбөр авах боломжийг хөнгөвчлөх;
- холбогдох бүх оролцогчдын хамтын ажиллагаа, зохицуулалтыг бэхжүүлэх; хохирогчдын эрхийн олон улсын хэмжээсийг бэхжүүлэх.

Иймд Европын холбооны 2004 онд баталсан олон улсын гэрээгээр дараах үүргийг гишүүн орнуудад үүрэг болгосон байна.<sup>58</sup>

**НӨХӨН ТӨЛБӨРИЙН ҮНДЭСНИЙ СХЕМ<sup>288</sup>**

12 дугаар зүйл

Энэхүү баримт бичигт заасан журам нь гишүүн орнуудын өөрийн нутаг дэвсгэрт үйлдсэн хүч хэрэглэсэн санаатай гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох тухай схемд үндэслэн үйлчилнэ.

1. Гишүүн улс нь өөрийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн хүч хэрэглэсэн санаатай гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох схемийг бий болгож, хохирогчдод шударга, зохих нөхөн олговрыг олгохыг үндэсний хууль тогтоомжоор баталгаажуулна.

Иймд Европын холбооноос үүрэг болгосон баримт бичгийн 12 -р зүйлд зааснаар Европын холбооны улс бүр гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох үндэсний схемийг бий болгох шаардлагыг тавьсан байна<sup>59</sup>.

Улмаар ХБНГУ болон Баруун Европын орнууд сүүлийн 15 жилийн хугацаанд хохирогч судлал, хохирогчдын эрх ашигт онцгой анхаарал хандуулж, хохирогчийн нөхөн төлбөр олгох хэд хэдэн хууль эрх зүйн схемийг бий болгоход хүргэсэн<sup>60</sup>. Иймд ХБНГУ, Швед, болон Норвегийн Хант улсын хохирлыг төрөөс нөхөн барагдуулах тухай хууль тогтоомж болон хохирлын сангийн тухай харьцуулсан судалгааг дараах байдлаар дэлгэрэнгүй авч үзье.

## **ХБНГУ**

➤ Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн төлүүлэх хууль тогтоомж

ХБНГУ нь дайнд тахир дутуу болсон, хүчирхийллийн гэмт хэрэгт өртсөн, цэргийн алба хааж байгаад гэмтэж бэртсэн, вакцинжуулалтын улмаас хохирсон зэрэг төрийн үйл ажиллагааны шударга бус байдлын улмаас хохирол амссан хохирогчид болон тэдний ар гэрт төрөөс нөхөн олговор олгох үндэсний тогтолцоог бэхжүүлсэн байна. Тодруулбал,

ХБНГУ-ын Үндсэн хууль нь хохирогчдын эрхийг хамгаалах, хохирлыг төрөөс нөхөн төлүүлэх эрх үүргийг хуульчлан зохицуулсан байдаг<sup>61</sup>. Тухайлбал, ХБНГУ нь төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанаас учирсан гэм хорын хохирлыг төр хариуцан арилгах тухай үзэл санааг Үндсэн хуулийн түвшинд хуульчлан зохицуулсан. Тухайлбал, ХБНГУ-ын Үндсэн хуулийн 34 дүгээр зүйлд "...

58 COUNCIL DIRECTIVE 2004/80/EC of 29 April 2004 relating to compensation to crime victims, <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/PDF/?uri=CELEX:32004L0080&from=DE>.

59 European Union, [https://e-justice.europa.eu/content\\_if\\_my\\_claim\\_is\\_to\\_be\\_considered\\_in\\_this\\_country-491-en.do?clang=en](https://e-justice.europa.eu/content_if_my_claim_is_to_be_considered_in_this_country-491-en.do?clang=en).

60 DÜNKEL, F. Victim Compensation and Offender Restitution in the Federal Republic of Germany-A Western-European Comparative Perspective. *International Journal of Comparative and Applied Criminal Justice*, 9(1-2), 29-39, <https://doi.org/10.1080/01924036.1985.9688805>, 1985

61 [https://www.apav.pt/ivor/images/ivor/PDFs/Fact\\_sheet\\_germany.pdf](https://www.apav.pt/ivor/images/ivor/PDFs/Fact_sheet_germany.pdf)



төрийн албан хаагч нь өөрт итгэмжлэн хүлээлгэсэн ажил үүргийн хүрээнд гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн үүргээ зөрчсөн бол үүнтэй холбоотой учирсан хохирлыг төр хариуцан арилгана” гэж зааж “төр”-ийн хариуцлагын үзэл баримтлалыг Үндсэн хуулийн түвшинд хүлээн зөвшөөрсөн. Холбооны Үндсэн Хуулийн Шүүх «Үндсэн хууль нь хохирогчдын үндсэн эрхийг хамгаалах, сурталчлах, тэдний эрх ашгийг шүүхийн журмаар боломжийн хугацаанд хамгаалах, бататгах боломжийг төрд үүрэг болгоно” хэмээн тайлбарласан байна.<sup>62</sup>

Мөн, дэлхийн 2-р дайны дараа ХБНГУ нь дайны улмаас хохирсон хохирогчдод нөхөн олговор олгох, хохирогчдын эрхийг сэргээх бодлогыг баримталж эхэлсэн бөгөөд энэ үеэс эхлэн хохирлын сан, хохирогчдын эрхийг сэргээх тухай хууль тогтоомжуудыг баталж эхэлсэн байна. ХБНГУ нь гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулахаар хамгийн анх Холбооны дайны хохирогчийн тэтгэмжийн тухай хууль (The Federal War Victim's Maintenance Act (Bundesversorgungsgesetz))-ийг дэлхийн 2 -р дайны хохирогчид болон тэдний ард амьд үлдсэн гэр бүлийн хүмүүсийн эрхийг нь сэргээх зорилгоор баталсан. Энэхүү хууль нь одоо хүчин төгөлдөр үйлчилж буй засгийн газраас нөхөн олговрыг олгох тухай хууль тогтоомжуудын суурь хууль болсон юм.

Мөн хохирогчийн эрх ашгийг хамгаалах тухай үндсэн хуулийн үзэл санааг ХБНГУ-ын Иргэний хуулийн 839 дүгээр зүйлээр тодотгон, төрийн албан хаагчийн хохирлыг арилгах үүргийг төрд шилжүүлсэн байдаг. Тухайлбал, Германы Иргэний хуулийн 839 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрийн албан хаагч гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн албан үүргээ санаатай болон болгоомжгүй байдлаар зөрчсөн бол тэрхүү үйлдлийн улмаас учирсан хохирлыг өөр бусад замаар хохирогч хохирлоо барагдуулах боломжгүй болсон тохиолдолд учруулсан хохирлыг албан хаагч хариуцан арилгах үүрэгтэй”. Мөн хуулийн 34 дүгээр зүйлд “хэрэв аливаа этгээд өөрт нь олгогдсон төрийн/нийтийн албан үүргээ зөрчсөн бол түүний хариуцлагыг төр эсвэл түүнийг ажиллуулж байгаа байгууллага зарчмын хувьд хариуцна” гэж заасан байдаг. Германы Иргэний хуулийн 839 дүгээр зүйлийг 34 дүгээр зүйлтэй хамтатган хэрэглэх нь дараах хүрээгээр хязгаарлагдана<sup>63</sup>. Үүнд:

- Тухайн зөрчил нь заавал төрийн албан хаагчийн үйлдлийн үр дүн байх;
- Тухайн маргаантай үйлдэл нь албан хаагчийн өөрт нь олгогдсон албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой байх
- Учирсан гэх гэм хор нь зөрчигдсэн хэм хэмжээгээр хамгаалагдсан хүрээнд байх
- Тухайн зөрчил нь санаатай болон болгоомжгүй байдлаар үйлдэгдсэн байх зэрэг зохицуулалтыг тус тус агуулсан байна.

Германы эрх зүй дэх уг зохицуулалтын нэг чухал онцлог бол гэм хорын хохирогч нь хохирлоо барагдуулах өөр бусад эх үүсвэр болох даатгал, нийгмийн халамж зэрэг бусад эх үүсвэргүй байх явдал байдаг. Өөрөөр хэлбэл, хуулийн дээрх заалтын дагуу нөхөн төлбөр төлөх үүрэг үүсэх нэг үндэслэл нь уг гэм хорыг өөр арга хэрэгслээр арилгах боломжгүй байх шаардлагатай.<sup>64</sup>

62 [https://www.gesetze-im-internet.de/englisch\\_gg/](https://www.gesetze-im-internet.de/englisch_gg/), Basic Law for the Federal Republic of Germany

63 Мөн тэнд.

64 F.F.Blachly & M.E.Oatman, Approaches to Governmental Liability in Tort: A Comparative Survey, 9 Law and Contemporary Problems 181-213 (Spring 1942).

Мөн 1971 онд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас үүссэн хохирол нөхөн төлүүлэх тухай хууль (Gesetz über die Entschädigung für Strafverfolgungsmaßnahmen) (StrEG)-ийг батлан хэрэгжүүлж байна. Энэхүү хуульд шүүхийн өмнөх шатанд учирсан хохирлыг барагдуулах тухай тусгайлан хуульчлан зохицуулсан байдаг. Уг хуулийн 1-р зүйлд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас хохирол учирсан этгээд нь тухайн эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон, эсвэл ял оногдуулсан шийдвэрийг хүчингүй болгосон зэрэг бусад байдлаар дуусгавар болгосон тохиолдолд төрийн сангаас хохирол шаардах эрхтэй” гэж хуульчилжээ<sup>65</sup>.

Энэхүү хууль тогтоомжийн зарчим, үзэл баримтлалд нийцүүлэн тодорхой хэдэн нөхөн олговрын тухай хуулийг зорилго, чиг үүргээс нь шалтгаалан өөр өөр хуулиар зохицуулсан байна. Нийгмийн нөхөн олговрын тухай хууль (Social Compensation Act)- ийн дагуу нэхэмжлэл гаргаж байгаа тохиолдолд ихэвчлэн хохирол учруулсан тодорхой үйл явдал, арга хэмжээ, санаандгүй тохиолдол зэргээс үүдсэн байх ёстой юм. Харин вакцинаас улбаатай аливаа хохирлыг төрөөс барагдуулахдаа Халдвараас хамгаалах тухай хууль (The Infection Protection Act (IfSG))-иар тус тус ялгаатайгаар хуульчлан зохицуулдаг байна<sup>66</sup>.

Вестфалия-Липпегийн бүс нутгийн холбоо болон Рейнландын бүсийн холбоо нь тодорхой нөхөн олговрын хуулийн дагуу хохирогчдын өргөдлийг хянан шийдвэрлэх үүрэгтэй. Нийгмийн нөхөн олговрын тухай хуулийн дагуу тэтгэмж авах хүсэлт гаргахын тулд хариуцсан бүс нутгийн холбоонд өргөдөл гаргах ёстой. Өргөдлийг хүлээн авсны дараа холбогдох хуульд заасан нэхэмжлэлийн шаардлага хангасан эсэхийг шалгана.

Хэрэв хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчдод Хохирогчийн нөхөн олговрын тухай хууль (Victim Compensation Act (OEG))-аар зохицуулдаг бөгөөд хамгийн анх 1976 онд батлан гаргасан байна<sup>67</sup>. Германы хууль тогтоомжид «хохирогч» буюу victim гэсэн үгийн хууль ёсны тодорхойлолт байдаггүй. Энэ нэр томъёог ихэвчлэн co-plaintiff or injured party гэж тодорхойлдог<sup>68</sup>. Гэвч “Хохирогч” (victim) гэдэг үгийг шууд утгаар нь ашигладаг хууль бол “Victim Compensation Act” буюу “Хохирогчийн нөхөн төлбөрийн тухай хууль” юм. Энэ нь хохирогчдод олгох төрөөс гаргаж буй нөхөн олговрыг зохицуулдаг бөгөөд гэмт хэрэгтнийг олж чадахгүй байгаа нөхцөлд энэхүү хуулиар нөхөн олговрыг олгодог байна<sup>69</sup>. Тус хуулийн үзэл баримтлал нь “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаа нь гэмт хэргийн гаралтыг бууруулахгүй байгаа тул, хохирогчдын эрх ашгийг сэргээх системийг хөгжүүлэх нь зөв” гэж үзсэн байдаг<sup>70</sup>. Хуулийн зорилго нь “хүчирхийллийн улмаас үүссэн эрүүл мэнд, болон эдийн засгаараа хохирсон хохирлыг арилгах явдал юм”<sup>71</sup> хэмээн онцлон

65 Gesetz über die Entschädigung für Strafverfolgungsmaßnahmen (StrEG) <https://www.gesetze-im-internet.de/streg/BJNR001570971.html>

66 <https://www.lwl-soziales-entschaedigungsrecht.de/de/antrag-stellen/>

67 [https://www.gesetze-im-internet.de/englisch\\_oeg/englisch\\_oeg.html](https://www.gesetze-im-internet.de/englisch_oeg/englisch_oeg.html), Act on compensation to victims of violent crime, (Crime Victims Compensation Act – OEG)

68 [https://www.apav.pt/ivor/images/ivor/PDFs/Fact\\_sheet\\_germany.pdf](https://www.apav.pt/ivor/images/ivor/PDFs/Fact_sheet_germany.pdf)

69 Мөн тэнд.

70 DÜNKEL, F, Victim Compensation and Offender Restitution in the Federal Republic of Germany-A Western-European Comparative Perspective, *International Journal of Comparative and Applied Criminal Justice*, 9(1-2), 29-39, <https://doi.org/10.1080/01924036.1985.9688805>, 1985

71 <https://www.odabs.org/en/finanzielle-entschaedigung/compensation-via-the-crime-victims-compensation-act.html>

тэмдгэлжээ. Өөрөөр хэлбэл, Гэмт хэргийн хохирогчдын нөхөн олговрын тухай хуулийг хэрэгжүүлэхийн тулд нэхэмжлэгч нар хүчирхийллийн үйл ажиллагааны объект байх ёстой бөгөөд гэмт хэргээс учирсан хор уршгийг мэдэрсэн байх ёстой. Хохирогчид эсвэл амь насаа алдсан хохирогчдын ар гэр, хамаатан садан хоёулаа энэхүү хууль тогтоомжийн дагуу нөхөн төлбөр авах эрхтэй байна.

Тус хуулиар нөхөн төлбөр авахад тавигдах хууль зүйн үндэслэл, гомдол гаргах, шийдвэрлэх журам, нөхөн төлбөр олгохгүй байх үндэслэл, нөхөн төлбөр олгох зардал, гэмт хэргийн хохирогчид үзүүлэх тусламж, санхүүжүүлэх зэрэг нийтлэг асуудлыг зохицуулсан байна.<sup>72</sup> Тухайлбал, уг хууль нь нийт 7 зүйл, заалтаас бүрдэх бөгөөд хуулийн 10601 дүгээр зүйлд гэмт хэргийн хохирогчийн сан байгуулах, сан бүрдүүлэх эх үүсвэр, мөнгөн хөрөнгийг хуваарилах ажиллагаа, 10602 дугаар зүйлд гэмт хэргийн хохирогчдод туслалцаа үзүүлэх, 10604 дүгээр зүйлд захиргааны үйл ажиллагаа явуулахтай холбогдсон заалт, 10605-р зүйлд гэмт хэргийн хохирогчийн албыг байгуулах, 10606-зүйлийг хүчингүй болгосон, 10607-р зүйлд хохирогчид туслалцаа үзүүлэх, 10608-р зүйлд гэмт хэргийн хохирогчийн шүүх хуралдаанд оролцуулахтай холбогдсон харилцааг тус тус зохицуулсан байна.

➤ Санхүүжилтын эх үүсвэр

Тус хөтөлбөрийг ХБНГУ-ын засгийн газрын төсвөөс санхүүжүүлдэг.

➤ Хохирогч нөхөн төлбөр авах эрх үүсэх шалгуур

Тус хууль нь ХБНГУ -ын нутаг дэвсгэрт санаатай хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч болж, улмаар эрүүл мэндээрээ хохирсон хүн нөхөн төлбөр авах хүсэлт гаргах эрхтэй. Нөхөн олговрыг авахын тулд хохирогч орлого олох чадварынхаа 25% ба түүнээс дээш хувийг алдсан байх ёстой<sup>73</sup>. Харин түр зуурын шинж чанартай буюу 6 сар хүртэлх хугацаанд эрүүл мэндийн хямрал, хэвийн бус байдалд байсан бол нөхөн олговор олгодоггүй<sup>74</sup>. Харин урт хугацааны эрүүл мэндийн гэмтэл, бэртэлд нөхөн олговор олгодог байна.

Гэмт хэргийн хохирогчдын нөхөн төлбөрийн тухай хуульд хүч хэрэглэсэн гэмт хэргийг хууль бус санаатай хүч үйлдсэн халдлага буюу санаатайгаар биед гэмтэл учруулах, хүчиндэх, бэлгийн хүчирхийлэл гэж тодорхойлсон байдаг. Эрүүл мэндийн өвчин зовиур нь зөвхөн тухайн хүчирхийллийн үйлдлээс шууд үүдэлтэй байх ёстой бөгөөд нөхөн олговор бие махбодийн болон/эсвэл сэтгэлзүйн гэмтлүүдийг хамруулдаг байх ба тэдгээр нь түр зуурын болон байнгын шинжтэй байж болно.

Гэмт хэргийн хохирогчдын нөхөн олговрын тухай хуулийн дагуу хүсэлт гаргах тохиолдолд Хохирогчдыг дэмжих байгууллага буюу *Versorgungsamt* шийдвэрлэдэг. Өөрөөр хэлбэл, хохирогчдын хүсэлт, гомдлыг хянан шийдвэрлэх явцыг зөвхөн ашгийн бус байгууллага болох *Weiser Ring* хэрэгжүүлж, сонгон шалгаруулалтыг явуулдаг байна. *Weisser Ring* ашгийн бус байгууллага нь гэмт хэргийн хохирогчдод олон төрлийн тусламж үйлчилгээ үзүүлдэг бөгөөд хохирогчдыг хохирлоо барагдуулахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий байгууллага юм. Иймд ХБНГУ-ын хохирол барагдуулах тогтолцооны нэг онцлог нь хохирогчдыг дэмжих, тэднийг хохирлоо барагдуулахад зөвөлгөө, туслалцаа үзүүлдэг байгууллагууд давхар

72 Victim compensation and assistant act.

73 DÜNKEL, F, Victim Compensation and Offender Restitution in the Federal Republic of Germany-A Western-European Comparative Perspective, *International Journal of Comparative and Applied Criminal Justice*, 9(1-2), 29-39, <https://doi.org/10.1080/01924036.1985.9688805>, 1985

74 DÜNKEL, F, Victim Compensation and Offender Restitution in the Federal Republic of Germany-A Western-European Comparative Perspective, *International Journal of Comparative and Applied Criminal Justice*, 9(1-2), 29-39, <https://doi.org/10.1080/01924036.1985.9688805>, 1985

ажилладаг байна. WEISSER RING бол Герман дахь хохирогчдод туслах үндэсний хэмжээний цорын ганц байгууллага юм<sup>75</sup>. WEISSER RING -ийн хохирогчдод үзүүлэх дэмжлэг нь гэмт хэргийн хохирогчдод үнэ төлбөргүй тусламж үзүүлэхэд оршино. Хохирогчдыг дэмжих ажилчид сайн дурын болон мэргэжлийн хувьд ганцаарчилсан туслалцаа үзүүлдэг. Тэд янз бүрийн амьдрал, ажлын туршлагатай бөгөөд хохирогч бүрийн нөхцөл байдлыг таниж, зохих туслалцаа үзүүлэхийн тулд холбоо барих хүн, хөтөчөөр ажиллахаар бэлтгэгдсэн байдаг.

WEISSER RING -ийн зорилго нь:

- Гэмт хэргийн хохирогч болон тэдний гэр бүлд яаралтай тусламж үзүүлэх
- Гэмтсэн хүмүүсийн эрх зүй, нийгмийн байдлыг сайжруулах талаар олон нийтийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, судалгаа хийх
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бүх нийтийн боловсролыг дэмжих
- Хохирогчийн хохирлын нөхөн төлбөрийг барагдуулах, гэмт этгээд-хохирогчийг эвлэрүүлэн зуучлахад туслалцаа үзүүлэх зэрэг болно.

Энэхүү байгууллага нь хохирогчдыг буцаад хэвийн ажил, амьдралд нь татан оролцуулахын төлөө ажилладаг бөгөөд хараат бусаар үйл ажиллагаа явуулдаг. WEISSER RING-ээс санал болгож буй тусламж нь үнэ төлбөргүй бөгөөд хохирогчдод туслах мэргэжилтнүүд сайн дурын үндсэн дээр ажилладаг. Энэхүү байгууллага нь хохирогчдын айдас, санаа зовнилыг сонсож, зөвлөгөө өгч, хүнд хэцүү үед нь дагалддаг байна.

Тус байгууллага нь эрүүгийн гэмт хэргийн нотлох баримт хангалттай бүрдсэн байна гэж үзвэл гэмт хэргийн бүх хохирогчдод өмнө нь гэмт хэрэг үйлдсэн, ял шийтгүүлсэн эсэхээс үл хамааран хохирогчид, хохирогчийн ойр дотны хүмүүс, болон гэмт хэргийн гэрч нарт тусламж үзүүлдэг.<sup>76</sup>

➤ Гомдол гаргах эрх бүхий этгээд

Хүч хэрэглэсэн гэмт хэргийн хохирогч, болон хүн амины гэмт хэргийн хохирогчийн гэр бүлийн гишүүдэд нөхөн олговор авах эрх нь үүсдэг. Хохирогч нас барсан бол ойр дотны хүмүүс нь эрүүл мэндэд хохирол учирсан эсэхээс үл хамааран тэжээгчээ алдсаны нөхөн олговор тогтоолгох эрхтэй байдаг. Мөн хэргийн газар гэмт хэргийн гэрч болж цочирдсоны улмаас эрүүл мэндээрээ хохирч буй хүмүүс болон аргагүй хамгаалалт хийсэн субъектүүд тус хуулиар хохирлоо барагдуулах эрхтэй. Тус хууль нь авто тээврийн улмаас үүдсэн гэмт хэргийн хохирогчдод нөхөн олговор олгодоггүй бөгөөд автомашины ослын улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх санд тусад нь өргөдөл гаргаж болно<sup>77</sup>.

Гадаад улсын иргэдийн хувьд Европын Холбооны улсуудын хооронд харилцан тохиролцсон хэлэлцээрийн үндсэн дээр зөвшөөрөгдсөн улсын иргэд нөхөн төлбөр авах эрхтэй байх ба ХБНГУ-д албан ёсоор 3 жилээс багагүй хугацаанд амьдарсан бол нөхөн төлбөр авах эрх үүснэ. Өөрөөр хэлбэл, энэхүү нөхөн олговрын хамрах хүрээ нь хохирогчдын тухайн улсад оршин суух хугацаа болон оршин суух зөвшөөрлийн төрлөөс хамаарна.

75 <https://weisser-ring.de/english>.

76 <https://weisser-ring.de/english>.

77 [https://www.gesetze-im-internet.de/englisch\\_oeg/englisch\\_oeg.html](https://www.gesetze-im-internet.de/englisch_oeg/englisch_oeg.html), Act on compensation to victims of violent crime. (Crime Victims Compensation Act – OEG)

Гэмт хэргийн хохирогчдын нөхөн төлбөрийн тухай хуулийн 5, 6 -р зүйлд:<sup>78</sup>

4- зүйл. 1: Европын холбооны иргэд Германы иргэдтэй адил эмчилгээ хийлгэх эрхтэй;  
 5-р зүйл. 1: Хохирогч 3 жил гаруй хугацаанд тасралтгүй Герман улсад хууль ёсны дагуу оршин суусан бол хүчирхийллийн улмаас хохирсон Герман хохирогчийн адил нөхөн төлбөр авах эрхтэй;  
 5.2: Хохирогч зургаан сараас гурван жилийн хугацаанд тасралтгүй Герман улсад түр болон хууль ёсны дагуу оршин суудаг бол Гэмт хэргийн хохирогчийн нөхөн төлбөрийн тухай хуулийн дагуу орлоготой холбоогүй тэтгэмжийг тэдэнд олгох боломжтой;  
 6. 1: Гуравдугаар зэрэгтэй холбоотой Германы иргэн эсвэл гадаадын иргэнтэй холбоотой хохирогчид. 4 ба 5 -р зүйлд заасны дагуу тодорхойлсон хүмүүсийн адил тэтгэмж авах эрхтэй. 5 үгүй. 2;  
 5. 6: Хэрэв гадаадын хохирогч Герман улсад дээд тал нь зургаан сар түр болон хууль ёсны дагуу оршин суудаг бол хүнд хэцүү асуудлыг шийдвэрлэхийн тулд түүнд нэг удаагийн төлбөр олгох боломжтой.

## ➤ Гомдол гаргах журам

Гомдол гаргах хугацааг хуулиар тогтоогоогүй боловч гэмт хэрэг гарснаас хойш 1 жилийн дотор гомдол гаргах хугацааг баримталдаг. Хохирогч гэмт хэрэг гарсан өдөр, байршил, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, гэмтлийн талаар цагдаагийн байгууллагад заавал мэдэгдэх ёстой байдаг.

Эрх бүхий байгууллага нь хэрвээ нөхөн төлбөр олгохоор шийдвэрлэгдвэл гэмт хэрэг гарсан өдрөөс биш өргөдөл гаргасан өдрөөс эхлэн хугацааг тооцож нөхөн олговрыг олгоно. Өргөдөл гаргагчийн өргөдлийг хүлээн авснаас хойш 6 сарын дотор гаргасан шийдвэрийн талаар өргөдөл гаргагчид мэдэгдэнэ.

## ➤ Нөхөн төлбөрийн хэмжээ ба олгох хязгаар

Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох дээд хязгаар байхгүй байна. Өөрөөр хэлбэл, нөхөн төлбөр олгох хэмжээг хуульд заагаагүй.

## ➤ Нөхөн олговрын хамрах хүрээ

Нөхөн олговрын хамрах хүрээг Холбооны Дэмжлэгийн тухай (Federal Support Act) хуулийн заалтуудын дагуу тодорхойлсон бөгөөд эмчилгээний болон, хохирогчдын тэтгэвэр, асрах тэтгэмж, яаралтай тусламж, амьжиргааны нэмэлт тэтгэмж, орон сууцны тэтгэмж гэх мэт халамжийн тэтгэмжийг хамарна. Нэмж дурдахад, тодорхой нөхцөлд хохирогчид тохиолдол бүрт нэмэлт тэтгэмж авах эрхтэй байж болно. Эдгээрийг хувийн дэмжлэг, биет хандив, мөнгөн тэтгэмж хэлбэрээр олгож болно.

Эрүүл мэндэд хохирол учирсан тохиолдолд эрүүл мэнд, гүйцэтгэлийн чадавхийг хадгалах, сайжруулах, сэргээх шаардлагатай арга хэмжээ авах, эдийн засгийн боломжийн дэмжлэг авах эрхтэй. ХБНГУ -ын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчид бие махбодийн болон сэтгэцийн эрүүл мэндийн бүх хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй. Эрүүл мэндэд учирсан хохирлын улмаас үүссэн эдийн засгийн хохирлыг орлогын байдлаас үл хамааран нөхөн төлдөг.<sup>79</sup> Хохирогчдын нөхөн олговор нь гэмтэл, өвчний хэлбэр, хүнд байдлыг харгалзан, тухайн хүний бодит хэрэгцээнд үндэслэгддэг. Тухайлбал, хохирлын улмаас үүдсэн туслах хэрэгсэл болох (протез, шүдний протез, тэргэнцэр), сэтгэл зүйн тусламж үйлчилгээний зардал, нөхөн сэргээлтийн зардал, хохирогчийн хөдөлмөрийн чадвар буурсан тохиолдолд тахир дутуугийн тэтгэмж, оршуулгын зардал, тэжээгчээ алдсаны тэтгэмж, өмнө нь ажиллаж байсан ажлаас олох байсан орлого зэргийг тооцон хохирлыг барагдуулдаг байна. Нөхөн олговрын хэмжээг Холбооны дайны хохирогчдын нөхөн төлбөрийн тухай хуульд заасан болно.<sup>80</sup>

78 [https://www.gesetze-im-internet.de/englisch\\_oeg/englisch\\_oeg.html](https://www.gesetze-im-internet.de/englisch_oeg/englisch_oeg.html). Act on compensation to victims of violent crime. (Crime Victims Compensation Act – OEG)

79 <https://www.kok-gegen-menschenhandel.de/en/human-trafficking/legal-framework-in-germany/crime-victims-compensation-act>

80 <https://www.bmas.de/EN/Social-Affairs/Socialcompensation-law/Socialcompensation-law-art.html>

## ШВЕДИЙН ХАНТ УЛС

➤ Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн төлүүлэх хууль тогтоомж

Швед Улсад гэмт хэргийн улмаас хохирсон этгээдэд олгох нөхөн олговрыг шүүхээс тогтоосон тохиолдолд гэмт хэрэгтэн этгээд өөрөөс нь, даатгалын байгууллагаас, эсхүл гэмт хэргийн хохирогчдод нөхөн олговор өгөх, дэмжлэг үзүүлэх байгууллагаар дамжуулан хохирогчийн хохирлыг барагдуулах засгийн газрын нөхөн олговрын төлөвлөгөөгөөр дамжуулан нөхөн олговор олгохоор зохицуулсан байдаг. Гэмт хэргийн хохирогчдын сангийн тухай хууль (1994: 419) нь 1994 онд анх мөрдөгдөж эхэлсэн бөгөөд өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байна. Тус хугацаанд нийт хоёр удаа нэмэлт өөрчлөлт орсон. Тус хууль нийт дөрвөн зүйлтэй бөгөөд хохирлын сантай холбоотой нарийвчилсан харилцааг Засгийн газраас баталсан журмын дагуу зохицуулдаг.<sup>81</sup>

➤ Хохирогч нөхөн төлбөр авах эрх үүсэх шалгуур

Сангаас нөхөн олговор олгохын өмнө юун түрүүнд хохирогч гэмт хэрэг үйлдсэн этгээдээс нөхөн төлбөр авахыг хичээх хэрэгтэй. Хэрэв гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь тогтоогдож, шүүхээс хохирлоо барагдуулахаар шийдвэрлэсэн бол Орон нутгийн шийдвэр гүйцэтгэх алба нь хохирлыг барагдуулах чиглэлээр ажиллана. Харин гэмт этгээд нь тодорхойгүй, эсхүл гэмт хэрэг үйлдсэн этгээд төлбөрөө төлөх ямар ч боломжгүй тохиолдолд аливаа даатгал нь хохирлыг нөхөж чадах эсэхийг шалгадаг байна. Энэ нь өрхийн даатгал, хамтын болон ганцаарчилсан ослын даатгал зэргээс боломжтой эсэхийг мөн шалгана. Тухайлбал, хохирогч ажиллаж байхдаа гэмт хэрэг үйлдсэн бол хөдөлмөрийн зах зээлийн даатгалын тогтолцоогоор нөхөн төлбөр авах боломж ихэвчлэн байдаг. Харин хохирогч төрөөс нөхөн олговрыг даатгал болон гэмт хэрэгтэн этгээдээс бүрэн авч чадаагүй тохиолдолд төрөөс авах боломж бүрдэнэ. Төрөөс нөхөн олговор авахын тулд тухайн гэмт хэрэг Швед Улсын газар нутаг дээр үйлдэгдсэн байх ёстой бөгөөд Швед Улсад байнга оршин суудаг эсэхээс үл хамааран оюутан, жуулчин ч байсан хамаагүй гэмт хэргийн хохирогч болсон тохиолдолд төрөөс нөхөн олговор авах эрхтэй.

➤ Санхүүжилтын эх үүсвэр

Нэг болон хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял оногдуулсан этгээдэд ямар гэмт хэрэг үйлдсэн байхаас үл хамаарч шийтгэх тогтоолд торгох ял оногдуулахаар заасан тохиолдолд энэ хуулийн дагуу хураамж төлөх бөгөөд хураамжийн хэмжээ нь 800 крон байна. Швед Улсын Эрүүгийн хуулийн 35 бүлгийн 7 дугаар хэсэгт заасан үндэслэлийн дагуу торгуулиас чөлөөлөгдвөл энэ хуулийн дээрх хураамжаас мөн адил чөлөөлөгдөнө. Дээрх хураамж нь хохирогчийн санг бүрдүүлдэг бөгөөд сангийн хөрөнгийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу гэмт хэргийн хохирогчдод зориулагддаг. Сангийн менежментийн зардлыг сангийн хөрөнгөөр нөхөх шийдвэрийг Засгийн газар гаргаж болно. Сангийн менежментийн талаар нарийвчилсан журмыг Засгийн газраас гаргадаг.<sup>82</sup>

Төрийн болон төрийн бус байгууллага нь сангийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд туслалцаа үзүүлэхээс гадна, гэмт хэргийн улмаас хохирсон этгээдтэй холбоотой мэдээлэл, судалгааг гүйцэтгэх боломжтой байдаг. Дээр дурдсанчлан сангийн

81 <https://www.government.se/government-agencies/crime-victim-compensation-and-support-authority/>

82 Гэмт хэргийн хохирогчдын сангийн тухай хууль (1994: 419), [https://www.riksdagen.se/sv/dokument-lagar/dokument/svensk-forfattningssamling/lag-1994419-om-brottsofferfond\\_sfs-1994-419](https://www.riksdagen.se/sv/dokument-lagar/dokument/svensk-forfattningssamling/lag-1994419-om-brottsofferfond_sfs-1994-419), (Сүүлд үзсэн: 2021.08.31)

гол үүсвэрийн нэг бол шүүхийн шийдвэрээр торгууль ноогдуулахаар тогтоосон гэмт хэрэгтэн этгээд бүрээс авах 800 крон. Тус санд жил бүр 30 сая орчим крон (ойролцоогоор 3,265,000 евро) цуглардаг.

➤ Гэмт хэргийн хохирогчид олгох нөхөн олговор (Brottskadeersdttning)

Гэмт хэргийн хохирогчдыг дэмжих газраар дамжуулан Швед Улсаас гэмт хэргийн нөхөн олговор авах боломжтой. Хохирогчид үүссэн хохирол нь гэмт хэргийн шинжтэй үйлдлээс үүдэлтэй байх ёстой бөгөөд дараах шаардлагыг хангасан байх шаардлагатай:

- (а) гэмт хэргийг цагдаагийн байгууллагад мэдэгдсэн байх,
- (б) Гэмт хэргийг гэмт этгээд бүрэн төлж, даатгалд хамруулж чадахгүй байх,
- (в) Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн олговрыг авах тухай өргөдлөө гэмт хэрэг үйлдсэн эсхүл мөрдөн ба урьдчилсан мөрдөн байцаалтын ажиллагаа дуусгавар болсноос хойш хоёр жилийн дотор гаргасан байх ёстой. Тус хугацаанд гаргаагүй бол хүндэтгэн үзэх шалтгааныг харгалзан үзнэ.

Дараах нөхцөл бүрдсэн тохиолдолд нөхөн олговор авч болно:

- а) Гэмт хэргийн шинжтэй үйлдлийн улмаас хохирогчид гэмтэл учирсан байх, дараах байдлаар илэрч болно;
  - эрүүл мэндийн үйлчилгээ, эм, гэмтсэн хувцасны зардал,
  - орлогоо алдах,
  - өвчин зовлон,
  - тахир дутуу, эрэмдэг зэрэмдэг болох
- б) Тухайн хувь хүний эсрэг гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд нөхөн олговор авах эрхтэй.
- с) Өмч хөрөнгийн эсрэг үйлдсэн гэмт хэрэг зарим тохиолдолд нөхөн олговор авах боломжтой байдаг. Тухайлбал, гэмт хэрэгтэн оргодол байсан эсхүл тусгай нөхцөлөөр шоронгоос болон бусад төрлийн төрийн байгууллагаас суллагдсан.

Хэрэв хохирогч гэмт хэргийн шинжтэй үйлдлийн улмаас нас барсан бол түүний нас барсан тухай мэдээнээс үүдэлтэй сэтгэл санааны хохирлыг болон хохирогчийг оршуулахтай холбоотой нөхөн олговрыг гэр бүл нь авах эрхтэй байдаг. Нөхөн олговорт багтсан зардлуудад:

- Эмчилгээний зардал
- Гэмт хэргийн улмаас гэмтсэн нүдний шил, сонсголын аппарат,
- Эмнэлэгт хэвтсэн зардал
- Байнгын хөгжлийн бэрхшээлтэй болсоны тэтгэмж
- Олох байсан цалингийн хэмжээ
- Тэжээгчээ алдсаны тэтгэмж
- Оршуулгын зардал
- Аялал жуулчлалын зардал
- Өвдөлт ба зовлон шаналалын нөхөн олговор
- Хувь хүний халдашгүй эрхийг зөрчихтэй холбоотой зардал
- Гэмтлийн улмаас үүссэн таагүй байдал зэрэгт нөхөн олговруудыг тооцон барагдуулдаг байна.

Гэр бүлийн гишүүнд сэтгэл санааны хохирлыг тооцож нөхөн олговор олгох асуудлыг 2006 онд шийдвэрлэж байсан бөгөөд тус шийдвэрийн хэрэгт гэмт хэргийн хохирогч толгой болон цээжин тус газраа хүнд бэртэл авсны улмаас 14 хоног амь насанд нь аюултай нөхцөл үүсэж, ухаангүй байсан бөгөөд, үүний дараа нас барсан байдаг. Хяналтын шатны шүүх хохирогчийн ээж сэтгэл санааны хохирлын нөхөн олговор авах эрхтэй эсэхийг шалгаж, нөхөн олговор олгохоор шийдвэрлэсэн байдаг.<sup>83</sup>

Гэмт хэргийн улмаас хохирсон этгээд төрөөс нөхөн олговор авахын тулд Гэмт хэргийн хохирогчдыг дэмжих газарт тусгай маягт бөглөх эсхүл интернэт дэх вэбсайтаар дамжуулан өргөдлөө илгээх шаардлагатай. Өргөдлийг хянан шийдвэрлэх хугацаа нь хэргийн шинж чанараас шууд хамааралтай байдаг бөгөөд ердийн хэргийг шийдвэрлэхэд хоёроос таван сар шаардлагатай. Харин эрх бүхий байгууллагатай холбогдох, эмнэлгийн үнэлгээ авах шаардлагатай гэх мэт илүү төвөгтэй тохиолдлууд удаан үргэлжилж болно. Гэсэн хэдий ч нэг жилээс илүү хугацаа шаардагдах тохиолдол ховор байдаг. Гэмт хэрэг үйлдэгдсэний, урьдчилсан мөрдөн байцаалтын ажиллагаа дууссанаас хойш гурван жилийн дотор тус өргөдлийг Гэмт хэргийн хохирогчийг дэмжих газарт илгээдэг. Эсхүл гэмт хэргийн улмаас насанд хүрээгүй этгээд хохирсон тохиолдолд тухайн этгээд 21 нас хүртэл Гэмт хэргийн хохирогчийг дэмжих газарт төрөөс нөхөн олговор авах өргөдлөө гаргах эрхтэй.

Ойр дотно хүмүүсийнхээ эсрэг ноцтой гэмт хэргийн гэрч болсон хүүхдүүдэд хохирлын сангаас нөхөн олговор олгохоор Эрүүгийн хохирлын тухай хуульд зохицуулсан.<sup>84</sup> Жишээлбэл, гэр бүлийн хүчирхийлэл, эцэг эхийн аль нэг нь гэр бүлийн бусад гишүүндээ хүч хэрэглэж буй үйлдэл. Нөхөн олговор олгохын тулд шүүхийн шийдвэр болон цагдаагийн мөрдөн байцаалт гэх мэт хэргийн бүртгэлд хүүхэд гэмт хэрэг үйлдсэнийг харсан, сонссон гэж тэмдэглэсэн байх шаардлагатай юм. Энэ төрлийн хохирогчийн нөхөн олговорт 5.000-60.000 крон хүртэл хохирлын сангаас авах боломжтой байдаг.<sup>85</sup>

➤ Гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор олгож буй жишээ

Хүчингийн гэмт хэргийн улмаас хөнгөн хэлбэрээр хохирсон этгээдэд одоогийн байдлаар ойролцоогоор 15.000 крон олгож байгаа бөгөөд тус нөхөн олговрын хэмжээ нь зургаан сарын турш өвчний хүнд үед эмчлэгдэж буй хохирогчийн эмнэлэгт өвчтэй байх үеийн хугацаанд тохирч байгаа юм. 2018 оны 7 дугаар сарын 1-ний өдөр Хяналтын шатны шүүх “Damages after the overnight stay” NJA 2019 буюу болгоомжгүй байдлаар бэлгийн харьцаанд орсон хохирогчид сангаас олгох нөхөн олговрын 10.000 крон олгохоор шийдвэрлэсэн.

Хохирлын сангаас олгох нөхөн олговрын хэмжээ нь хүчирхийлэлд өртсөн насанд хүрээгүй этгээдэд хүртэл ижил хэмжээгээр олгогдож байгаа юм. Хэрэв насанд хүрээгүй этгээд удаа дараа бэлгийн хүчирхийлэлд өртсөн тохиолдолд нөхөн олговрын хэмжээг 30.000 крон хүртэл өгөхөөр практик бий болсон байна.

83 <https://referatsamling.brottsoffermyndigheten.se/ersattning-for-sveda-och-vark/ersattning-for-sveda-och-vark-pa-grund-av-nara-anhorigs-dod-eller-svara-skada/>

84 Эрүүгийн хохирлын тухай хуулийн 9 дүгээр зүйл, [https://www.riksdagen.se/sv/dokument-lagar/dokument/svensk-forfattningssamling/brottsskadelag-2014322\\_sfs-2014-322](https://www.riksdagen.se/sv/dokument-lagar/dokument/svensk-forfattningssamling/brottsskadelag-2014322_sfs-2014-322), (Сүүлд үзсэн: 2021.09.01)

85 <https://referatsamling.brottsoffermyndigheten.se/sarskilt-om-brottsskadeersattning/brottsskadeersattning-till-barn-som-bevitnat-brott/>



Хяналтын шатны шүүх 2005 онд насанд хүрээгүй этгээдийг хүчирхийлсэн хэргийг шийдвэрлэсэн бөгөөд хохирогчид 50.000 крон нөхөн олгохоор шийдвэрлэсэн. Тус хэргийн хохирогч 7-14 нас хүртлээ хойд эцэгтээ 100 гаруй удаа хүчирхийлүүлсэн байдаг.<sup>86</sup>

Хэрэв гэмт хэргийн улмаас хохирогч хүнд гэмтэл авсан, эсхүл нас барсан тохиолдолд түүний гэр бүлийн гишүүнд 30.000 кронийг хохирлын сангаас олгож байгаа хэдий ч гэмт хэргийн шинж, үйлдсэн нөхцөл байдал зэргээс хамаарч хохирлын сангаас олгох нөхөн олговрын хэмжээг ихэсгэж болно. Тухайлбал, хяналтын шатны шүүх “The standardized relative allowance” NJA 2017 хэрэгт хохирлын сангаас 60.000 крон олгохоор шийдвэрлэсэн байна.<sup>87</sup>

Гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчид тусламж үзүүлэхэд хамтран ажилладаг төрийн болон төрийн бус байгууллага байдаг. Тухайлбал, цагдаа болон прокурорын байгууллага нь гэмт хэргийн хохирогчид түүний эрхийн талаар тайлбарлаж өгөх үүрэгтэйгээс гадна нөхөн олговор авах шаардлагыг бэлтгэхэд хохирогчид туслалцаа үзүүлнэ. Түүнчлэн тухайн нийгмийн хүрээллийн халамжийн байгууллага хохирогчид болон хохирогчийн гэр бүлд гэмт хэргийн улмаас хохирсон этгээдийн зүгээс туслалцаа, дэмжлэг үзүүлэх үүрэгтэй байдаг. Мөн эрүүл мэнд, эмнэлгийн үйлчилгээ эсхүл гэмт хэргийн хохирогчдод дэмжлэг үзүүлдэг олон нийтийн байгууллагад хандаж дэмжлэг авч болно.<sup>88</sup>

Гэмт хэргийн хохирогчдын сангийн зорилго нь гэмт хэргийн хохирогчдын нөхцөл байдлыг сайжруулахад чиглэсэн янз бүрийн үйл ажиллагаанд эдийн засгийн дэмжлэг үзүүлэх явдал юм. Өөрөөр хэлбэл, хохирогчид нөхөн олговор олгох харилцааг зохицуулахаас гадна хохирогчтой холбоотой бусад судалгаа, мэдээллийг бүрдүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх явдал юм. Жил бүр 30 сая орчим крон (ойролцоогоор 3,265,000 евро)-ийг тус сангаар дамжуулж, нийт 210 сая орчим крон (ойролцоогоор 22,845,000 евро)-ийг бусад үйл ажиллагаанд зориулсан байдаг.

## НОРВЕГИЙН ХАНТ УЛС

- Хохирлыг төрөөс нөхөн төлүүлэх хууль тогтоомж

Норвегийн Хант Улс нь Эрүүгийн гэмт хэргийн улмаас хүний биед учирсан хохирлыг төрөөс нөхөн олгох тухай хуулийг (Act on compensation from the state for personal injury caused by a criminal act (Victims' Compensation Act))<sup>89</sup> анх 2001 онд баталж байсан бөгөөд сүүлийн нэмэлт өөрчлөлт 2021 оны 6 дугаар сарын 29-ний өдөр орсон, өнөөдрийн байдлаар тус хууль дөрвөн бүлэг арван есөн зүйлээс бүрдэж хүчин төгөлдөр үйлчилж байна.

- Хохирогч нөхөн төлбөр авах эрх үүсэх шалгуур

86 <https://referatsamling.brottsoffermyndigheten.se/ersattning-for-sveda-och-vark/ersattning-for-sveda-och-vark-vid-sexuella-overgrepp/>

87 <https://referatsamling.brottsoffermyndigheten.se/ersattning-for-sveda-och-vark/ersattning-for-sveda-och-vark-pa-grund-av-nara-anhorigs-dod-eller-svara-skada/>

88 <https://www.brottsoffermyndigheten.se/utsatt-for-brott/stod-och-skydd/>

89 Швед Улсын Эрүүгийн гэмт хэргийн улмаас хүний биед учирсан хохирлыг төрөөс нөхөн төлөх тухай хууль, <https://lovdata.no/dokument/NL/lov/2001-04-20-13>, (Сүүлд үзсэн: 2021.09.06)

Амь нас, эрүүл мэнд, эрх чөлөөг зөрчсөн гэмт хэргийн улмаас бие махбодид нь хохирол учирсан этгээд, эсхүл амьд үлдсэн хүмүүс дээрх хуулийн дагуу төрийн сангаас гэмт хэргийн хохирогч болсон хохирлоо барагдуулах эрхтэй. Гэмт хэргийн улмаас хүний биед учирсан хохирлыг төрөөс нөхөн олгох сангаас мөн дараах тохиолдолд бие махбодид гэмтэл учирсан бол нөхөн олговор олгохоор зохицуулсан байна<sup>90</sup>:

- a. Хууль ёсны дагуу баривчлах, эсхүл баривчлахаар завдах явцад, мөн гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлсэн, урьдчилан сэргийлэх оролдлого хийсэн цагдаагийн байгууллага болон бусад цагдаагийн байгууллагын адил эрх хэмжээтэй байгууллагад туслалцаа үзүүлэх явцад;
- b. Амь нас, эрүүл мэнд, эрх чөлөөг нь зөрчсөн гэмт хэргийн хохирогч учрах хохирлыг багасгах зорилгоор тус үйлдлийг зогсоох, урьдчилан сэргийлэх эсхүл хязгаарлах үйл явцад туслалцаа үзүүлэхэд.

Гэмт хэргийн улмаас хүний биед учирсан хохирлыг төрөөс нөхөн олгох тухай хуулийн үйлчлэх хүрээнд 1961 оны 2 дугаар сарын 3-ны өдрийн “Автотээврийн хэрэгслээс үүдэлтэй хохирлын хариуцлагын тухай хууль”-ийн хүрээнд хохирсон этгээдэд хамаарахгүй болохыг хуулиар тодотгон заасан байна.

Дээрх хуульд заасны дагуу хохирлыг төрөөс нөхөн олгох тухай хууль Свальбардыг оролцуулан хаант улсад үйлдэгдсэн, Норвег Улсын нутаг дэвсгэрт хамаарах усан, агаарын орон зайд байгаа усан онгоц, агаарын хөлөг болон Норвегийн нутаг дэвсгэр дэх усан доорх байгалийн хурдас хайх, хөгжүүлэх байгууламж, талбайд гэмт хэрэг үйлдэгдсэн бол хохирогчид төрөөс нөхөн олговор олгохоор зохицуулсан байна. Хэрэв гэмт хэргийн улмаас гэмтсэн хүн эсхүл амьд үлдсэн хүн өөрийн гэмтэлтэй байх хугацаанд Норвег Улсад амьдрах тохиолдолд бол тусгай шалтгаанаар шаардлагатай бол дээр заасан нөхцөлд хамааруулан хохирогчид төрийн сангаас нөхөн олговор олгоно.

Төр гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчдод нөхөн олговор олгохдоо хохирогчийн гаргасан өргөдлийн дагуу олгох бөгөөд тус өргөдлийг<sup>91</sup> яамнаас тогтоосон хэлбэрийн дагуу Хохирогчид нөхөн олговор олгох албад гаргана. Яам өргөдлийн агуулгатай холбоотой нэмэлт дүрмийг тогтоож болно. Түүнчлэн нөхөн олговрыг гагцхүү гэмт хэргийн талаар цагдаад мэдэгдсэн тохиолдолд нөхөн олговрын сангаас олгох бөгөөд хохирогч гэмт хэрэгтний эсрэг хохирлоо барагдуулах хүсэлтээ гаргах хэрэгтэй.

Сангаас олгох нөхөн олговор нь хохирогчийн гэмтэлтэй байх үеийн бодит хохирол болон ирээдүйд олох орлого, гарах зарлагыг Хохирлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу олгоно. Хэрэв гэмт хэрэг үйлдэгдэх үед хохирогч 19 наснаас бага настай байсан тохиолдолд хохирогчид нөхөн олговрыг Хохирлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2а дахь хэсэгт заасны дагуу бага насны хүүхдэд нөхөн олговор олгох журмаар олгоно.<sup>92</sup>

90 Швед Улсын Эрүүгийн гэмт хэргийн улмаас хүний биед учирсан хохирлыг төрөөс нөхөн төлөх тухай хууль, <https://lovdata.no/dokument/NL/lov/2001-04-20-13>, (Сүүлд үзсэн: 2021.09.06)

91 “Хөөн хэлэлцэх хугацааны тухай хууль”-д заасан хугацаанд эсхүл Эрүүгийн хуульд заасны дагуу гэмт хэрэг үйлдэгчийн эрүүгийн хариуцлага хүлээлгэх хугацаа дуусахаас өмнө өргөдлийг хохирогчид нөхөн олговор олгох албад гаргана. Хэрэв хохирогч 21 насанд хүрээгүй этгээд байх тохиолдолд нөхөн олговор авах өргөдлийг хохирогч 21 нас хүртэл авч болно.

92 [https://lovdata.no/dokument/NL/lov/1969-06-13-26/KAPITTEL\\_3#%C2%A73-2a](https://lovdata.no/dokument/NL/lov/1969-06-13-26/KAPITTEL_3#%C2%A73-2a)

Хэрэв хохирогч байнгын болон их хэмжээний эрүүл мэндийн хохирол амссан бол тусгай нөхөн олговор олгоно. Нөхөн олговрыг тухайн хүний эрүүл мэндийн шинж чанар, хэмжээ, мөн хувийн амьдралаа хөгжүүлэх ач холбогдлыг харгалзан тодорхойлно. Нөхөн олговрыг тодорхойлохдоо хариуцлагын урьдчилсан тооцоог тооцох ёсгүй. Тахир дутуугийн зэрэг 15%-иас бага байвал нөхөн олговор олгодоггүй.

Тэжээгчээ алдсантай холбогдуулан сангаас олгох нөхөн олговрыг хэсэгчлэн болон бүрэн хэмжээгээр тухайн хугацаанд буюу гэмт хэргийн улмаас нас барсан хугацаанд нэн даруй олгоно. Нас барсан хохирогчийн гэр бүлийн гишүүн болон хамтран амьдарч байсан этгээд Хохирлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу өөрт учирсан хохирлоо шаардах эрхтэй. Хохирогч нас барсантай холбоотойгоор төрөөс олгох нөхөн олговорт оршуулгын зардал болон оршуулах үйл ажиллагаатай холбоотой үүсэх бусад зардал багтсан байх шаардлагатай. Түүнчлэн нас барсантай холбоотой нөхөн олговрын хэмжээ нь хуулийн 11 дүгээр зүйлд тусгасан хэмжээ, хязгаарын дотор олгохоор зохицуулсан байна.

Хуулийн 11 дүгээр зүйлд хохирогчид олгох нөхөн олговрын дээд болон доод хязгаарыг зохицуулсан байх бөгөөд хуульд заасны дагуу Үндэсний даатгалын тухай хуулийн 1-4 дэх хэсэг<sup>93</sup> заасан хэмжээг 60 дахин өсгөсөн хэмжээтэй дүйцхүйц нөхөн олговрыг олгохоор зохицуулсан. Хэрэв хохирогчид учирсан хохирлын хэмжээ 1.000 норвег кроноос бага байгаа тохиолдолд төрөөс тус хохирлыг нөхөн төлдөггүй. Дээр заасан хэмжээ нь нөхөн олговрын дээд хязгаар бөгөөд өргөдөл гаргасан бүх хохирогчид тус нөхөн олговрыг өгнө гэсэн ойлголт биш юм. Хэрэв хохирогч өөрт олгогдсон нөхөн олговрын хэмжээтэй санал нийлэхгүй байгаа тохиолдолд Хохирогчдод нөхөн олговор олгох зөвлөлд гаргах бөгөөд тус зөвлөлийн шийдвэрийг шүүхээр хянуулдаг. Энэ процесс зөвхөн гэмт хэрэгтний эсрэг нөхөн олговор авах нэхэмжлэл гаргаагүй тохиолдолд явагдана.

Хохирогчид олгох нөхөн олговрын сангаас дан ганц биед учирсан хохирлыг барагдуулахаас гадна тухайн гэмт хэргийн үед өмсөж байсан хувцас, гэмт хэргийн улмаас хиймэл эрхтэн хэрэг болсон зэрэг бусад хохирлыг барагдуулах нөхөн олговрыг төрийн сангаас гаргуулж болохоор зохицуулсан. Гэмт хэргийн улмаас хохирсон этгээдэд нөхөн олговор олгоход өвчтэй байх үеийн цалин болон түүнтэй адилтгах тэтгэмж болох нийгмийн даатгалын тэтгэмж, ажил эрхлэлт эсвэл мэргэжлийн тэтгэврийн төлөвлөгөөний тэтгэмжийг хасаж тооцдог. Хохирогчийн нөхөн олговрын хэмжээг гагцхүү Нөхөн олговрын тухай хуулийн 5-1 дэх хэсэг<sup>94</sup> заасны дагуу багасгаж болно. Тухайлбал, тус хуульд заасны дагуу гэмт хэргийн үед хохирогч шууд бус байдлаар өөрийн буруугаас болж гэмтсэн, эсхүл хохирогч шууд бус байдлаар тухайн гэмт хэргийн үед өөрт учирч болох байсан хохирлоо багасгах боломжтой байсан зэрэг нөхцөлүүд зохицуулагдсан байгаа юм. Хохирлын тухай хуулийн 1-1, 1-3, 5-3 дахь хэсэг<sup>95</sup> нөхөн олговрын хэмжээг багасгахыг хориглосон байна. Хохирлын тухай хуулийн 1-1 дэх хэсэгт 18 наснаас доош, 1-3 дахь хэсэгт субъектийн онцлог буюу галзуурсан, сэтгэцийн хоцрогдолтой, эсхүл өөрийгөө аваад явах чадваргүй этгээдийн учруулсан хохирлын талаар зохицуулсан.

93 Үндэсний даатгалын тухай хуулийн 1-4 дэх хэсэг, [https://lovdata.no/dokument/NL/lov/1997-02-28-19/KAPITTEL\\_2-1#%C2%A71-4](https://lovdata.no/dokument/NL/lov/1997-02-28-19/KAPITTEL_2-1#%C2%A71-4), (Сүүлд үзсэн: 2021.09.07)

94 Нөхөн олговрын тухай хуулийн 5-1 дэх хэсэг, [https://lovdata.no/dokument/NL/lov/1969-06-13-26/KAPITTEL\\_5#%C2%A75-1](https://lovdata.no/dokument/NL/lov/1969-06-13-26/KAPITTEL_5#%C2%A75-1), (Сүүлд үзсэн: 2021.09.07)

95 Хохирлын тухай хууль, [https://lovdata.no/dokument/NL/lov/1969-06-13-26/KAPITTEL\\_1#%C2%A71-1](https://lovdata.no/dokument/NL/lov/1969-06-13-26/KAPITTEL_1#%C2%A71-1), (Сүүлд үзсэн: 2021.09.07)

Гэмт хэргийн улмаас хохирсон этгээд өөрийн хохирлоо өв залгамжлалын журмаар шилжүүлж болох бөгөөд тус харилцааг Нөхөн олговрын тухай хуулийн 3-10 дахь хэсэгт заасны дагуу зохицуулна.<sup>96</sup>

Дээр дурдсанчлан хохирогчид нөхөн олговор олгох өргөдлийг Хохирогчдод олгох нөхөн олговрын алба шийдвэрлэдэг бөгөөд тус шийдвэртэй хохирогч санал нийлэхгүй байгаа тохиолдолд Хохирогчдод нөхөн олговор олгох зөвлөлд гомдол гаргаж болдог. Тус зөвлөл нь ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, мөн хоёр хувийн орлогч гишүүнээс бүрддэг бөгөөд тус бүрийг яамнаас 4 жилийн хугацаатай томилдог.

Өргөдөл гаргагчийн хэрэгт холбогдогч эсвэл хохирол учруулсан бусад хариуцагч нарын эсрэг нэхэмжилсэн нөхөн олговрыг энэ хуулийн дагуу төлсөн хэмжээгээр төрд шилжүүлдэг. Эхний хэсэгт заасан улсын нэхэмжлэлийг гэм буруутай нь нотлогдсон тохиолдолд, гэмт хэрэг үйлдэгчийн санхүү эсвэл бусад нөхцөл байдлыг харгалзан бүхэлд нь эсвэл хэсэгчлэн цуцалж болно. Хүчирхийллийн хохирогчдод нөхөн төлбөр олгох газар шүүхэд давж заалдах эсэхийг шийдэж, энэ хэргийг шийдвэрлэнэ.

Хохирлын сангаас нөхөн олговор авах гэж байгаа өргөдөл гаргаж буй хохирогч хэрэв нөхөн олговортой холбоотой буруу болон худал мэдээлэл өгсөн, эсхүл мэдээлэл нуун дарагдуулсан тохиолдолд хохирогчид олгосон нөхөн олговрыг буцаан шаардаж авах эрхтэй. Түүнчлэн хэрэв хохирогч нөхөн олговрыг бусад хэлбэрээр авсан тохиолдолд мөн адил төрөөс олгосон нөхөн олговрыг шаардаж авах эрхтэй. Тус асуудлын талаар хохирогчдод нөхөн олговор олгох алба шийдвэрлэдэг бөгөөд цугларсан нөхөн олговрын мөнгийг яам өөрөөр зохицуулаагүй бол Норвегийн төлбөр цуглуулах агентлаг цуглуулдаг.<sup>97</sup>

➤ Гомдол гаргах хугацаа

Гомдол гаргагч нь цагдаагийн байгууллагад 3 жилийн дотор гомдлыг гаргаж, тэрхүү гомдлыг Норвеги улсын Вардое хотод байрлах Хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчдын нэхэмжлэлийн алба хэмээх газарлуу хүргүүлдэг байна. Гомдол гаргагч нь өргөдөл гаргаснаас хойш 6 сарын дотор шийдвэрийн мэдэгдлийг хүлээн авна. Шийдвэр гарснаас хойш 1 хоногоос 3 долоо хоногийн хооронд нөхөн төлбөр олгодог байна. Шийдвэртэй санал нийлэхгүй байгаа тохиолдолд, Гэмт хэргийн хохирогчдод нөхөн олговор олгох зөвлөлд давж заалдаж болно.<sup>98</sup>

96 Нөхөн олговрын тухай хуулийн 3-10 дахь хэсэг, [https://lovdata.no/dokument/NL/lov/1969-06-13-26/KAPITTEL\\_3#%C2%A73-10](https://lovdata.no/dokument/NL/lov/1969-06-13-26/KAPITTEL_3#%C2%A73-10), (Сүүлд үзсэн: 2021.09.07)

97 Norwegian Central Collection Agency

98 <https://Www.Ssb.No/En/Sosiale-Forhold-Og-Kriminalitet/Kriminalitet-Og Rettsvesen/Statistikk/Anmeldte-Lovbrudd-Og-Ofre>

## Харьцуулсан дүгнэлт

Орчин үед дэлхий нийтийн техник технологийн өндөр хөгжилтэй уялдан хүн амын төвлөрөл, үйлдвэржилт, даяарчлал асар хурдацтай явагдаж, улмаар хүний амь нас, эрүүл мэнд, сэтгэл санаа, эд хөрөнгийн эрсдэл үүсч, гэмт хэргийн гаралтын түвшин ихсэж байна. Үүнтэй холбогдуулан хүний эрхийг хангах, түүний зөрчигдсөн эрхийг сэргээх үүднээс гэмт хэргийн улмаас учирсан хохирол, гэм хорыг арилгах асуудал, түүнийг хэрэгжүүлэх хууль эрх зүйн тогтолцоо дэлхий дахинаа улам боловсронгуй болон хөгжиж байна. Олон улсын жишгээс харахад байгалийн давагдашгүй гамшигт үзэгдэл, террорист, дайн, бослого үймээн зэрэг гэмт этгээд нь тодорхойгүй олох боломжгүй олон удаагийн нөхцөл байдлын улмаас төрөөс хохирогчдыг дэмжих, нөхөн олговор олгох зэрэг үндэсний тогтолцоог улам боловсронгуй болгож иржээ. Хохирлын хэмжээг бодитой тогтоох, нөхөн барагдуулах аргыг боловсруулахад тухайн улс орны онцлог, эдийн засгийн байдал, гэмт хэрэг гаралтын түвшин чухал байр суурийг эзэлж байна.

Хохирлын сангийн тогтолцоо нь тухайн улс орны онцлог, эдийн засгийн боломж бололцоо, үндэсний сэтгэхүйгээс шууд хамааралтай байгааг онцлох нь зүйтэй. Монгол Улсад 2012 оноос эхэлсэн Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн үндсэн чиглэлийн нэг нь хохирогч хамгаалах, хохирол барагдуулах тогтолцоо бүрдүүлж хэрэгжүүлэх явдал билээ. Гэмт хэргийн хохирол, хор уршгийг шударгаар барагдуулах, шаардлагатай тохиолдолд төрөөс хохирлыг төлүүлэх нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх төдийгүй, нийгмийн эмзэг бүлгийн хохирогчдын эрхийг хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэхэд чухал үр нөлөөтэй<sup>99</sup>. Иймд Монгол Улс нь байгалийн гамшигийн эрсдэл болон гэмт хэргийн гаралт бага, харьцангуй тайван орон болохынхоо хувьд төрөөс олгох нөхөн төлбөрийн хамрах хүрээ, хэмжээ нь маш бага бөгөөд нөхөн олговрын үндэсний тогтолцооны эрх зүйн зохицуулалт практик үйл ажиллагаа гадаадын хөгжингүй улс орнуудаас ихээхэн хоцорсон байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын хууль тогтоомжид гэмт хэргийн хохирогчийн эрх зүйн байдал нь олон улсын стандартад зарим талаар ойртож очсон боловч, ихэвчлэн тунхаглалын шинжтэй, хохирогчийн хохирлын нөхөн төлүүлэх механизм, зохион байгуулалт, эдийн засгийн баталгаа, бааз, суурь байхгүйн улмаас хүний эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн хэвээр байна.

Мөн гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх, учирсан хохирлыг арилгуулах талаарх заалт холбогдох хуульд хангалттай мэт боловч эдгээр нь зөвхөн тунхаглалын шинжтэй төдийгүй хэрэгжих механизм нь тодорхой бус. Олон улсын эрх зүйн стандарт, үндсэн зарчмуудтай харьцуулан үзэхэд гэмт хэргийн хохирогч нь төрөөс нийгмийн халамж тусламж авах, эрх бүхий байгууллагаас мэдээлэл авах эрх нь тодорхой тусгагдаагүйгээс гадна төрөөс нөхөн төлбөр авах, нөхөн олговор олгох асуудал олон улсын жишгээс хол хоцорчээ. Өөрөөр хэлбэл, хүн, хуулийн этгээд гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо барагдуулж, хор уршгаа нөхөн төлүүлж чадахгүй байсаар байна. Тус сангаас эмчилгээний болон оршуулгын зардал, хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг л олгохоор заасан нь гэмт хэргийн хохирогчийн хохирлыг хангалттай хэмжээнд, шударгаар нөхөн барагдуулах зарчимд бүрэн нийцээгүй гэж дүгнэж болох юм<sup>100</sup>.

99 Үндэсний Статистикийн Хороо. Гэмт Хэргийн Хохирогчийн Өнөөгийн Байдалд Хийсэн Баримтын Судалгаа. [https://1212.Mn/Booklibrarydownload.Ashx?Url=Victimization\\_Survey.Pdf&Ln=Mn](https://1212.Mn/Booklibrarydownload.Ashx?Url=Victimization_Survey.Pdf&Ln=Mn), 2014

100 Нээлттэй Нийгэм Форум, Эрүүгийн Хэрэг Хянан Шийдвэрлэх Тухай Хуулийн Дөчин Тавдугаар Бүлгийн Хэрэгжилт, Судалгааны Тайлан. ISBN: 978-9919-9742-7-5, 2021

Монгол Улсад гэмт хэргийн улмаас хохирогчийн эрхийг хангах чиглэлээр хууль зүйн зохицуулалт, түүнийг хэрэгжүүлэх арга барил шинэчлэгдээгүй, тодорхой аргачлал, журмуудыг шинээр батлан хэрэгжүүлээгүй, мөн хууль сахиулагчдын хуучин хэвшмэл хандлагаас шалтгаалж гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн эрхийг хангах, түүнийг нөхөн сэргээх байдал хангалтгүй байна. Иймд хууль тогтоогчийн үзэл санаа буюу хохирогчийн эрхийг хангахад ахиц дэвшил гаргах, хохирол, хор уршгийн төрөл хэмжээг үнэлж, түүнийг барагдуулах байдалд ахиц гаргах хуулийн зорилт үндсэндээ хэрэгжээгүй гэж судлаачид үзэж байна<sup>101</sup>.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг гэмт этгээд нөхөн төлж барагдуулах нь шударга ёсны зарчимд нийцэх хэдий ч зөвхөн зайлшгүй тохиолдолд төрөөс хохирлыг нөхөн барагдуулах төрийн хариуцлагыг Үндсэн хуулиар болон олон улсын эрх зүйн түвшинд баталгаажуулсан байна. Өөрөөр хэлбэл, онолын түвшинд үзэхэд төр нь гэмт хэргийн гаралтыг зогсоох, бууруулах, иргэдийгээ хамгаалах үүргийг хүлээсэн болохынхоо хувьд хохирогчдын эрх ашгийг сэргээх, нөхөн төлбөр барагдуулах тодорхой хэмжээний хариуцлагыг заавал үүрэх ёстой гэсэн чиг хандлагыг олон улсын түвшинд баримталж байна. Иймд төрөөс хохирогчдын эрх ашгийг нөхөн сэргээхтэй холбоотойгоор төрөөс зайлшгүй тохиолдолд барагдуулах тухай тусгай хууль тогтоомжтой байгаа бөгөөд гэмт хэргийн хохирогч нарт туслалцаа үзүүлэх төрийн болон төрийн байгууллагуудыг байгуулж, төрөөс дэмжлэг үзүүлж байна. Олон улсын түвшинд төрөөс хохирол барагдуулах сангийн эх үүсвэрийг гэмт этгээдээс хэсэгчлэн санхүүжилт авах аль эсхүл татвар төлөгчдийн мөнгөөс буюу улсын төсвөөс 100% санхүүжүүлэх зэрэг 2 үндсэн загвар схем байгаа юм.

Энэхүү судалгаанаас дүгнэвэл, эх газрын эрх зүйн тогтолцоо болон англи-саксоны эрх зүйн тогтолцоотой тогтолцооны онцлогоос үл хамааран гадаадын улс орнууд төрөөс хохирлыг барагдуулах тухай нийтлэг асуудлуудад анхаарлаа хандуулж байна. Энэ нь гэмт хэргийн улмаас хохирсон хохирлыг нөхөн төлүүлэх шаардлага, шалгуур үзүүлэлт, гэмт этгээд болон хохирогчдод тавигдах шаардлага, хамрагдах боломжийн талаар зэрэг үндсэн асуултуудад хариулахыг эрэлхийлж байна. Тухайлбал, Европын Холбооны орнуудын хувьд “бэлгийн хүчирхийлэл” зэргийг оролцуулан “санаатай хүч хэрэглэсэн гэмт хэрэг” -т холбогдох хохирогчдод нөхөн төлбөр олгохоор зохицуулсан байгаа хэдий ч эд хөрөнгийн хохиролтой холбоотой гэмт хэргийг хохирлыг нэг сангаас гаргуулахгүй байх нийтлэг зохицуулалт байгааг онцлох нь зүйтэй. Манай Монгол Улсын хувьд ч адил төстэй эрх зүйн зохицуулалттай байгаа буюу тухайлбал, хадгаламж, зээлийн хоршооноос хохирсон хохирогчдын хохирлыг Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай хуулиар зохицуулж байна. Харин төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас үүссэн хохирлыг Засгийн газрын тусгай сангаас гаргуулж буй практик байгаа бөгөөд, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангаас гаргаж буй тус тусдаа зохицуулалт байгааг анзаарах нь зүйтэй. Харин манай Монгол Улсад зөвхөн “Эрүүгийн хуульд заасан зарим гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн хууль ёсны төлөөлөгч, хүнд гэмтэл учирсан хохирогчид нөхөн төлбөр олгоход зарцуулна” хэмээн хуульчилсан байна. Гэвч ЭХХШтХ 45.2-р зүйлийн 1 дэх хэсэгт “Хүнийг хууль бусаар ял шийтгэсэн, баривчилсан, цагдан хорьсон, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлсэн, эмнэлгийн байгууллагад байлгасан, албадан эмчлэх арга хэмжээ хэрэглэсэн, эрүүдэн шүүсний улмаас учирсан хохирлыг мөрдөгч, прокурор, шүүгчийн гэм бурууг үл харгалзан төр хариуцан арилгана.”

101 Нээлттэй Нийгэм Форум, МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРЛЫГ ҮНЭЛЖ, ТОГТООЖ, НӨХӨН ТӨЛҮҮЛЖ БУЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ, 2021

хэмээн заасан нь төрөөс өөрт учирсан хохирлоо шаардах, нөхөн төлүүлэх эрхийг зохицуулж, улмаар уг эрхийг хангах үүргийг төрд хариуцуулсан байгаа ч яг аль сангаас барагдуулах нь маш тодорхойгүй, хэрэгжүүлэх тухай хууль зүйн зохицуулалтгүй байгаа бөгөөд тус гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах хохирлын сангаас мөн олгохоор хуульчлан зохицуулаагүй байна. Иймд тус сангаас хохирлыг барагдуулах хүрээ хэт хязгаарлагдмал байгаа төдийгүй ЭХХШтХ болон Хохирлын сангийн тухай хуулийн нийцлийг хангах шаардлагатай байна.

Зарим улс орнуудад шүүхийн өмнөх болон шүүхийн шатанд эрх нь зөрчигдсөн төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг гэмт хэргийн хохирогчдод олгох сангаас олгох хууль эрх зүйн нэгдмэл байдлыг хангасан бол зарим тохиолдолд төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг барагдуулна гэхээсээ илүү эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад үүссэн хууль бус, буруутай үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулна хэмээн ялган зохицуулсан онцлогтой байна.

Мөн гэмт хэргийн төрлөөр ангилснаас гадна, мөн төрөөс нөхөн төлбөр авахад зохимжгүй (undeserving victims) (inappropriate) хохирогчдыг нарийвчлан тодорхойлсон байна. Тухайлбал, гэмт этгээдрүү дайрсан зүй зохисгүй үйлдэл хийсэн, зодоон цохионд сайн дураараа оролцсон, түрэмгий үйлдэл хийж заналхийлсэн, эсхүл гэмт хэргийн үйл явдлыг өдөөн хатгасан, нөлөөлсөн тохиолдолд “нөхөн төлбөр хүртэх эрхгүй хохирогч” хэмээгээд хохирогчид тодорхой шалгуур тавьсан байгааг манай хууль тогтоогч нар анхааран үзэж, хууль тогтоомждоо шинээр тусгах нь зүй ёсны хэрэг болоод байна.

Хохирлын сангийн тогтолцоог бүрдүүлэхэд хохирогч төр 2-ыг зуучлах байгууллага буюу хохирогчид зөвлөгөө өгдөг, өргөдлийг хүлээн авдаг Цагдаагийн байгууллагаас гадна, хохирогчийг дэмжих алба, төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран ажилладаг бөгөөд улмаар хохирол нөхөн барагдуулах тогтолцоо, болон түүний хамрах хүрээ өргөсөж, үр дүнгээ өгөх ач холбогдолтой байна. Тухайлбал, гадаадын улс орнуудын туршлагаас харвал төрөөс нөхөн олговор олгох тухай мэдээллийг анхан шатны нэгж болох Цагдаагийн байгууллага хариуцан ажиллах, өргөдлийн маягтыг хохирогчдод өгөх, төрөөс нөхөн олговор авах боломжийг талаар танилцуулан сурталчлах, хохирогчдод чиглэл өгөх зэрэг олон талт чиг үүргийг ноогдуусан байгаа нь олон улсад ажиглагдаж байна. Тус өргөдлийн шаардлагыг хангасан гэж үзвэл Хохирол нөхөн барагдуулах зөвлөлд, Хохирлын нөхөн олговрын албад дамжуулан өгдөг бөгөөд өргөдлийг хянан хэлэлцэж эцсийн байдлаар дүгнэлт гаргадаг тусгай чиг үүрэг бүхий хараат бус байгууллага байдаг юм. Зарим тохиолдолд тухайлбал, БНСУ-д Прокурорын байгууллагын дэргэд тусгай чиг үүрэг бүхий Хохирол нөхөн төлүүлэх алба шийдвэрлэдэг байна. Ингэснээр өргөдөл гомдол түргэн шуурхай шийдвэрлэгдэх үндэс, суурь нь болж байгаа төдийгүй ихэнхи тохиолдолд хэрэг гарсан өдрөөс эхлэн гэмт этгээдийн хохирлыг нөхөн төлөх боломж бололцоог судлан, хэрэв гэмт этгээд олдохгүй зэрэг шалтгаантай байгаа тохиолдолд анхан шатны нэгж болох Цагдаагийн байгууллагаас өргөдлийн маягтыг авч, цаг алдалгүй зохих шийдвэр гаргах эрх бүхий байгууллагад дамжуулан өгдөг нь сайшаалтай байна.

Харин манай Монгол Улсад зөвхөн шүүхийн шийдвэр гарсны дараа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас өргөдлийн маягтыг авдаг ялгаатай зохицуулалт байна. Төрөөс нөхөн олговрын олгох тухай талаар хэргийн хамгийн сүүлийн шатанд шийдвэрлэдэг нь хохирогчийн эрх ашгийг зөрчих нөхцөлийг бүрдүүлж байна. Мөн иргэд хаанаас маягтыг авах, хаана өгөх, хэн хариуцах тухай нарийвчилсан мэдээлэл дутмаг байхаас гадна төрөөс хохирлыг барагдуулах тухай хяналт тавьж,

хохирогчдыг чиглүүлж өгөх субъект тодорхойгүй. Өөрөөр хэлбэл, хохирлыг төрөөс барагдуулах тухай хүсэлтийг зуучлан холбох байгууллага байхгүй. Улмаар иргэд төрөөс нөхөн олговор авах боломжийн талаар мэдлэггүйгээс болж зохих байгууллагад хүсэлт, өргөдөл өгдөггүй байх нөхцөлийг бүрдүүлэх үндэслэл болж байна.

Иргэдийн гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргийн улмаас учирсан материаллаг болон сэтгэл санааны хохирлыг нөхөн барагдуулах нь төрийн болон нийгмийн чухал чиг үүрэг юм. Гэвч Засгийн газрын тусгай сангийн 13-дугаар зүйлд зааснаар зөвхөн хохирогчийн эмчилгээний зардал, оршуулгын зардал; хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлого хэмээн хязгаарлан зохицуулсан нь сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийг орхигдуулах, бодит хохирлыг тооцохгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Гэвч гадны жишгээс харвал, тухайлбал, БНСУ-д төрөөс дээрхээс гадна тэжээгчээ алдсаны тэтгэмж, сургалтын төлбөр, сэтгэл зүйн эмчилгээний төлбөрийг тооцон нөхөн олговорт багтааж буй нь бодит хохирлыг бүрэн хэмжээгээр олгох хууль эрх зүйн орчинг бүрдүүлсэн байна.

Мөн Монгол Улсад төрөөс нөхөн олговор олгох тухай тусгай чиг үүрэг бүхий тогтмол үйл ажиллагаа явуулдаг тусгай эрх бүхий байгууллага байхгүй буюу зөвхөн ерөнхий чиг үүрэг бүхий Аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шүүхийн шийдвэр гарсны дараа өргөдлийг өгөхөөр хуульчлан зохицуулсан байна. Энэ нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хариуцуулсан төдий боловч тэр чиглэлээр дагнан, тогтвортой үйл ажиллагаа явуулдаггүйн улмаас өргөдлийг хянан хэлэлцэх хугацааг удаашруулж, хүнд сурталд автагдах, хохирогчдыг залхаах, нөхөн олговор олгох хугацааг алдах зэрэг олон асуудлыг дагуулж буйг дурдах нь зүйтэй. Аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь өргөдлийг хянан хэлэлцэж, зохих шийдвэрийг ХЗДХЯ-д хүргүүлж ХЗДХЯ-ны сайд нь эцсийн шийдвэрийг гаргадаг байх нь хүнд суртлыг дагуулах, хугацаа алдах эрсдэлийг дагуулж байна. Харин гадаад улсад төрөөс хохирол нөхөн төлүүлэх зөвлөлөөс гарсан шийдвэрт санал нийлэхгүй байгаа тохиолдолд хохирогч нь дээд шатны байгууллага болох Нөхөн олговрын ерөнхий зөвлөлд давж заалдах эрхийг нь хуульчлан зохицуулсан байдаг бөгөөд энэ нь тусгай чиг үүрэг бүхий байгууллагад хурдан шуурхай авч хэлэлцэх боломжийг агуулж байна. Харин Монгол Улсад давж заалдах эрх, түүнийг шийдвэрлэх эрх бүхий байгууллагыг Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох журам-7.1-д зааснаар “Өргөдөл гаргагч нь нөхөн төлбөр олгох ажиллагаатай холбоотой гомдлоо шүүхэд гаргаж болно” хэмээн тодорхойгүй, ойлгомжгүй байдлаар хуульчлан зохицуулсан байгаа нь хохирогчийг залхаах, мухардалд оруулах нөхцөлийг үүсгэж байна гэж дүгнэж байна.

Мөн Монгол Улсын хувьд төрөөс нөхөн олговор олгох зохицуулалтын хамрах хүрээ нь хэт хязгаарлагдмал бөгөөд хохирогчид гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо ямар тохиолдолд төрөөс барагдуулах эсэх, ямар үндсэн шалгуур тавигдаж байгаа эсэх нь тодорхойгүй буюу тогтсон стандарт байхгүй байна. Нөхөн олговор олгохгүй байх үндэслэлийг Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох журмын 7.1-д заасан бөгөөд “Өргөдөл гаргагч нь хуурамч бичиг баримт бүрдүүлсэн, эсхүл гэм буруутай этгээд болон түүний хууль ёсны төлөөлөгч хохирлыг бүрэн барагдуулсан бол нөхөн төлбөр олгохоос татгалзаж өргөдөл гаргагчид хариу мэдэгдэнэ” хэмээн заасан нь судлагдсан орнуудын хууль тогтоомжтой адил нийтлэг зохицуулалттай байгаа хэдий ч хэт ерөнхий буюу нөхөн олговор олгохыг татгалзах үндэслэлүүдийг нарийвчлах, хамрах хүрээг ил тод байдлаар өргөжүүлэх шаардлагатай байна. Хохирлын нөхөн олговрыг олгохоос ямар тохиолдолд татгалзах, ямар тохиолдолд бүтэн болон хэсэгчлэн олгох тухай стандарт шалгуурыг журамлан тогтоогоогүй



байгаа нь олон нийтэд хардлага төрүүлэх, нийгэмд тодорхойгүй байдал үүсгэх, хохирогчдод эрх тэгш хандах зарчмыг зөрчих нөхцөлийг бий болгож буй байгаа бөгөөд шийдвэр гаргагч эрх бүхий этгээд зөвхөн өөрийн дотоод үзэмжээр хохирол барагдуулах тухай шийдвэр гаргах нөхцөлийг бий болгож буйг дурдах нь зүйтэй. Мөн гадны улсуудын хууль тогтоомжид шийдвэр гарснаас хойш тодорхой хоногийн дотор нөхөн олговрыг хохирогчид шилжүүлнэ гэж нарийвчлан заасан байдаг бол манай улсад тэр хугацааг хуульчлан зохицуулаагүй байгаа нь хохирогчдод тодорхойгүй байдал үүсгэх хандлагатай байна.

Олон улсын жишгийг харахад, тухайлбал, БНСУ-д нөхөн олговрыг ямар нөхцөлд олгох, олгохгүй байх тухай нарийвчлан хуульчлан зохицуулсан байгаа нь хохирогчдод эргэлзээ төрүүлэхгүй байх, шийдвэр гаргах нөхцөлийг хөнгөвчлөх нөхцөлийг бүрэлдүүлж байгаа юм. Мөн тус хуулиар төрөөс нөхөн олговор авах эрх бүхий этгээдийг маш нарийвчлан тогтоосон байна. Тухайлбал, нөхөн олговор авах эрх бүхий субъектүүдийг ерөнхийлөн заасан байгаа бөгөөд гэр бүлийн гишүүдийг эрэмбэ дарааллаар нь ангилснаас гадна гэдсэнд бүрэлдэж буй үр хөврөлд хүртэл нөхөн олговор авах эрхтэйг заасан онцлогтой байна. Мөн нөхөн олговор авах хүсэлт гаргасан этгээд нь нийгмийн зан суртахууны хэм хэмжээг зөрчсөн буюу гэмт хэрэгт холбогдож байсан, шалгагдаж байгаа эсэхийг урьдчилан тогтоодог бөгөөд зохих гэмт хэргийг мэдээллээгүй байх зэрэг түүхтэй байвал нөхөн олговрыг олгохгүй байхаар хуульчилсан байна.

Мөн зөвхөн гэмт этгээд буруутай нь нотлогдож шүүхийн ял шийтгэл авсан тохиолдолд сангаас нөхөн олговор олгохоор заасан нь гэмт этгээд олдоогүй, тодорхойгүй тохиолдолд хэрхэх тухай зохицуулалтгүй байна. Гэвч гадаадын хууль тогтоомжид гэмт этгээд нь олдоогүй аль эсхүл сэтгэцийн өвчтэй байгаа тохиолдолд төрөөс нөхөн олговор олгодог сайн жишиг байна. Монгол Улсад гэм буруутай гэдэг нь нотлогдоогүй буюу цагаатгагдсан, гэмт этгээд тодорхой бус тохиолдолд хохирогч хохирч үлдсэн хэвээр байгаа тул энэ тохиолдолд төрөөс учирсан хохирлыг хөнгөвчлөх нь Эрүүгийн хууль болон ЭХХШТХ-ын үзэл баримтлал, тавьсан зорилго зорилгод хүрэх алхам болох учиртай. Мөн гэмт этгээд бүрэн нотлогдохгүй байх тохиолдолд хохирогчийн хохирлыг гаргуулах, хохирогчийн гомдлыг тайлах үүднээс зайлшгүй хэн нэгнийг яллах, гүтгэх, хэлмэгдүүлэх зэрэг эрсдэл харьцангуй багасах нөхцөл үүсэх бөгөөд улмаар шүүгч болон прокурорын байгууллагын үйл ажиллагаа хуулийн дагуу, хараат бус явагдах нөхцөл бүрдэнэ.

Хохирлын сангийн тогтолцооны маш чухал хүчин зүйл нь санхүүжилтын эх үүсвэр юм. Санхүүжилтын эх үүсвэрээс шалтгаалж хохирлын сангийн хэв маяг шинэчлэгдэн өөрчлөгдөж, улс орон болгон өөр өөр төрлийн хохирлын сангийн тогтолцоо, санхүүжилтын схемтэй байгаа нь энэхүү харьцуулсан судалгаагаар харагдаж байна. Монгол Улсад Гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох журам-д зааснаар "... гэм буруутай этгээдээр буцаан төвлөрүүлнэ" гэж заасан нь бусад улсын хууль тогтоомжоос, онцлог ялгаатай байгаа бөгөөд зөвхөн Казахстан улсын гэмт этгээдээс хохирлын сангийн буцаан төвлөрүүлэлттэй адил байна. Энэ тохиолдолд гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулж байна гэж хэлэхэд тохиромжгүй байгаа бөгөөд энэ нь гэмт этгээд нь шууд бус замаар хохирлыг барагдуулж байна гэж үзэж болох юм. Зарим тохиолдолд буюу Япон улс нь хохирлын санд хандив тусламж өгөх нээлттэй байдлаар санхүүжилтын эх үүсвэрийг хуульчлан зохицуулсан онцлогтой байгааг дурдах нь зүйтэй. Харин хөгжингүй улсын хууль тогтоомжин хувьд цэвэр улсын төсөв буюу Улсын татварын мөнгө, төсвийн орлогоос хохирлын сангийн санхүүжилтыг олгодог нийтлэг жишигтэй байна.

Монгол Улсад хүний амь нас, эрүүл мэнд, сэтгэл санаанд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шийдвэрлэхдээ зөвхөн нотлох баримтад тулгуурлаж байгаа тул эмчилгээ, оршуулга, тээврийн зардлын баримт зэрэг хохирогчийн цуглуулсан нотлох баримт дээр харгалзан хохирлын хэмжээг тогтоож байна. Харин олон улсад хохирогчийн оролцоогүйгээр Татварын алба зэрэг холбогдох төрийн байгууллагуудаас шууд мэдээлэл авсны үндсэн дээр орлого, цалин, олж болох байсан орлогыг тогтоож буй хүнд суртал, цаг хугацаа хэмнэсэн сайн жишиг байгааг дурдах нь зүйтэй.

## САНАЛ

Судалгаагаар авч үзсэн асуудлын хүрээнд олон улсын чиг хандлага, болон үзэл баримтлал, олон талт онолуудыг харгалзсаны үндсэн дээр, аль онол, бодлогын баримтлалыг баримтлахаас шалтгаалан гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс барагдуулах тухай тогтолцоо болон холбогдох хууль тогтоомжийг зайлшгүй шинэчлэн найруулж, нэмэлт өөрчлөлт оруулах дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- Монгол Улсад гэмт хэргийн хохирол барагдуулах үндэсний тогтолцоог бий болгох. Энэ нь Хохирлын сангийн тухай хууль хэлбэртэй байх боломжтой бөгөөд энэ сангаар дамжуулан гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох тухай зохицуулалт хийх;
- Хуулийг боловсруулах, хуульд нэмэлт өөрчлөлт оруулахад нэр томъёоны хэрэглээнд анхаарах. Өөрөөр хэлбэл, “Хохирлын сан” гэж нэрлэх бус харин “Нөхөн төлбөрийн сан” гэж нэрлэх нь зүйтэй байж болох юм.
- Хохирлын сангийн санхүүгийн эх үүсвэрийг гэмт хэргийн хохирлын даатгалд иргэдийг хамруулах замаар, мөн торгох, эд хөрөнгө хураах ялын орлого болон бусад захиргааны торгууль, ААХЯ-ыг хөлстэй гүйцэтгэж, хөлсийг санд оруулах замаар, мөн төсвөөс тодорхой хэмжээгээр санхүүжүүлэх гэх мэт аргаар эх үүсвэрийг бүрдүүлэх боломжийг нарийвчлан судлах
- Гэмт этгээд олдоогүй, аль эсвэл сэтгэцийн өвчтэй тохиолдолд хохирол нөхөн төлүүлэлт хийгддэггүй учир энэ тохиолдолд хохирлыг төрөөс зайлшгүй барагдуулахаар зохицуулах
- ЭХХШТХ-ын 45.1-р зүйлд заасан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас учирсан хохирлыг төрөөс барагдуулах гэж заасантай уялдуулан хамрах хүрээг өргөсгөх
- Цагдаагийн байгууллагаас төрөөс нөхөн олговор олгох тухай мэдээллийг иргэдэд ойлгуулан түгээх чиг үүргийг бий болгох, сурталчлан таниулах
- Хохирлын сангаас нөхөн төлбөрийн хамрах хүрээг өргөсгөж, сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийг олгохоор зохицуулалтыг бий болгох
- Нөхөн төлбөр олгох асуудлыг хэлэлцэх орон тооны бус Зөвлөлийг халж, харин орон тооны байнгын чиг үүрэг бүхий Зөвлөлийг бий болгох;
- Төрөөс нөхөн төлбөр олгох шийдвэр гарснаас хойш нөхөн олговрын олгох хугацааг нарийвчлан зохицуулах
- Хохирогчийн гэр бүл гэж ямар хүмүүсийг хамруулах тухай нарийвчлан зааж, ангилан, эрэмбэлэх
- Хохирлын сангаас ямар тохиолдолд нөхөн олговор олгох боломжтой болон боломжгүй эсэх талаар нарийвчлан зохицуулах
- Эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг шүүхийн бус байгууллагаар хянан хэлэлцүүлэх боломжийг бий болгох
- Гэмт этгээдэд тавигдах шалгуураас гадна нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахуунд харшлах үйлдэл хийгээгүй, гэмт этгээдрүү заналхийлэн дайраагүй байх, гэмт хэрэгт хамтран оролцоогүй байх зэрэг төрийн сангаас нөхөн төлбөр авах хохирогчийн шалгуур үзүүлэлтийг хуульчлан тогтоох

Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хууль  
(Crime victim protection act<sup>102</sup>)

4 дүгээр зүйл (Төрийн үүрэг хариуцлага)

Гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах, дэмжих чиглэлээр дараах арга хэмжээг авч, төр шаардлагатай санхүүгийн эх үүсвэрээр хангах үүрэгтэй.

1. Гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах, дэмжих системийг бий болгох;
2. Гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах, дэмжих өнөөгийн нөхцөл байдлын талаархи судалгаа, сурталчилгааг хийх;
3. Гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах, дэмжих талаар холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгож, олон талт бодлого боловсруулан хэрэгжүүлэх.

5 дугаар зүйл (Орон нутгийн засаг захиргааны хариуцлага)

(1) Орон нутгийн засаг захиргаа гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах, дэмжих талаар идэвхтэй ажиллаж, гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, дэмжих талаар төрөөс баримтлах бодлогыг жигд биелүүлэхэд хамтран ажиллах болно.

(2) Орон нутгийн засаг захиргаа (1) дэх үүргээ биелүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрээр хангана.

6 дугаар зүйл (Иргэдийн үүрэг хариуцлага)

Иргэд гэмт хэргийн хохирогчийн нэр хүндийг гутаах, хувийн нууцад халдахаас зайлсхийж, гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах, дэмжих бодлогыг жигд боловсруулж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийн тулд муж, орон нутгийн засаг захиргаатай хамтран ажиллах ёстой.

IV БҮЛЭГ Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг хөнгөвчлөх

16 дугаар зүйл (Хохирлын нөхөн олговрыг олгох шаардлага)

Хэрэв хохирогч дараах шаардлагыг хангавал, төр хохирогчид болон түүний гэр бүлд, нас барсан хүний гэр бүлийнхэнд гэмт хэргийн хохирлыг арилгах сангаас (relief fund) нөхөн олговор олгоно. (цаашид «тусламжийн сан» гэх):

1. Гэмт этгээдээс гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах зохих нөхөн олговрыг бүтэн буюу хэсэгчлэн авах бололцоогүй тохиолдолд сангаас олгоно;

2. Шүүхийн урьдчилсан шатны ажиллагаа болох эрүүгийн хэргийн мөрдөн байцаалт, эсхүл шүүх хуралдааны явцад хүний эрх зөрчигдөж, хохирогч болсон тохиолдолд сангаас нөхөн олговрыг олгоно.

17 дугаар зүйл (Тусламжийн сангийн төрөл)

(1) Тусламжийн санг амиа алдсан хохирогчий

н гэр бүлийн тусламжийн сан, тахир дутуугийн тусламжийн сан, хүнд гэмтэл бэртлийг арилгах сан гэж тус тусад нь ангилж, нэг удаагийн нөхөн төлбөр олгоно.

(2) Гэр бүлийн тусламжийн санг хохирогчийн нас барах үед 18 -р зүйлд заасны дагуу хохирогч нас барсан гэр бүлийн гишүүнд олгох ёстой. Гэр бүлийн гишүүдэд тус бүр тэнцүү хэмжээгээр олгоно.

(3) Тахир дутуугийн тусламжийн сангаас зөвхөн хүнд гэмтэл бэртэлтэй буюу тусламж зайлшгүй шаардлагатай хохирогчдод олгоно.

18 дугаар зүйл (Нас барсан гэр бүлийн гишүүдийн хамрах хүрээ, дэс дараалал)

(1) Нас барсан хохирогчийн гэр бүлийн тусламжийн сангаас гэр бүлийн гишүүд дараах байдлаар нөхөн олговор авах эрх үүснэ.

1. Нас барах үед, хохирогчийн олсон орлогоор амьдралаа залгуулж байсан эхнэр, нөхөр (хамтран амьдрагч) болон хохирогчийн үр удам;

2. Хохирогчийн нас барах үед түүний орлогоор амьдралаа залгуулж байсан эцэг эх, ач, зээ, өвөө, эмээ, ах, эгч нар;

3. 1, 2 -р зүйлд хамаарахгүй хохирогчийн үр удам болох эцэг эх, ач зээ, өвөө эмээ, ах эгч нар

(2) (1) дэх хэсэгт зааснаар гэр бүлээ алдсан гэр бүлийн хамрах хүрээг тогтоохдоо мөн гэдсэнд бүрэлдэж буй үр хөврөлийг хохирогчийг нас барах үед аль хэдийн төрсөн гэж үзэх бөгөөд сангаас хохирлоо барагдуулах эрхтэй.

(3) Нас барсан хохирогчийн гэр бүлийн тусламжийн сангаас нөхөн олговрыг хүлээн авах боломжтой гэж үзэж буй гэр бүлийн гишүүдийн авах дарааллыг (1) хэсгийн дэд зүйл тус бүрт жагсаасан бөгөөд 2, 3 -р зүйлд тусгагдсаны дагуу дарааллыг оруулж, дээрхи байдлаас жагсаасан тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэх ёстой. Үрчилж авсан эцэг эх нь биологийн эцэг эхээс дээгүүрт тавигдах ёстой.

(4) Хэрэв нас барсан хохирогчийн гэр бүлийн гишүүн дараах нөхцөлийг хангавал түүнийг гэр бүлийн тусламжийн санд хамрагдах эрхгүй хүн гэж үзнэ.

1. Хохирогчийг санаатайгаар үхэлд хүргэхэд нөлөөлсөн бол;

19 дүгээр зүйл (Тусламжийн сангаас дараах тохиолдолд нөхөн олговор авах эрхгүй байх боломжтой)

(1) Гэмт хэрэг үйлдэх үед хохирогч болон гэмт этгээдийн хооронд дараах гэр бүлийн харилцааны аль нэг нь байгаа бол тусламжийн сангаас нөхөн олговор олгоно.

102 Crime Victim protection act. [https://elaw.klri.re.kr/eng\\_mobile/viewer.do?hseq=42631&type=part&key=7](https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=42631&type=part&key=7)

|  |
|--|
| <p>1. Эхнэр / нөхөр (гэрлэлтийн бодит харилцаанд орсон хүнийг оруулаад);</p> <p>2. Цусан төрлийн удам угсаанд хамаарах хүмүүс;</p> <p>3. Удам угсааны дөрөвдүгээр зэрэглэлийн хамаатан садан;</p> <p>4. Хамт амьдардаг хамаатан садан.</p> <p>(2) Гэмт хэрэг хийгдсэн цаг хугацаанд хохирогч болон гэмт этгээдийн хооронд дээрхи 1 хэсэгт заасан харилцаа холбоо байхгүй тохиолдолд нөхөн олговрын мөнгийг олгохгүй.</p> <p>(3) Хохирогч дараах гэмт хэргийн аль нэгийг үйлдсэн тохиолдолд тусламжийн сангаас мөнгө олгохгүй.</p> <p>1. Холбогдох эрүүгийн гэмт хэрэгт хянан шалгагдаж байгаа;</p> <p>2. Хүчирхийлэл, заналхийлэл, ноцтой халдлага үйлдэх гэж оролдсон зэрэг холбогдох гэмт хэргийн шинж чанартай үйлдэл хийсэн бол;</p> <p>3. Эрүүгийн хэрэгтэй холбогдох аливаа шударга бус үйлдлийг хийсэн бол;</p> <p>4. Эрүүгийн шинж чанартай холбогдох үйл явдлыг зохих байгууллагад мэдэгдээгүй өнгөрсөн бол;</p> <p>5. Хууль бус үйлдэл хийх магадлалтай байгууллагад элсэн орсон бол (Тухайн байгууллагад элссэн нь холбогдох гэмт хэргийн хохирогч болохтой холбоогүй гэж үзвэл энэ нь хамаарахгүй);</p> <p>6. Хохирогч нь гэмт хэрэг үйлдсэний хариуд гэмт этгээдрүү болон түүний хамаатан садан, гэмт этгээдтэй холбоотой ойр дотны бусад этгээдүүдрүү бие махбодид нь хүнд гэмтэл учруулах үйлдэл хийсэн эсхүл аминд нь хүрсэн бол;</p> <p>(4) Хохирогч дараах үйлдлийн аль нэгийг хийсэн тохиолдолд тусламжийн сангийн хэсэгчилсэн төлбөр олгогдохгүй.</p> <p>1. Хүчирхийлэл, заналхийлэл, үл тоомсорлох зэрэг холбогдох гэмт үйлдлийг үүсгэсэн үйлдэл;</p> <p>2. Холбогдох гэмт хэргийн гэмтэл учруулах, хүндрүүлэхэд нөлөөлсөн анхаарал болгоомжгүй, зохисгүй үйлдэл.</p> <p>5) Нас барсан гэр бүлийн тусламжийн сангаас нөхөн олговор олгохдоо (1) (4) дэх хэсгийн заалтуудыг хэрэгжүүлэхдээ нөхөн олговор олгох нэн тэргүүний ач холбогдол бүхий гэр бүлийн гишүүн гэж үзнэ.</p> <p>(6) Тусламжийн сангийн төлбөрийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нийгмийн халамжийн хэм хэмжээг зөрчсөн гэж үзвэл, хөнгөлөлт эдэлж буй хохирогч, түүний гэр бүл, тэжээгчээ алдсан гэр бүл, хүчирхийлэгч хоёрын хоорондын харилцаа, бусад нөхцөл байдлыг харгалзан үзвэл нөхөн олговрын хэсэгчлэн төлж болно. 20 дугаар зүйл (Бусад дүрмийн дагуу тэтгэмжтэй холбоотой харилцаа гэх мэт) Өөр бусад хуулиар холбогдох нөхөн олговрыг аль хэдийн авсан бол сангаас дахин нөхөн олговор олгохгүй.</p> <p>21 дүгээр зүйл (Хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой харилцаа)</p> <p>(1) Хөнгөлөлт үзүүлэх ёстой хохирогч эсвэл түүний гэр бүлээс гарсан гэр бүл хохирол учирсантай холбогдуулан гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлбөрийг авсан бол төр хүлээн авсан мөнгөн дүнгийн хүрээнд тусламжийн сангийн мөнгийг төлөхгүй. түүний/түүний дагуу.</p> <p>(2) Тус улс төлсөн тусламжийн сангийн хэмжээгээр хөнгөлөлт эдэлж болзошгүй гэмт хэргийн улмаас холбогдох тусламжийн санг хүлээн авсан этгээдэд байгаа хохирлын нөхөн төлбөрийг нэхэмжлэх эрхийг давуу эрхтэйгээр хэрэгжүүлнэ.</p> <p>(3) (2) дахь хэсэгт заасан хохирлыг нөхөн төлүүлэхийг шаардах эрхээ эдлэх үедээ төр нь Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон дагуу хохирлыг хөдөлмөрийн урамшууллын сангаас, эсвэл хоригдлуудын ажлийн цалингийн сангаас олговрыг олгох боломжтой.</p> <p>22 дугаар зүйл (Сангийн хэмжээ)</p> <p>(1) Тэжээгчээ алдсан сангаас нөхөн олговрын хэмжээг тооцохдоо Ерөнхийлөгчийн тогтоолыг дагуу хохирогчийн ар гэрийн амьжиргааны нөхцөл, гэр бүлийн гишүүдийн тоо, насны ангилал зэргийг харгалзан, нас барсан хохирогчийн сарын цалин, сарын дундаж орлогыг нас барсан өдрөөс хойш дор хаяж 24 сараас 48 сараар үржүүлэн нөхөн олговрын хэмжээг тооцно.</p> <p>(2) Тахир дутуу, хүнд бэртлийн сангаас олгох нөхөн олговрын хэмжээг тогтоохдоо Ерөнхийлөгчийн тогтоолыг дагуу хохирогчийн гэмтлийн зэрэг, ар гэрийн амьжиргааны нөхцөл, гэр бүлийн гишүүдийн тоо, насны ангилал зэргийг харгалзан, гэмтсэн хохирогчийн сарын цалин, сарын дундаж орлогыг гэмтэл авсан өдрөөс хойш дор хаяж 2 сараас хамгийн ихдээ 48 сараар үржүүлэн тооцно. &lt;2014 оны 12 -р сарын 30 -ны өдрийн 12883 тоот хуулиар нэмэлт өөрчлөлт оруулсан&gt;</p> <p>(3) (1) эсвэл (2) дахь хэсэгт заасан сарын цалин, сарын бодит орлого, сарын дундаж цалингийн хэмжээг тогтоохдоо хохирогчийн оршин суугаа газрын харьяалал, эсвэл хохирогчийн ажилладаг байгууллагын дарга, болон татварын албаны даргаас өгсөн тодорхойлолтод үндэслэн баталгаажуулна.</p> <p>(4) Хөнгөлөлт эдлэх хохирогчийн сарын цалин хөлс, сарын бодит орлогын хэмжээ нь дундаж цалингийн хэмжээнээс хоёр дахин их байвал (1) эсвэл (2) дахь заалтыг ашиглахдаа дундаж цалингийн хоёр дахин их хэмжээтэй тэнцэх хэмжээний мөнгийг тооцно. сарын цалин эсвэл сарын бодит орлого гэж үзнэ.</p> <p>23 дугаар зүйл (Гадаадын иргэдэд үзүүлэх тусламж)</p> <p>Хэрэв гадаадын иргэн хохирогчийн гэр бүлийн гишүүн бол холбогдох улстай эрх зүйн туслалцааны гэрээ байгуулсан тохиолдолд энэхүү хууль үйлчилнэ.</p> |
|--|

24 дүгээр зүйл (Эрүүгийн гэмт хэргээс улмаас учирсан хохирлыг арилгах зөвлөл)  
(1) Нөхөн олговрыг төлөхтэй холбоотой асуудлыг хэлэлцэх, шийдвэрлэхийн тулд дүүргийн прокурорын газар бүрийн дэргэд Эрүүгийн гэмт хэргээс учирсан хохирлыг арилгах зөвлөл (цаашид “дүүргийн зөвлөл” гэх), мөн Тусламж үзүүлэх зөвлөлийг Хууль зүйн яамны хяналтан дор тус тус байгуулна.  
(2) Дүүргийн прокурорын газрын харьяа бүхий Дүүргийн зөвлөл нь нөхөн олговрын мөнгийг төлөхтэй холбоотой асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.  
(3) Ерөнхий Зөвлөл нь дараах зүйлсийг хэлэлцэн шийдвэрлэнэ.  
1. 27 дугаар зүйлд заасны дагуу өргөдөлтэй холбоотой дахин хэлэлцүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд;  
2. Хууль тогтоомжид заасан бусад асуудал.  
(4) Дүүргийн зөвлөл, болон Ерөнхий зөвлөлүүдийг Хууль зүйн сайд удирдан чиглүүлж, хяналт тавина.  
(5) Эрүүгийн хуулийн 127 дугаар зүйл, 129-132 дугаар зүйлийн заалтыг хэрэгжүүлэхдээ Дүүргийн зөвлөл, Ерөнхий зөвлөлийн гишүүдийн нэгийг төрийн албан хаагч байх ёстой. <2017 оны 3 -р сарын 14 ны өдрийн 14583 тоот хуулиар шинээр оруулсан >  
(6) Дүүргийн зөвлөл, Ерөнхий зөвлөлийн бүтэц, үйл ажиллагаа гэх мэт асуудлыг Ерөнхийлөгчийн зарлигаар тогтооно. <2017 оны 3 -р сарын 14, 14583 тоот хуулиар нэмэлт өөрчлөлт оруулсан>

## Хавсралт 2

4 дүгээр зүйл (Сан байгуулах)<sup>103</sup>  
(1) Сан нь дараах санхүүжилтээс бүрдэнэ.  
1. (2) дахь хэсэгт заасны дагуу авсан торгууль;  
2. Эрүүгийн хохирогчийг хамгаалах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу олж авсан нөхөн төлбөр;  
3. Засгийн газраас бусад хүмүүсийн оруулсан, хандивласан мөнгө, эд зүйл болон бусад эд хөрөнгө;  
(2) Засгийн газар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 477 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан торгуулийг Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон хэмжээгээр дор хаяж 6/100 -аар үржүүлж тооцсон дүнг төлнө.  
(3) Бусад хүн (1) 3 -т заасны дагуу бэлэн мөнгийг санд хандивлах боломжтой.  
5 дугаар зүйл (Сангийн удирдлага ба үйл ажиллагаа)  
(1) Тус сангийн үйл ажиллагааг Хууль зүйн сайд удирдаж явуулна.  
(2) Сангийн удирдлага, үйл ажиллагаанд шаардлагатай бусад асуудлыг Ерөнхийлөгчийн зарлигаар тогтооно.  
6 дугаар зүйл (Сангийн ашиглалт)  
Сангийн хөрөнгийг дараах зорилгоор ашиглана.  
1. Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн хохирлыг арилгахаар сангаас мөнгө олгохоор заасан;  
2. Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн дагуу олгохоор заасан;  
3. Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдсан бусад хүчин төгөлдөр хуулийн хүрээний гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах, дэмжихтэй холбоотой бусад үйл ажиллагаа;  
4. Сан бүрдүүлэх, удирдах, үйл ажиллагааны зардлыг олгох;  
5. Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, дэмжих зорилгоор Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон бусад бизнес, үйл ажиллагаа.  
7 дугаар зүйл (Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах санг ажиллуулах зөвлөлдөх хороо)  
(1) Хууль зүйн яаманд гэмт хэргийн хохирогчийг хамгаалах сангийн үйл ажиллагааны зөвлөлийг (цаашид «Зөвлөлдөх хороо» гэх) байгуулан Сангийн удирдлага, үйл ажиллагаатай холбоотой асуудлаар зөвлөлдөнө.  
1. Сангийн удирдлага, үйл ажиллагааны үндсэн бодлого;  
2. Үндэсний санхүүгийн тухай хуулийн 66 дугаар зүйлд заасны дагуу сангийн үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг байгуулах;  
3. Үндэсний санхүүгийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Сангийн үндсэн ангиллын зардлын хэмжээг өөрчлөх;

103 БНСУ-ын Гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах сангийн тухай хууль, Crime Victim Protection Fund Act

|   |
|---|
| <p>4. Үндэсний санхүүгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Сангийн үйл ажиллагааны тайлан, мөн хуулийн 73 дугаар зүйлд заасны дагуу Сангийн дансыг хаах тухай тайлан гаргах;</p> <p>5. Хөрөнгийн менежментийг бий болгох, өөрчлөх;</p> <p>6. Ерөнхийлөгчийн зарлигаар тус сангийн удирдлага, үйл ажиллагааны талаар заасан чухал асуудлууд болон Зөвлөлдөх хорооны дарга шаардлагатай гэж үзвэл хэлэлцүүлэхээр танилцуулсан бусад асуудлууд.</p> <p>(2) Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, дэмжих чиглэлээр бизнес эрхэлдэг Хууль зүйн яам, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам, Хүйсийн тэгш эрх, гэр бүлийн яам, Стратеги, Сангийн яам гэх мэт олон нийтийн албан тушаалтнуудыг гишүүнээр томилно. Зөвлөлдөх хороо: Зөвлөлдөх хорооны гишүүдийн 1/2 хэсгийн төрийн албан хаагчдаас бусад хүмүүсээс бүрдэх ёстой.</p> <p>(3) Зөвлөлдөх хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа болон бусад шаардлагатай асуудлыг Ерөнхийлөгчийн зарлигаар тогтооно.</p> <p>8 дугаар зүйл (Сангийн данс нээх)<br/>Хууль зүйн сайд нь Сангийн орлого, зарлагыг тодорхой байлгах үүднээс Солонгосын банкинд Сангийн данс үүсгэн байгуулна.</p> <p>9 дүгээр зүйл (Сангийн нягтлан бодох бүртгэлийн ажилтан)<br/>Хууль зүйн сайд нь өөрийн харьяа төрийн албан тушаалтнуудаас сангийн орлого хураагч, сангийн санхүүч, сангийн төлбөр хариуцагч, сангийн кассчинг томилно.</p> <p>10 дугаар зүйл (Санхүүгийн санхүүгийн жил)<br/>Сангийн санхүүгийн жил нь Засгийн газрын санхүүгийн жилтэй давхцана.</p> <p>11 дүгээр зүйл (Сангийн бүртгэл)<br/>Сангийн нягтлан бодох бүртгэлийг бизнесийн нягтлан бодох бүртгэлийн зарчмын дагуу удирдана</p> <p>12 дугаар зүйл (Сангаас түр зээл авах)<br/>Сангийн үйл ажиллагаанд шаардлагатай тохиолдолд Хууль зүйн сайд Сангийн зардлаар Солонгосын банк болон бусад санхүүгийн байгууллагаас түр хугацаагаар мөнгө зээлж болно.</p> <p>13 дугаар зүйл (Ашиг, алдагдлын менежмент)<br/>(1) Сангийн хаалтын үед илүүдэл мөнгө үлдсэн бол бүх ашгийг хуримтлуулах ёстой.<br/>(2) Сангийн үйл ажиллагааг хаах үед алдагдал гарсан тохиолдолд (1) дэх хэсэгт заасан нөөцийг дутагдлаа нөхөх бөгөөд хэрэв ийм нөөц хангалтгүй бол Засгийн газар төсвийн дутагдлаар нөхөж болно.</p> <p>14 дүгээр зүйл.<br/>(1) 6 дугаар зүйлд заасны дагуу авах татаасыг өөр зориулалтаар ашиглахгүй.<br/>(2) Сангийн үйл ажиллагааг залилан мэхлэх болон бусад залилан мэхлэх замаар татаас авсан, эсвэл татаас авсан санг зориулалтаасаа өөр зориулалтаар ашигласан бол Хууль зүйн сайдын зүгээс Сангийн бүх хэсгийг эсвэл зарим хэсгийг буцааж өгч болно.</p> <p>15 дугаар зүйл (Хяналт)<br/>Хууль зүйн сайд шаардлагатай гэж үзвэл Сангаас санхүүгийн эх үүсвэр авч буй хүний хөрөнгө оруулгын мэдээлэл өгөхийг шаардах, тайлагнах тухай хүсэлт гаргаж болно.<br/>Сангийн сангаас санхүүгийн эх үүсвэр авсан аливаа хүн 6-р зүйлд заасан зүйлийг залилан мэхлэх замаар олж авсан бол таван жилээс хэтрүүлэхгүй хорих эсвэл 20 сая воноос хэтрэхгүй торгууль ногдуулна.</p> <p>17 дугаар зүйл (Хамтарсан торгуулийн заалт)<br/>Хэрэв хуулийн этгээд төлөөлөгч, эсхүл агент, ажилтан, хувь хүн нь 16 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн бол тухайн гэмт хэрэгтэнд хариуцлага тооцохоос гадна тухайн хуулийн этгээдэд эсвэл хувь хүнд мөн зохих үндэслэлийн дагуу торгууль ногдуулна: Хэрэв ийм гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд холбогдох үүрэгт зохих ёсоор анхаарал тавьж, хяналт тавиагүй тохиолдолд дээр дурдсан зүйл үйлчлэхгүй.<br/>“Гэмт хэргийн хохирогчийг дэмжих байгууллага” гэсэн нэр томъёо нь гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, дэмжлэг үзүүлэх үндсэн зорилготой ашгийн бус байгууллагыг хэлнэ;</p> |
|---|

## НОМ ЗҮЙ

### Олон улсын гэрээ:

1. Хүний эрхийн түгээмэл тунхаглал. 1946 он;
2. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт. 1966 он;
3. Эрх мэдлээ урвуулан ашигласан болон гэмт хэргийн хохирогчдын талаарх үндсэн зарчмын тухай тунхаглал. 1985 он;
4. Гэмт хэрэг, хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах үндсэн зарчим. 2005 он;
5. Олон улсын хүний эрхийн эрх зүйн их хэмжээний зөрчил, хүмүүнлэгийн эрх зүйн ноцтой зөрчлийн улмаас хохирсон этгээдийн хохирлоо нөхөн төлүүлэх эрхийн талаарх үндсэн зарчмууд. 2005 он

### Хууль, тогтоомж:

1. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992 он;
2. Иргэний хууль. УБ., 2002 он;
3. Эрүүгийн хууль. УБ., 2019 он;
4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ., 2019 он;
5. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. УБ., 2002 он;
6. Улсын Дээд шүүхийн тогтоол, дугаар 15, “Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах талаарх эрүүгийн байцаан шийтгэх болон иргэний хуулийн зарим зүйл, заалтыг эрүү, иргэний шүүн таслах ажиллагаанд хэрэглэх тухай”. УБ., 2009 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн;
7. Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай хууль. УБ., 2007 он;
8. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчлийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хууль. УБ., 1997 он;

### Ном, өгүүлэл, нийтэл, диссертаци:

1. Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал: Нийтлэг үндэслэл, Хүний эрх, шүүх эрх мэдэл, Нутгийн удирдлага. УБ., 2017 он;
2. Нээлттэй нийгэм форум. 2021. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дөчин тавдугаар бүлгийн хэрэгжилт - судалгааны тайлан
3. Нээлттэй нийгэм форум. (2021). Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дөчин тавдугаар бүлгийн хэрэгжилт. Судалгааны тайлан. ISBN: 978-9919-9742-7-5.
4. Нээлттэй нийгэм форум. (2021). Монгол Улсад гэмт хэргийн хохирлыг үнэлж, тогтоож, нөхөн төлүүлж буй нөхцөл байдал.
5. Нээлттэй нийгэм форум. (2020) Хохирлын үндэсний тогтолцоо: Монгол улсад гэмт хэргийн хохирлыг үнэлж, тогтоож, нөхөн төлүүлж буй нөхцөл байдал.
6. Нээлттэй нийгэм форум. (2019). Гэрч, хохирогчийн хамгаалалт бодлогын судалгааны тайлан. ISBN 978-99978-803-9-0
7. ХЗҮХ. 2018. Төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлээс учирсан гэм хорыг арилгаж байгаа байдал,



8. Үндэсний статистикийн хороо. (2014). Гэмт хэргийн хохирогчийн өнөөгийн байдалд хийсэн баримтын судалгаа. [https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Victimization\\_survey.pdf&ln=Mn](https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Victimization_survey.pdf&ln=Mn)
9. Б. Батболд. 2020. Гэмт хэргийн улмаас иргэний амь нас, эрүүл мэндэд учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулах талаарх үзэл баримтлал. Хууль дээдлэх ёс. №3
10. Б.Буянхишиг. Эрх зүйт төрийн зарчим нь төрийн хариуцлагын тогтолцоог сайжруулах, хөгжүүлэх үндэс болох тухай.
11. Ч. Нямсүрэн. Гэмт хэргийн виктимологи /хохирогч судлал/. Анхны хэвлэл. Уб., 2005-457-458 тал.
12. Иргэний хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл. Уб., 2002. №7.
13. Гэрч хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр
14. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2019. №48
15. Монгол Улсын Сангийн яам (2018) “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан”- гийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүнгийн талаар. <https://mof.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/>
16. Хууль зүйн үндэсний хүрээлэн “Гэмт хэргийн улмаас учирсан хохирол”. 2007 он
17. Хүний эрхийн үндэсний комисс (2018) Хохирол нөхөн төлүүлэх эрхийн хэрэгжилтийн зарим асуудал» сэдвээр өглөөний уулзалт зохион байгууллаа. <https://nhrcm.gov.mn/>
18. НҮБ-ын хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө. <http://www.mfa.gov.mn/old/wp-content/uploads/>
19. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын хэрэгжилтийн талаарх монгол улсын ээлжит зургаа дахь тайлан. /2015 он/
20. Монгол Улсын Сангийн яам (2018) “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан”-гийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүнгийн талаар. <https://mof.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/>
21. Хүний эрхийн үндэсний комисс (2018) Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 17 дахь илтгэл <https://nhrcm.gov.mn/%D0%BC%D1%8D%D0%B4%D1%8D%D1%8D/%D0%B8%D0%BB%D1%82%D0%B3%D1%8D%D0%BB/>

**Гадаад хэл дээрх ном, өгүүлэл, нийтлэл, цахим эх сурвалжууд:**

1. Miers, D., 2014. Offender and state compensation for victims of crime: Two decades of development and change. *International Review of Victimology*, 20(1), pp.145-168.
2. HALDANE, J., & HARVEY, A. (1995). The Philosophy of State Compensation. *Journal of Applied Philosophy*, 12(3), 273-282. <http://www.jstor.org/stable/24354130>
3. ITO Fujie & ISHII-TAKIGUCHI Ryoko. 2020 The Current Status and Issues in Crime Victim Support in Japan [http://www.sophia-humans.jp/department/socialservices\\_bulletin/pdf/2020\\_06.pdf](http://www.sophia-humans.jp/department/socialservices_bulletin/pdf/2020_06.pdf)
4. Cho, k. s. (2007). the current situation and challenges of measures for victims

- of crime in the korean criminal justice system. history and development of measuresfor victims of crime (ch 1). routledge.
5. Cho, k. s. (2007). the current situation and challenges of measures for victims of crime in the korean criminal justice system. history and development of measuresfor victims of crime (ch 1). routledge.
  6. Council directive 2004/80/ec of 29 april 2004 relating to compensation to crime victims,
  7. Europeanunion,[https://ejustice.europa.eu/content\\_if\\_my\\_claim\\_is\\_to\\_be\\_considered\\_in\\_this\\_country-491-en.do?clang=en](https://ejustice.europa.eu/content_if_my_claim_is_to_be_considered_in_this_country-491-en.do?clang=en); <https://eur-lex.europa.eu/legal-content/en/txt/pdf/?uri=celex:32004l0080&from=de>
  8. Дьнкел, f. (1985). victim compensation and offender restitution in the federal republic of germany-a western-european comparative perspective. international journal of comparative and applied criminal justice, 9(1-2), 29-39. <https://doi.org/10.1080/01924036.1985.9688805>
  9. Matsuzawa, s. (2020). protection of victims of crime-the case of japan. the right to human dignity, 349.
  10. F.F.Blachly & M.E.Oatman, Approaches to Governmental Liability in Tort: A Comparative Survey, 9 Law and Contemporary Problems 181-213 (Spring 1942).
  11. Burns, P. (1983). A comparative overview of the criminal injuries compensation schemes.Victimology, 8(3-4), 102–110.Google Scholar
  12. Council of Europe (1978). Compensation of victims of crime. Strasbourg: Publications Section.Google Scholar
  13. Geis, G. (1976). Crime victims and victim compensation programs. In W.F. McDonald (Ed.),Criminal justice and the victims(pp. 237–256). Beverly Hills, CA: Sage.Google Scholar
  14. On the Korean justice system, See [www.moj.go.kr/HP/ENG/eng\\_02/eng\\_2040.jsp](http://www.moj.go.kr/HP/ENG/eng_02/eng_2040.jsp) ; UNAFEI(1995), Criminal Justice Profiles of Asia-Investigation, Prosecution, And Trial .
  15. On the Korean justice system, See [www.moj.go.kr/HP/ENG/eng\\_02/eng\\_2040.jsp](http://www.moj.go.kr/HP/ENG/eng_02/eng_2040.jsp) ;
  16. UNAFEI(1995), Criminal Justice Profiles of Asia-Investigation, Prosecution, And Trial .
  17. [http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail\\_main?re=&vm=02&id=2980](http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail_main?re=&vm=02&id=2980)
  18. <https://www.npa.go.jp/hanzaihigai/whitepaper/english/2019/pdf/chapter1.pdf>
  19. [http://www.buzznews.mn/news/156/single/22277?fbclid=IwAR25oouf0C6uJR0Ck5uD1nHnneKujRMx2ZjJjmatelyP0yW31VdUdA0n\\_xc](http://www.buzznews.mn/news/156/single/22277?fbclid=IwAR25oouf0C6uJR0Ck5uD1nHnneKujRMx2ZjJjmatelyP0yW31VdUdA0n_xc)
  20. [https://ec.europa.eu/info/policies/justice-and-fundamental-rights/criminal-justice/protecting-victims-rights/right-compensation\\_en](https://ec.europa.eu/info/policies/justice-and-fundamental-rights/criminal-justice/protecting-victims-rights/right-compensation_en)
  21. [https://www.apav.pt/ivor/images/ivor/PDFs/Fact\\_sheet\\_germany.pdf](https://www.apav.pt/ivor/images/ivor/PDFs/Fact_sheet_germany.pdf)
  22. [https://www.gesetze-im-internet.de/englisch\\_gg/](https://www.gesetze-im-internet.de/englisch_gg/),
  23. <https://www.lwl-soziales-entschaedigungsrecht.de/de/antrag-stellen/>
  24. [https://www.gesetze-im-internet.de/englisch\\_oeg/englisch\\_oeg.html](https://www.gesetze-im-internet.de/englisch_oeg/englisch_oeg.html),
  25. [https://www.apav.pt/ivor/images/ivor/PDFs/Fact\\_sheet\\_germany.pdf](https://www.apav.pt/ivor/images/ivor/PDFs/Fact_sheet_germany.pdf)

26. <https://weisser-ring.de/english>
27. <https://www.odabs.org/en/finanzielle-entschaedigung/compensation-via-the-crime-victims-compensation-act.html>
28. <https://www.kok-gegen-menschenhandel.de/en/human-trafficking/legal-framework-in-germany/crime-victims-compensation-act>
29. <https://www.bmas.de/EN/Social-Affairs/Socialcompensation-law/Socialcompensation-law-art.html>
30. <https://www.government.se/government-agencies/crime-victim-compensation-and-support-authority/>
31. <https://referatsamling.brottsoffermyndigheten.se/ersattning-for-sveda-och-vark/ersattning-for-sveda-och-vark-pa-grund-av-nara-anhorigs-dod-eller-svara-skada/>
32. [https://lovdata.no/dokument/NL/lov/1969-06-13-26/KAPITTEL\\_3#%C2%A73-2a](https://lovdata.no/dokument/NL/lov/1969-06-13-26/KAPITTEL_3#%C2%A73-2a)
33. <https://www.ssb.no/en/sosiale-forhold-og-kriminalitet/kriminalitet-og-rettsvesen/statistikk/anmeldte-lovbrudd-ogofre>
34. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. 1212.mn
35. Гэмт хэргийн хохирогчдын сангийн тухай хууль (1994: 419), [https://www.riksdagen.se/sv/dokument-lagar/dokument/svensk-forfattningssamling/lag-1994419-om-brottsofferfond\\_sfs-1994-419](https://www.riksdagen.se/sv/dokument-lagar/dokument/svensk-forfattningssamling/lag-1994419-om-brottsofferfond_sfs-1994-419), (Сүүлд үзсэн: 2021.08.31)
36. 2021-2023 оны Бүгд Найрамдах Казахстан Улсын төсвийн тухай” хууль, [https://online.zakon.kz/Document/?doc\\_id=32245090#pos=53;-54](https://online.zakon.kz/Document/?doc_id=32245090#pos=53;-54), (Сүүлд үзсэн: 2021.08.25)
37. Казахстан Улсын Эрүүгийн процессын тухай хууль, [https://online.zakon.kz/Document/?doc\\_id=31575852#pos=90;-54](https://online.zakon.kz/Document/?doc_id=31575852#pos=90;-54), (Сүүлд үзсэн: 2021.08.26)
38. Казахстан Улсын Эрүүгийн хууль, [https://online.zakon.kz/Document/?doc\\_id=31575252&doc\\_id2=31575252#pos=114;-110&pos2=1619;-62](https://online.zakon.kz/Document/?doc_id=31575252&doc_id2=31575252#pos=114;-110&pos2=1619;-62), (Сүүлд үзсэн: 2021.08.26)
39. Crime Victim protection act. [https://elaw.klri.re.kr/eng\\_mobile/viewer.do?hseq=42631&type=part&key=7](https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=42631&type=part&key=7)
40. Gesetz über die Entschädigung für Strafverfolgungsmaßnahmen (StrEG) <https://www.gesetze-im-internet.de/streg/BJNR001570971.html>
41. Victim compensation and assistant act.
42. Basic Law for the Federal Republic of Germany
43. Crime Victims Compensation Act – OEG

